



Үндэсний аудитын газар

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МОНГОЛ УЛСЫН УРТ, ДУНД ХУГАЦААНЫ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУССАН
ЗОРИЛТЫГ БҮРЭН ХАНГУУЛАХ, ЦАХИМЖИЛТ, ИЛ ТОД БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ
ШААРДЛАГА БАЙНА

АУДИТЫН СЭДЭВ: ТӨРИЙН ӨМЧИТ УУЛ УУРХАЙН КОМПАНИУДЫН
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ СИСТЕМИЙН АШИГЛАЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ТЧУАГ-2025/16/ШТА-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх
аудитор Д.Баярсайхан

Утас: 263813 Цахим хаяг: bayarsaikhand@audit.gov.mn

Аудитын менежер Д.Очирсүрэн
Утас: 263813 Цахим хаяг: ochirsurend@audit.gov.mn

Мэдээлэл, технологийн төвийн дарга Б.Сэр-Од
Утас: Цахим хаяг: Ser-Odb@audit.gov.mn

Ахлах аудитор С.Одонцэцэг
Х.Ган-Очир

Аудитор Д.Эрдэнэчимэг
З.Төмөрбаатар

Шинжээч Б.Лхагвасүрэн
Б.Мягмаржав

Улаанбаатар хот
2025 он



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2025 оны 12 сарын 12 өдөр

Дугаар А/151

Улаанбаатар хот

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.3, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Төрийн өмчит уул уурхайн компаниудын худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Төрийн худалдан авах ажиллагааны газар, "Эрдэнэс Монгол" ХХК, "Тавантолгой" ХК-д тус тус хүргүүлэхийг Тусгай чиг үүргийн аудитын газар (Д.Баярсайхан)-т даалгасугай.

3.Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагын мэдээллийг статистик мэдээний бүртгэлд бүртгэж, Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газарт хүргүүлэхийг Тусгай чиг үүргийн аудитын газар (Д.Баярсайхан)-т даалгасугай.

4.Аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт тус тус ирүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар (С.Бямбацогт), Сангийн сайд (Б.Жавхлан) нарт зөвлөсүгэй.

5.Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлага, тогтоосон төлбөрийн актын хэрэгжилтийг хангуулахад хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Монгол Улсын Ерөнхий Аудиторын орлогч (Б.Мөнхдөл), Тусгай чиг үүргийн аудитын газар (Д.Баярсайхан)-т тус тус даалгасугай.

6.Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг Тусгай чиг үүргийн аудитын газар (Д.Баярсайхан)-т үүрэг болгосугай.



С.МАГНАЙСҮРЭН

Z:\Tushaal\2025\EA-In A Tushaal\1212 ASH-HG-5.Docx

1525010048

Монгол Улсын Ерөнхий аудиторын
2025 оны 12 сарын 12 ны өдрийн А/151
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

АГУУЛГА

Хүснэгтийн жагсаалт	3
Графикийн жагсаалт	4
Дүрслэлийн жагсаалт	4
Хавсралтын жагсаалт	4
Аудит хийсэн үндэслэл, зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, хугацаа	5
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	5
Аудитын зорилт, хамарсан хүрээ	5
Аудитын арга зүй	5
Аудитын шалгуур үзүүлэлт	5
Аудитын баг, бүрэлдэхүүн	7
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	8
БҮЛЭГ 1. ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА ТӨРӨӨС БОДЛОГООР ДЭМЖСЭН ТҮВШИНД ХҮРЧ ХӨГЖӨӨГҮЙ, ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ БҮРЭН ХАНГААГҮЙ БАЙНА	12
Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт төрийн худалдан авалтын талаар туссан зорилт бүрэн хангагдаагүй байна	12
Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн дэд бүтцийн тогтвортой байдал бүрэн хангагдаагүй нь системийн найдвартай ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна	14
Аудитаар цахим системийн хэрэглээний түвшнийг судалж, системийн хэрэглээнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох зорилгоор цахим системийн ашиглалт, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг гаргалаа	15
Мэдээллийн аюулгүй байдал болон цахим системийн хөгжүүлэлт, хяналт, ашиглалттай холбоотой мэргэшсэн боловсон хүчний чадавхыг тогтвортой хангах тогтолцоог бүрэн бүрдүүлээгүй байна	16
Цахим системийн хэрэглэгчийн эрхийн удирдлага, нууцлал, хяналт, бүртгэл, олон шатлалт баталгаажуулалт болон системийн дотоод хяналт хангалтгүй байгаа нь мэдээллийн аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж байна	17
ТХААГ цахим системийн ашиглалттай холбоотой холбогдох хууль, журмыг бүрэн мөрдөж ажиллаагүй, тендерийн хураамжийн орлогыг цахим системийн хөгжүүлэлт, мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулахад бүрэн зарцуулаагүй байна	18
БҮЛЭГ 2. ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ СИСТЕМИЙГ АШИГЛАСНААР ЦАХИМЖИЛТ, ИЛ ТОД БАЙДАЛ БҮРЭН ХАНГАГДААГҮЙ БАЙНА	23
Төрийн өмчит уул уурхайн компаниудын засаглалыг тодорхой болгох, дээд шатны байгууллагын хяналтыг сайжруулах замаар санхүүгийн үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх шаардлага байна	23
Цахим системийн ашиглалттай холбоотой холбогдох хууль, журмыг бүрэн мөрдөж ажиллаагүй, систем хооронд уялдаагүй байгаа нь олон нийт үнэн зөв, иж бүрэн, ил тод мэдээллээр бүрэн хангагдахгүй байна	27
ТХААГ, захиалагч талуудын хамтын ажиллагаа, хариуцлагын тогтолцоо дутмаг байгаа нь цахим дэлгүүрийн ашиглалт, ерөнхий гэрээний хэрэгжилт хангалтгүй байхад нөлөөлж байна	30
Цахим системийн үйл ажиллагаа, ашиглалтын байдалд дотоод хяналтын механизм үр дүнгүй байгаагаас худалдан авах ажиллагаанд үүсэх эрсдэлийг тодорхойлох боломжгүй байна	33
Дүгнэлт	35
Зөвлөмж	36
Холбогдох байгууллагын санал:	39

Товчилсон үгсийн тайлал

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУБ	Аудитын дээд байгууллагуудын Олон Улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын стандарт
АХБ	Азийн хөгжлийн банк
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНСАУ	Бүгд Найрамдах Солонгос Ард Улс
ГА	Гүйцэтгэлийн аудит
ЖДҮҮ	Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ОУ	Олон Улс
ТБОНӨХБАҮХАтХууль	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмчит
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
ТХААГ	Төрийн худалдан авах ажиллагааны газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТЧУАГ	Тусгай чиг үүргийн аудитын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УИХ	Улсын Их Хурал
УСННББОУС	Улсын салбарын нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын стандарт
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
ҮХ	Үнэлгээний хороо
ҮТП	Үйлдвэрлэл, технологийн парк
ХА	Харьцуулалтын арга
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШТА	Шууд тайлагнах аудит
ШХА	Шууд худалдан авалт
GEPS	Government E-procurement Promotion System
GPA	Government Procurement Agreement
INTOSAI	International Organization of Supreme Audit Institutions
ISO/IEC	International Organization for Standardization / International Electrotechnical Commission
JTPP	Japan Trade Promotion Portal
KONEPS	Korea New E-Procurement System
MNS	Mongolian National Standard
PKI	Public Key Infrastructure
SIEM	Security Information and Event Management
UX/UI	User Experience / User Interface
WTO	World Trade Organization

Хүснэгтийн жагсаалт

Дугаар	Агуулга	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Төрийн болон орон нутгийн өмчит уул уурхайн компаниудын мэдээлэл	9
Хүснэгт 2	Худалдан авах ажиллагааны цахим системийн мэдээлэл /Улсын хэмжээнд болон 13 компаниар/	10
Хүснэгт 3	Компаниудын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд оруулсан тодотголын мэдээ	24
Хүснэгт 4	Он дамжуулан хэрэгжүүлсэн боловч төлөвлөгөөнд тусгаагүй зохион байгуулсан тендерийн мэдээлэл, сая төгрөг	25
Хүснэгт 5	Худалдан авах ажиллагааны цахим системд гэрээ бүртгэсэн мэдээлэл	28
Хүснэгт 6	Шалгарсан компанитай гэрээ хугацаандаа байгуулаагүй талаарх мэдээлэл	29
Хүснэгт 7	Компаниудын цахим дэлгүүрээс худалдан авсан болон худалдан авах боломжтой байсан бараа, үйлчилгээний мэдээлэл	31
Хүснэгт 8	Компанийн дотоод хяналтын чиг үүрэг бүхий нэгжийн судалгаа	33
Хүснэгт 9	Аудитаар илрүүлсэн алдаа зөрчлийн бүртгэлийн нэгтгэл	34

Графикийн жагсаалт

Дугаар	Агуулга	Хуудасны дугаар
График 1	13 компанийн тендерийг худалдан авах ажиллагааны төрлөөр /2023,2024 он/, тэрбум төгрөг	10
График 2	Судалгаанд хамрагдагсдын систем ашиглалтын байдал	15

Дүрслэлийн жагсаалт

Дугаар	Агуулга	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Цахим системийн үндсэн үйл ажиллагааны үе шатны процессын зураг	8
Дүрслэл 2	Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт туссан зорилтууд	12
Дүрслэл 3	Компаниудын шилэн данс, цахим системд нийтэлсэн ХАА-ны төлөвлөгөөний мэдээлэл	29

Хавсралтын жагсаалт

Дугаар	Агуулга	Хуудасны дугаар
Хавсралт 1	Цахим системийн үндсэн үйл ажиллагааны үе шатны процессын тайлбар	49
Хавсралт 2	13 Компанийн тендер шалгаруулалттай холбоотой гомдлын мэдээлэл	50
Хавсралт 3	13 компанийн 2023-2024 онд төсөвт туссан зарим зардлуудыг ХАА-ны төлөвлөгөөнд туссан эсэхийг тодруулах судалгаа	51
Хавсралт 4	13 компанийн 2023-2024 онд худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс ерөнхий гэрээний аргаар худалдан авсан бараа, үйлчилгээ, сая төгрөг	53
Хавсралт 5	13 компанийн 2023-2024 онд цахим дэлгүүрээс ерөнхий гэрээний аргаар худалдан авах боломжтой бараа, үйлчилгээний түүвэрлэсэн тооцоолол, сая төгрөг	56
Хавсралт 6	Цахим системийн үндсэн үйл ажиллагаанд оролцогчдын үе шатны процессын дэлгэрэнгүй зураглал	58
Хавсралт 7	Ерөнхий гэрээний аргаар тендерийн шалгаруулалт зохион байгуулах процессын зураг /1 дүгээр үе шат/	60
Хавсралт 8	Ерөнхий гэрээний аргаар цахим дэлгүүрээс худалдан авах процессын зураг /2 дугаар үе шат/	61

Аудит хийсэн үндэслэл, зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, хугацаа

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2024 оны 5 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2024 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө”-ний дагуу “Төрийн өмчит уул уурхайн компаниудын худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудит хийлээ.

Аудитын зорилт, хамарсан хүрээ

Төрийн өмчит уул уурхайн компаниудын худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалт, үр дүнд аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулан УИХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэсэн.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийлээ. Үүнд:

- ✓ Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем нь хууль тогтоомжийн шаардлагад нийцэж, бодит хэрэгцээг хангасан эсэх,
- ✓ Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийг ашигласнаар худалдан авалт ил тод, үр дүнтэй болсон эсэх,

Аудитад шалгагдагч төрийн өмчит уул уурхайн 13 компанийн 2023-2024 оны төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалтын байдал, цахим шилжилтийн хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, холбогдох хууль тогтоомж, бодлого, зохицуулалтын хэрэгжилт, мөн хамрагдагч Сангийн яам, Төрийн худалдан авах ажиллагааны газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын холбогдох нэгжийн үйл ажиллагааны тайлан, мэдээ, тоон өгөгдөл бусад нотлох баримт материалд үндэслэн дүн шинжилгээ хийж аудитыг гүйцэтгэв.

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн батлуулсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020, “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлалд заасан арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийж аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын шалгуур үзүүлэлт

Асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан төлөвлөсөн арга зүй, гүйцэтгэлийн аудитын арвилан хэмнэлтэй, үр ашигтай, үр нөлөөтэй байх зарчим болон дараах хууль, эрх зүйн актыг аудитад шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

Бодлогын баримт бичиг:

- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;
- “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”;
- “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”;

Хууль:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Компанийн тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль;
- Кибер аюулгүй байдлын тухай хууль;
- Бусад холбогдох хуулиуд.

Засгийн газрын тогтоол:

- Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам";
- Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчит оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам";
- Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам";
- Засгийн газрын 2007 оны 6 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны хүний нөөцийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр";
- Засгийн газрын 2024 оны 162 дугаар тогтоолоор баталсан "Ерөнхий гэрээний аргаар худалдан авах бараа, үйлчилгээний жагсаалт";
- Засгийн газрын 2012 оны 115 дугаар тогтоолоор баталсан "Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих журам";
- Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар";
- Засгийн газрын 2024 оны 147 дугаар тогтоолоор баталсан "Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм";
- Засгийн газрын 2024 оны 120 дугаар тогтоолоор баталсан "Төрийн нууцад хамаарах худалдан авах ажиллагааг зохицуулах журам";
- Засгийн газрын 2023 оны 108 дугаар тогтоолоор баталсан "Эрдэнэс Монгол" ХХК-ийн дүрэм

Сайдын тушаал:

- Сангийн сайдын 2023 оны "Бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх тендерийн ашиглалтын хугацааны өртөг тооцох аргачлал, заавар" 256 дугаар тушаал;
- Сангийн сайдын 2023 оны А/249 дүгээр тушаалаар баталсан "Бүртгэл хөтлөх, мэдээллийг баталгаажуулах журам" 249 дүгээр тушаал;
- Сангийн сайдын 2024 оны А/118 дугаар тушаалаар баталсан "Нээлттэй тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулах журам";
- Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалаар баталсан "Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам";
- Сангийн сайдын 2023 оны А/255 дугаар тушаалаар баталсан "Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар";
- Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам";
- Сангийн сайдын 2023 оны А/252 дугаар тушаалаар баталсан "Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам";
- Сангийн сайдын 2023 оны А/251 дүгээр тушаалаар баталсан "Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сургалт эрхлэх байгууллага, түүний багш, ажилтанд тавигдах шаардлага, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр, шалгалтын журам";

- Сангийн сайдын 2023 оны А/248 дүгээр тушаалаар баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”;
- Сангийн сайдын 2023 оны А/254 дүгээр тушаалаар баталсан “Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам”;
- Сангийн сайдын 2023 оны А/259 дүгээр тушаалаар баталсан “Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын жишиг барим бичиг-2024”;
- Сангийн сайдын 2023 оны А/258 дугаар тушаалаар баталсан “Бараа худалдан авах тендер шалгаруулалтын жишиг барим бичиг-2024”;
- Сангийн сайдын 2023 оны А/261 дугаар тушаалаар баталсан “Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендер шалгаруулалтын жишиг барим бичиг-2024”, Харьцуулалтын аргаар үйлчилгээ авах тендер шалгаруулалтын жишиг барим бичиг-2024, Харьцуулалтын аргаар ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын жишиг барим бичиг-2024;
- Сангийн сайдын 2023 оны А/257 дугаар тушаалаар баталсан “Гэрээ шууд байгуулах аргаар бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг-2024”;
- Сангийн сайдын 2023 оны А/262 дугаар тушаалаар баталсан “Ерөнхий гэрээний аргаар бараа, үйлчилгээ худалдан авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг-2024”;
- Сангийн сайдын 2023 оны А/260 дугаар тушаалаар баталсан “Үйлчилгээ авах тендер шалгаруулалтын жишиг барим бичиг-2024”;
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд.

Аудитын баг, бүрэлдэхүүн

Аудитыг Үндэсний аудитын газрын Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Баярсайхан удирдаж, аудитын менежер Д.Очирсүрэн үе шатны хяналтыг хэрэгжүүлж, Мэдээлэл, технологийн төвийн дарга Б.Сэр-Од, ахлах аудитор С.Одонцэцэг, Х.Ган-Очир, аудитор Д.Эрдэнэчимэг, З.Төмөрбаатар, Б.Лхагвасүрэн, шинжээч Б.Мягмаржав нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Засгийн газраас төрийн худалдан авах ажиллагааг цахимжуулах бодлогыг 2006 оноос эхлэн шат дараатайгаар хэрэгжүүлж, төрийн болон орон нутгийн төсвийг үр ашигтай захиран зарцуулах, худалдан авах ажиллагааг цахим орчинд нэгдсэн нэг удирдлага, хяналтын дор олон нийтэд хүртээмжтэй, ил тод, нээлттэй зохион байгуулах, түүнд олон нийтийн хяналт тавих мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх зорилгоор 2017 оноос төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ийг /цаашид “**цахим систем**” гэх/ бүх шатны төрийн байгууллагууд ашиглан худалдан авах ажиллагааг зохион байгуулж эхэлсэн байна.

Цахим систем нь худалдан авах ажиллагааны төлөвлөлт, тендер шалгаруулалт зохион байгуулах, гэрээ, гэрээний гүйцэтгэлийг удирдах, тендер шалгаруулалтад оролцох, цахим шалгалтыг зохион байгуулах, ерөнхий гэрээгээр худалдан авах ажиллагааг зохион байгуулах болон төрийн байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулж, нэгдсэн мэдээлэл солилцооны цахим тогтолцоог бий болгох зорилгоор хөгжүүлэгдсэн байна.

ТБОНӨХБАҮХАТХуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.26-д "цахим систем" гэж программ хангамж ашиглан худалдан авах ажиллагааг зохион байгуулах, интернэтэд суурилсан мэдээллийн системийг хэлнэ гэж заасан байна.

Цахим системийн үйл ажиллагааг ТБОНӨХБАҮХАТХууль болон холбогдох бусад хууль, тогтоомжоор зохицуулжээ. Энэхүү зохицуулалтыг тус хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ” гэж хуульчилсан байна.

УИХ-ын 2012 оны 14 дүгээр тогтоол, Засгийн газрын 2012 оны 6 дугаар тогтоолоор Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах мэргэжлийн байгууллага болох Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Худалдан авах ажиллагааны газар байгуулж, хуулиар цахим системийн ашиглалт, үйл ажиллагааг хариуцахаар чиг үүргийг зааж өгсөн байна.

Цахим системийн үндсэн үйл ажиллагааг үе шатаар үзүүлбэл дараах байдалтай байна. /Дэлгэрэнгүй тайлбарыг хавсралтаас 1-ээс үзнэ үү/



Эх сурвалж: Аудитын баг

Цахим системийн үндсэн үйл ажиллагаанд оролцогчдын үе шатны процессын дэлгэрэнгүй зураглалыг хавсралтаас үзнэ үү.

Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.12-т "**стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд**" гэж үндэсний аюулгүй байдал, улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх хэмжээний, эсхүл жилд Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний таван хувиас дээш хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа буюу үйлдвэрлэх боломжтой ордыг" хамруулахаар тодорхойлсон байна.

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахтай холбоотой харилцаанд төрийн төлөөллийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2007 оны 52 дугаар тогтоолоор "Эрдэнэс Монгол" ХХК-ийг үүсгэн байгуулсан бөгөөд компанийн эзэмшилд охин, харьяа 19, хараат 14, нийт 33 компани үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс аудитаар нэгдлийн охин, хараат, харьяа уул уурхайн төрийн өмчит 11 компанийг хамруулсан. Мөн Таван толгойн нүүрсний бүлэг ордын ашигт малтмалын ашиглалтын MV-000287 дугаар тусгай зөвшөөрлийн талбайн хүрээнд нүүрс олборлолтын үйл ажиллагаа явуулдаг, орон нутгийн өмчит Таван толгой ХК-ийг хамруулсан болно.

Хүснэгт 1. Төрийн болон орон нутгийн өмчит уул уурхайн компаниудын мэдээлэл

Д.Д	Компанийн нэр	Толгой, охин, хараат, харьяа эсэх	Төрийн өмчийн оролцооны хувь	Үндсэн үйл ажиллагааны чиглэл
1	Эрдэнэс Монгол ХХК	Толгой компани	100.0	Нэгдлийн бүрэлдэхүүн компаниудыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллах
2	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	Харьяа хуулийн этгээд	100.0	Эрдэнэтийн Овооны Зэс, молибдены ордын хүдрийн олборлолт, боловсруулалт, үйлдвэрлэл
3	Эрдэнэс критикал минералс ТӨҮГ	Харьяа хуулийн этгээд	100.0	Хайлуур жонш, үнэт металл болон бусад төрлийн ашигт малтмалыг олборлох, боловсруулах
4	Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХХК	Охин компани	100.0	Хаягдал төмрийг дахин хайлуулж, ган цувимал бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хүдэр боловсруулах
5	Эрдэнэс оюу толгой ХХК	Охин компани	34.0	"Оюу Толгой" ХХК -ийн төрийн эзэмшлийн 34 хувийн хувьцааг эзэмшиж, "Оюу толгой ордоос Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээний тухай" УИХ, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулах
6	Эрдэнэс алт ресурс ХХК	Охин компани	100.0	Уул уурхайн чиглэлээр зөвлөгөө өгөх, ашигт малтмал эрэх, хайх, олборлох, ашиглах, Салхитын мөнгө-алтны ордыг түшиглэсэн хүдэр олборлох, боловсруулах
7	Эрдэнэс УТП ХХК	Охин компани	100.0	2022 онд баталсан Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу Засгийн газрын 2023 оны 257 дугаар тогтоолоор төрийн өмчит үйлдвэрлэл, технологийн парк байгуулсан
8	Эрдэнэс Тавантолгой ХК	Охин компани	85.2	Тавантолгойн чулуун нүүрсний орд газарт ашиглалтын үйл ажиллагаа явуулах
9	Багануур ХК	Охин компани	75.0	Эрчим хүчний нүүрс олборлох, дотоодын эрчим хүчний нүүрсний хэрэглээний 60 хувийг хангах
10	Шивээ овоо ХК	Охин компани	90.0	Шивээ Овоогийн хүрэн нүүрсний орд газарт ашиглалтын үйл ажиллагаа, нүүрс олборлох
11	Цемент шохой ХХК	Охин компани	100.0	Цемент болон шохойн бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулж байна
12	Эрдэнэс Баянбогд ХХК	Хараат компани	50.0	Ашигт малтмал хайх, ашиглах үйл ажиллагаа явуулах, Баянбогд нүүрсний орд газарт эрчим хүчний нүүрс олборлохоор урьдчилан төлөвлөлт
13	Таван толгой ХК	Орон нутгийн өмчит	51.0	Таван толгойн нүүрсний бүлэг ордын хүрээнд нүүрс олборлолтын үйл ажиллагаа явуулж байна.

Эх сурвалж: Эрдэнэс Монгол ХХК-наас ирүүлсэн тайлан мэдээ, 13 компанийн цахим хуудас

Компаниудын хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь "Эрдэнэс Монгол" нэгдэл бөгөөд Компанийн тухай хууль, компанийн дүрэмд заасны дагуу өөрийн ТУЗ-тэй 5, нэгдлийн ТУЗ-д хамаарах 6, үйл ажиллагаанд оролцохгүй буюу хараат "Эрдэнэс Баянбогд" ХХК тус тус байна.

Улсын хэмжээнд 2023 онд 55,293 тендерийн санал, 7,107 оролцогчийн оролцоо бүртгэгдэж, худалдан авах ажиллагааны төрлөөр бараа 61, ажил 29, үйлчилгээ 10 хувь, журмын хувьд НТШ 50, ХА 49, бусад 1, ШХА 0.1 хувийг тус тус эзэлсэн байна.

Харин 2024 онд дээрх үзүүлэлт өсөж 63,978 тендерийн санал, 7,660 оролцогчийн оролцоо бүртгэгдэж, цахим системийн хандалт 29.0 саяас 32.0 саяд хүрч, цахимаар зарласан тендерийн урилга 26,470-аас 31,331 болж өмнөх оноос нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Улсын хэмжээнд 2023 онд 15,040.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 33,341, 2024 онд 36,764.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 38,997 тендерийг зохион байгуулахаар төлөвлөсөн байгаа нь өмнөх онтой харьцуулахад төсөвт өртөг 144.4 хувь, тендерийн тоо 17.0 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 2. Худалдан авах ажиллагааны цахим системийн мэдээлэл /Улсын хэмжээнд болон 13 компаниар/ тэрбум төгрөг

Он	Улсын хэмжээнд				Үүнээс: Төрийн болон орон нутгийн өмчит уул уурхайн 13 компани				Эзлэх хувь
	Төлөвлөсөн		Зарласан		Төлөвлөсөн		Зарласан		
	тоо	төсөвт өртөг	тоо	төсөвт өртөг	тоо	төсөвт өртөг	тоо	төсөвт өртөг	
2023	33341	15,040.0	13644	11,867.8	4099	7,791.7	2026	6,478.7	51.8
2024	38997	36,764.7	16857	29,506.1	3977	12,741.1	2065	9,140.3	34.7


Эх сурвалж: Цахим систем

Харин 13 компанийн хувьд 2023 онд 7,791.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 4099 /багцтай/ тендер, 2024 онд 12,741.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 3977 /багцтай/ тендер төлөвлөсөн нь өмнөх онтой харьцуулахад төсөвт өртөг 61.2 хувиар өссөн хэдий ч тендерийн тоо 3 хувиар буурсан, нийт улсын хэмжээтэй харьцуулахад 2023 онд төсөвт өртгийн 51.8, тендерийн тоо хэмжээний 12.3, 2024 онд төсөвт өртгийн 34.7, тендерийн тоо хэмжээний 10.2 хувийг тус тус эзэлж байна.

Улсын хэмжээний нийт төлөвлөсөн тендерийн тоо хэмжээнээс харьцуулахад 2023 онд 40.9, 2024 онд 43.2, төсөвт өртгөөс харьцуулахад 2023 онд 78.9, 2024 онд 80.3 хувийг тус тус цахим системээр зарласан байна.Үүнээс төрийн өмчит уул уурхайн 13 компанийн хувьд нийт төлөвлөсөн тендерийн тоо хэмжээнээс харьцуулахад 2023 онд 49.4, 2024 онд 51.9, төсөвт өртгөөс харьцуулахад 2023 онд 83.1, 2024 онд 71.7 хувийг тус тус цахим системээр зарласан байна.

13 компанийн төлөвлөж, зарласан тендерийг худалдан авах ажиллагааны төрлөөр үзүүлбэл дараах байдалтай байна.

График 1. 13 компанийн тендерийг худалдан авах ажиллагааны төрлөөр /2023, 2024 он/, тэрбум төгрөг



Эх сурвалж: Цахим систем, аудитын баг

Дээрх графикаас харахад 2023 онд төлөвлөсөн тендерийн тоогоор бараа 78.6 хувь, ажил 11.4 хувь, зөвлөх үйлчилгээ 5.4 хувь, зөвлөхөөс бусад үйлчилгээ 4.5 хувь, 2024 онд бараа 74.0 хувь, ажил 13.6 хувь, зөвлөх үйлчилгээ 12.3 хувийг тус тус эзэлж байна. Харин 2023 онд зарласан тендерийн тоогоор бараа 81.6 хувь, ажил 11.1 хувь, зөвлөх үйлчилгээ 3.8 хувь, зөвлөхөөс бусад үйлчилгээ 3.3 хувь, 2024 онд бараа 76.9 хувь, ажил 14.5 хувь, зөвлөх үйлчилгээ 8.5 хувийг тус тус эзэлж байна.

13 компанийн хувьд 2023 онд 216.7 тэрбум төгрөг, 2024 онд 305.2 тэрбум төгрөгийн тендерийн хэмнэлт гарсан байна.


ТБОНӨХБАҮХАТХуулийн 56 дугаар зүйлийн 56.9-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтыг хөтөлж, олон нийтэд нээлттэй мэдээлнэ” гэсэн заалтын дагуу цахим системд 106 ААН-ийн мэдээлэл нийтэлсэн байна. Үүнээс илт худал мэдээлэл ирүүлсэн 33 ААН, гэрээний үүргээ биелүүлээгүй 66 ААН, мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасан 4 ААН байна.

БҮЛЭГ 1. ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА ТӨРӨӨС БОДЛОГООР ДЭМЖСЭН ТҮВШИНД ХҮРЧ ХӨГЖӨӨГҮЙ, ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ БҮРЭН ХАНГААГҮЙ БАЙНА

Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт төрийн худалдан авалтын талаар туссан зорилт бүрэн хангагдаагүй байна

1.1. УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор баталсан “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг үндэслэн улс орны хөгжлийг тодорхойлж, чиглүүлж байна. Дээрх урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт төрийн худалдан авалтын талаар дараах зорилтууд туссан байна.

Дүрслэл 2. Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт туссан зорилтууд



Эх сурвалж: Аудитын баг

1.2. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 6.4.6-д “Төрийн худалдан авалтыг ногоон худалдан авалтад үе шаттайгаар шилжүүлж, хувийн хэвшлийг дэмжих тогтолцоог бүрдүүлнэ” гэсэн зорилтыг дэвшүүлсэн байна.

1.3. 2025 онд гүйцэтгэсэн “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар ТХААГ-ын /СЯ хамтран/ хариуцан хэрэгжүүлэхээр тусгагдсан 4.1.7-д “Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжиж, тогтвортой нэмэгдүүлнэ” гэсэн зорилтыг “Тодорхой үр дүнд хүрсэн”, харин 6.4.5-д “Засгийн газрын ногоон худалдан авалтын эзлэх хувийг нэмэгдүүлж, 20 хувьд хүргэнэ” гэсэн зорилтыг “Эрчимжүүлэх шаардлагатай” гэж дүгнэж, хэрэгжилтийг 50.0 хувьтай үнэлсэн байна.

1.4. ТБОНӨХБАҮХАТХуулийн 12 дугаар зүйлийн 12.9-д “Техникийн тодорхойлолтыг хүрээлэн байгаа орчинд ээлтэй хэлбэрээр боловсруулах аргачлал, зааврыг байгаль орчны болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална” гэж заасны дагуу Сангийн сайдын 2023 оны 66 дугаар тогтоолоор “Ногоон худалдан авах ажиллагааны техникийн тодорхойлолт боловсруулах аргачлал”-ыг баталсан боловч хэрэгжилт хангалтгүй байна.

1.5. Дотоодын үйлдвэрээс худалдан авсан бараа, бүтээгдэхүүний хэмжээ нэрлэсэн дүнгээр өсөх хандлагатай боловч нийт худалдан авалтын дүнд эзлэх хувь бага хэвээр байна. Тайлант онд улсын хэмжээнд зарласан худалдан авалтын 6.7 хувь нь дотоодын үйлдвэрлэлээс худалдан авсан бараа бүтээгдэхүүнд ногдсон нь “эх оронч худалдан авалт”-ын бодлого хангалттай хэрэгжихгүй байгааг харуулж байна.

1.6. Дээрх зорилтыг хангах ажлын хүрээнд манай улс дор дурдсан ОУ-ын туршлагыг төрийн худалдан авалтад ашиглах боломж байна. Тухайлбал,

Шигтгээ 1: БНХАУ-ын төрийн худалдан авалтад жижиг дунд бизнес эрхлэгчдийн гүйцэтгэх үүрэг тусгай байр суурийг эзэлж байна. Сүүлийн жилүүдэд Хятадын Засгийн Газар жижиг дунд компаниудын хөгжлийг дэмжихийн тулд төсөв, татвар, мөнгөний бодлогыг шат дараатай хэрэгжүүлж, тухайлсан хууль, журамд ЖДҮҮ эрхлэгчдэд зориулсан төрийн худалдан авалтыг төлөвлөх, давуу эрх олгох, түүнчлэн ялгаавартай байдал үүсэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн бусад арга хэмжээнүүдийг авч байна. Мөн зарчмын хувьд бүх жижиг хэмжээний худалдан авалтыг ЖДҮҮ эрхлэгчдэд зориулах ёстой гэдгийг тогтоож, төрөл бүрийн зээлийн баталгаа гаргах, төрөлжсөн үйлчилгээ үзүүлэхээр тусгажээ. Үүний үр дүнд БНХАУ-ын төрийн худалдан авалтад ЖДҮҮ эрхлэгчтэй байгуулсан гэрээний эзлэх хувь 74.1 хувьд хүрсэн байна. (Эх сурвалж: “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын “Худалдан авах ажиллагаа, түүний үр дүн, гүйцэтгэлд хийсэн судалгаа, дүн шинжилгээний тайлан, 2024 он)

1.7. Дээрх байдлаас үзэхэд ЖДҮҮ эрхлэгч үйлдвэрлэх боломжтой, жил бүр давтамжтай худалдан авдаг бараа, материалын судалгааг хийж, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах боломжийг эрэлхийлж, холбогдох хууль, журамд нарийвчилсан зохицуулалт хийх замаар улс орны, бүс нутгийн нийгэм, эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх боломж байна.

1.8. ТХААГ Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.16-д “Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан эх оронч худалдан авалтыг дэмжиж, тендер шалгаруулалтын үйл ажиллагааг хиймэл оюун ухаан, сүүлийн үеийн дэвшилтэт технологид тулгуурлан хүний оролцоог багасгана” гэсэн зорилтын хүрээнд худалдан авах ажиллагааг хялбаршуулсан цахим хэлбэрээр зохион байгуулж, олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлсэн гэж тайлагнасан хэдий ч хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлтийг бүрэн хангаагүй байна. Үүнд:

Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт
Төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, худалдан авах ажиллагааны цахим системд холбогдсон мэдээллийн системийн тоог нэмэгдүүлэх, цахим системд бүртгэгдэж буй машин унших боломжтой өгөгдлийн тоог нэмэгдүүлж, нээлттэй өгөгдлийг түгээх, тендер шалгаруулалтын үнэлгээнд хүний оролцоог бууруулж, хиймэл оюун ухаанд суурилсан шийдвэр гаргах боломжийг бүрдүүлж, холбогдох мэдээллийг иргэд, байгууллага, олон нийтэд ил тод мэдээлнэ.	Тендер шалгаруулалттай холбоотой бүх мэдээллийг иргэд олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлж, сурталчлан таниулсан байна.
Төрийн байгууллагын худалдан авч буй бараа, үйлчилгээнд эрэлт, нийлүүлэлт, дотоодын үйлдвэрлэгчдийн зах зээлийн бүтэц, өрсөлдөөний хэлбэр, хүчин чадалд тогтмол судалгаа зохион байгуулж, ерөнхий гэрээ байгуулан, иргэд, байгууллага, олон нийтэд ил тод мэдээлнэ.	Чанар, стандартын шаардлага хангасан барааг дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой 15 хүртэл нэр төрлийн бараанд ерөнхий гэрээг зохион байгуулна.

1.9. “Тендер шалгаруулалттай холбоотой бүх мэдээллийг иргэд олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлж, сурталчлан таниулсан байна” гэсэн хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлтийн хувьд цахим системд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг байршуулж байгаа хэдий ч төлөвлөгөөний өөрчлөлт, тайлангийн мэдээллийг ил тод байршуулаагүй байна.

1.10. “Чанар, стандартын шаардлага хангасан барааг дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой 15 хүртэл нэр төрлийн бараанд ерөнхий гэрээг зохион байгуулна” гэсэн хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлтийн хувьд Засгийн газрын тогтоолоор баталж, цахим дэлгүүрт байршуулж байгаа хэдий ч захиалагчийн эрэлт хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байна.

1.11. Зарим төрийн өмчит уул уурхайн компани тухайлбал, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, дэвшилтэт технологи нэвтрүүлж, “TenderEval v1.0” хиймэл оюун ухаанд суурилсан үнэлгээний систем ашиглаж эхэлсэн нь сайн туршлага боловч улсын хэмжээнд нэгдсэн бодлогын түвшинд нэвтэрч чадаагүй байна.

1.12. Иймд Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт төрийн худалдан авалтын талаар туссан зорилтыг бүрэн хангуулах ажлыг эрчимжүүлэх нь зүйтэй байна.

Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн дэд бүтцийн тогтвортой байдал бүрэн хангагдаагүй нь системийн найдвартай ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна

1.13. Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем Үндэсний дата төвийн мэдээллийн дэд бүтцэд байрлаж, төрийн өмчит болон төсвийн байгууллагуудын бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах үндсэн платформын үүрэг гүйцэтгэдэг.

1.14. Гэвч 2023 онд систем тасалдаж, хэвийн ажиллагааг сэргээхэд 1 сарын хугацаа зарцуулж, тасалдлын өмнө хадгалах төхөөрөмжийн багтаамж дүүрсэн нь гол шалтгаан болж, тасрахаас өмнө бүртгэгдсэн 5 хоногийн өгөгдлийн дунджаар 55.0 хувь нь сэргэсэн байна.

1.15. Мөн системийн тасралтгүй ажиллагааны төлөвлөгөө болон гамшгаас сэргээн босгох төлөвлөгөө батлагдаагүй, нөөц сервер, ачаалал тэнцвэржүүлэгч, илүүдэл холболтын шийдэл нэвтрээгүй, сэргээх ажиллагааны протокол болон өөрчлөлтийн бүртгэлийн хяналтын тогтолцоо бүрдээгүй байна.

1.16. ТБОНӨХБАҮХАТХуулийн 49 дүгээр зүйлийн 49.4.6-д ТХААГ нь “цахим систем, түүний бүрэлдэхүүн хэсгийн хэвийн үйл ажиллагааг хариуцаж, цахим системийн аюулгүй байдал, нууцлалыг хангаж, техник технологи, программ хангамжийн хүчин чадлыг тогтмол нэмэгдүүлэх”, Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4-т “кибер аюулгүй байдлыг хангахад шаардагдах хөрөнгө, үйл ажиллагааны зардлыг жил бүрийн төсөвт тусгах”, Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын 6.1.9¹ дахь заалт, Сангийн сайдын 2023 оны А/248 дугаар тушаалаар баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын 6.2.2², 6.2.3³, 6.2.4⁴, 6.2.6⁵ дахь заалтууд, Засгийн газрын 2023 оны 224 дүгээр тогтоолоор баталсан “Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журам”-ын 3.1⁶ дахь заалтуудыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.17. 2021 онд АХБ-ны санхүүжилтээр “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем”-д Грант торнтон компанийн хийсэн аудитаар Мэдээллийн технологийн аудит болон серверийн дэд бүтцийн үнэлгээгээр зөвлөмж хүргүүлсэн боловч хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд: серверийн дэд бүтцийн шинэчлэл, мэдээллийн нөөцлөлт ба сэргээн босголтын төлөвлөлт, нууцлал аюулгүй байдлын тохиргооны сайжруулалт, системийн архитектурын оновчлол зэрэг өндөр эрсдэлтэй асуудлууд өнөөг хүртэл бүрэн хэрэгжээгүй хэвээр байгаа нь 2025 онд хийгдсэн кибер аюулгүй байдлын үнэлгээнд мөн адил давтан илэрсэн байна.

1.18. Эндээс үзэхэд цахим системийн тасралтгүй ажиллагаа, сэргээн босголтын төлөвлөгөөг боловсруулж батлах, жил бүр бодит туршилт хийж шинэчлэх механизмыг хэрэгжүүлэх, нөөц сервер, илүүдэл холболт, ачаалал тэнцвэржүүлэгч техникийн шийдлийг нэвтрүүлж, туршилтын үр дүнг баримтжуулан дүгнэх тогтолцоог бүрдүүлэх, сэргээх ажиллагааны протокол, өөрчлөлтийн бүртгэлийн болон лог-мониторингийн хяналтыг бүрдүүлж, тасалдлын шалтгаан, хариу арга хэмжээг задлан шинжлэх, баримтжуулах аргачлал нэвтрүүлж ажиллах шаардлагатай байна.

1.19. Мөн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангах, системийн архитектурын шинэчлэл болон тасралтгүй ажиллагааг хангах ажлыг өнөөгийн мэдээллийн технологийн орчны боломж, нөөцийг оновчтой ашиглах, шилжилтийн эрсдэлийг бууруулах, дэд бүтцийг үе шаттайгаар бүрдүүлэх зарчмаар төлөвлөж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

¹ цахим системээр зохион байгуулж буй тендер шалгаруулалт, түүнд нийтлэгдэж буй мэдээлэлд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж, хяналт тавих, гаргасан зөрчлийг арилгуулах тухай холбогдох байгууллагуудад шаардлага, мэдээлэл, зөвлөгөө хүргүүлэх.

² цахим системийн тасралтгүй ажиллагааг хангах зорилгоор цахим системд байнгын хяналт тавих

³ худалдан авах ажиллагааны хууль, журамд нийцүүлэн цахим системийн үйл ажиллагааны шинэчлэл, сайжруулалтыг тасралтгүй хийх

⁴ цахим системд мэдээллийн аюулгүй байдлын аудитыг хоёр жил тутам хийлгэх

⁵ системийн аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатайгаар хоёр дэд бүтцэд суурилсан нөөц сервер, тоног төхөөрөмжтэй байх

⁶ Хамгаалалт шаардлагатай мэдээлэл, түүнийг агуулсан систем, сүлжээний нууцлалын зэрэглэл, мэдээлэл хариуцагчийн жагсаалтыг гаргаж, тогтмол шинэчлэх


Аудитаар цахим системийн хэрэглээний түвшнийг судалж, системийн хэрэглээнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох зорилгоор цахим системийн ашиглалт, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг гаргалаа



Сэтгэл ханамжийн судалгааны ерөнхий мэдээлэл

Судалгаанд цахим системээр тендер шалгаруулалтыг зохион байгуулагч буюу захиалагч, тендер шалгаруулалтад оролцсон ААН-үүд буюу оролцогч нарыг хамруулан, 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 11-ний өдрийг хүртэл буюу нийт 42 хоногийн хугацаанд tender.gov.mn-д байршуулснаас 4717 ААН байгууллагын ХАА хариуцсан мэргэжилтэн хамрагдсан. Үүнээс захиалагч талын төлөөлөл 1939 буюу 41.1 хувь, оролцогч талын төлөөлөл 2778 буюу 58.9 хувийг эзэлж байна.

График 2. Судалгаанд хамрагдагсдын систем ашиглалтын байдал



Эх сурвалж: Цахим судалгаа, аудитын баг

Судалгаанд хамрагдсан 4,717 хэрэглэгчийн 48.7 хувь нь цахим системийг 3 жилээс дээш, 23.2 хувь нь 1-3 жил, нийт 71.9 хувь нь 1-ээс дээш жил ашигласан туршлагатай байгаа нь судалгаанд ХАА-аар мэргэшсэн, мэргэжлийн хүмүүс хамрагдсаныг харуулж байна. Судалгааны үр дүнг асуудал бүрд уялдуулан дэлгэрэнгүй тайланд тусгасан болно.

1.20. Аудитын явцад авсан цахим системийн ашиглалт, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаагаар цахим системийн үйл ажиллагааг хэрхэн үнэлсэн байдлыг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:



Сэтгэл ханамжийн судалгаа 1.

Оролцогчдын 41.7 хувь нь “Сайн”, 13.4 хувь нь “Маш сайн” гэж эергээр үнэлсэн хэдий ч 36.2 хувь нь “Дунд”, 5.9 хувь нь “Муу”, 2.8 хувь нь “Маш муу” гэж дүгнэсэн байна. Энэ нь цахим системийн үйл ажиллагаанд доголдол, UX/UI (хэрэглэгчийн туршлага, хэрэглэгчийн интерфэйс)-ийн ойлгомжгүй асуудал, системийн чанар тогтворгүй, хэрэглэгчийн туршлагын ялгаа өндөр байгааг харуулж байна.

1.21. Харин цахим системийн тасралтгүй ажиллагааны талаар судалгаанд хамрагдсан хэрэглэгчдийн 72.8 хувь нь систем доголдож гацдаг гэж хариулсан нь системийн тасралтгүй ажиллагаа, ачаалал даах чадвар, серверийн тогтвортой байдал хангалтгүй байгааг илтгэж байна.

1.22. Энэ нь тендерийн материал байршуулж амжихгүй байх, мэдээлэл саатах, оролцогч талуудын тэгш боломж алдагдах зэрэг төрийн худалдан авах ажиллагааны үндсэн зарчимд нийцэхгүй, улмаар серверийн хүчин чадал, ачааллын тэнцвэржилд, сүлжээний найдвартай байдал, мониторинг болон техникийн дэмжлэгийн шуурхай байдлыг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна.

1.23. Мөн системийн гүйцэтгэл, UX/UI (хэрэглэгчийн туршлага, хэрэглэгчийн интерфейс), доголдлын давтамж, мэдээллийн бүтэц болон хэрэглэгчийн зааварчилгааны чанарыг сайжруулах шаардлага өндөр байгааг харуулж байна.

Мэдээллийн аюулгүй байдал болон цахим системийн хөгжүүлэлт, хяналт, ашиглалттай холбоотой мэргэшсэн боловсон хүчний чадавхыг тогтвортой хангах тогтолцоог бүрэн бүрдүүлээгүй байна

1.24. ТХААГ-ын сургалтын жилийн төлөвлөгөөнд мэдээллийн аюулгүй байдлын болон системийн ашиглалтын сургалт тусгагдаагүй, холбогдох тайлан, оролцогчдын бүртгэл байхгүй байна.

1.25. Мэдээллийн аюулгүй байдлын сургалт зөвхөн нэг удаа (2025 онд ТЕГ-ийн оролцоотой) зохион байгуулсан хэдий ч сургалтын үр дүнгийн үнэлгээ, мэдлэгийн түвшнийг тодорхойлоогүй байна.

1.26. Нөөц инженер томилогдоогүй, мэргэжлийн хүний нөөц дутмаг, мэдээллийн аюулгүй байдал, хөгжүүлэлт, хяналтын чиг үүрэг нэг ажилтанд төвлөрсөн байна.

1.27. Энэ нь хүний нөөцийн чадавхын тогтвортой байдал, системийн тасралтгүй ажиллагаа, мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг нэмэгдүүлж байна. Мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоо ISO/IEC 27001:2022 Хавсралт A.7.2.2 ⁷ стандартын заалтыг хэрэгжүүлээгүй, мэдээллийн аюулгүй байдал, системийн ашиглалт, хөгжүүлэлттэй холбоотой дотоод хүний нөөц дутмаг байна.

1.28. Иймд жил бүр мэдээллийн аюулгүй байдлын сургалтыг төлөвлөгөөнд тусгаж, байгууллагын бүх техникийн болон удирдах ажилтныг хамруулах, нөөц инженер, мэдээллийн аюулгүй байдлын ажилтан томилж, ажилтнуудын мэргэжлийн түвшнийг дээшлүүлэх, олон улсын болон сертификаттай (ISO/IEC 27001 Тэргүүлэх аудитор гэх мэт) сургалтад үе шаттай хамруулах шаардлагатай байна.

1.29. Аудитын явцад авсан цахим системийн ашиглалт, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаагаар сургалтад хамрагдсан байдлыг дараах байдлаар тодорхойлсон.Үүнд:



Сэтгэл ханамжийн судалгаа 2.

Оролцогчдын 54.3 хувь нь системийн анхан шатны сургалтад огт хамрагдаагүй, 45.7 хувь нь тодорхой хэмжээгээр сургалтад хамрагдсан байна. Цахим систем хэрэглэгчдийн дийлэнх нь чиглүүлэх сургалт, стандартчилсан зааварчилгаагүйгээр өөрсдийн туршлага, оролдлогоор системийг ашиглаж байгаа нь сургалтын хүртээмж, нэгдсэн стандартчилсан зааварчилгааг сайжруулах шаардлага байгааг харуулж байна.

1.30. Тайлант хугацаанд “Эрдэнэс Монгол” ХХК, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар ТХААГ-т эрх шилжүүлсэн байна. Үүнд: “Эрдэнэс Монгол” ХХК 2023 онд 3,218.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээ, 2024 онд 74,170.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 төсөл, арга хэмжээ, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ 102,009.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй нэг төсөл, арга хэмжээ тус тус байна.

1.31. Гэвч компанийн зүгээс эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг цахим системд тайлагнах боломжгүй, системд тохиргоо хийгдээгүй, ТХААГ-аас цахим системээр тайлагнаагүй байна. Энэ нь Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 3.4-т "Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг эрх шилжүүлсэн төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахим системээр тайлагнана", 3.5-д "Эрх шилжиж ирсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг эрх хүлээн авсан этгээд энэ журамд заасан хугацаанд шилжүүлсэн этгээдэд цахим системээр тайлагнана" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

⁷ Байгууллага нь мэдээллийн аюулгүй байдлыг талаарх мэдлэг, үр чадварыг ажилтнуудад олгох, сургалтыг тогтмол зохион байгуулах ёстой.

1.32. Мөн Сангийн сайдын 2023 оны А/255 дугаар тушаалаар баталсан “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ын дагуу Маягт 1-10-ын мэдээллийг үнэлгээний хорооны гишүүд гараар хийж буй үнэлгээний бүх үйл явц, түүний дотор арифметик алдааг залруулах, үнийн хөнгөлөлт тооцох, давуу эрх олгох, харьцуулах үнийг тодорхойлох зэргийг автоматаар үүсгэх хөгжүүлэлтийг хийгээгүй байна.

1.33. Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын төлөвлөгөө, тайлангийн Маягт 1, 2-ын төлөвлөгөө, тайланг “Excel” хүснэгтээр нэгтгэдэг, ТЕЗ, Сангийн яам улсын хэмжээний мэдээллийг нэгтгэх системийн хөгжүүлэлт хийгдээгүй байна.

1.34. Иймд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын Маягт 1, 2-ыг нэгтгэн тайлагнах, цахим системд эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг цахим системд тайлагнах, “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ын Маягт 1-10-ын мэдээллийг автоматаар үүсгэх хөгжүүлэлт хийх нь зүйтэй байна.

Цахим системийн хэрэглэгчийн эрхийн удирдлага, нууцлал, хяналт, бүртгэл, олон шатлалт баталгаажуулалт болон системийн дотоод хяналт хангалтгүй байгаа нь мэдээллийн аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж байна

1.35. Цахим системд хэрэглэгчийн эрхийн удирдлагын тогтолцоо төлөвшөөгүй, баталгаажсан эрхийн матриц байхгүй, хандалтын эрхийн хуваарилалт нь албан тушаал, ажил үүргийн хариуцлагатай уялдаагүй байна.

1.36. Үүнээс гадна супер админ буюу бүрэн хандалтын түвшний зургаан давхардсан хэрэглэгчийн бүртгэл үйлдэгдсэн нь хяналтгүй хандалт үүсэх, мэдээллийн хамгаалалтын үндсэн зарчмууд алдагдах эрсдэлийг бий болгож байна.

1.37. Цахим системд олон шатлалт баталгаажуулалт нэвтрүүлээгүй, зөвхөн хэрэглэгчийн нэр, нууц үгээр нэвтрэх зохицуулалттай байна. Хэрэглэгчийн үйлдлийн бүртгэл бүрэн бус, автоматаар бүртгэх, шинжлэх, хянах нэгдсэн систем нэвтрүүлээгүй бөгөөд эрхийн олголт, өөрчлөлт, цуцлалт нь журмаар зохицуулагдсан боловч хэрэгжилт хангалтгүй байна.

1.38. Эдгээр нь мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдал, хариуцлагын зарчим алдагдах системийн түвшний эрсдэл үүсгэж байна. Үүнд “Захиалагчийн админ”, “Захиалагчийн баталгаажуулагч” зэрэг өндөр түвшний эрхийг ажлаас гарсан болон албан тушаал өөрчлөгдсөн ажилтнуудын нэр дээр хэвээр ашиглаж байгаа нь эрхийн зааглалд, хяналт, хариуцлагын зарчим алдагдаж, хэн ямар үйлдэл хийснийг тогтоох боломжгүй нөхцөл бий болж байна. Ийм зохицуулалт нь хяналтгүй хандалт, мэдээллийн зөвшөөрөлгүй өөрчлөлт, баталгаажуулалтын бүртгэлийн гажуудал зэрэг мэдээллийн аюулгүй байдлын системийн түвшний эрсдэл үүсгэж байна. Үүнд,

- ✓ **Багануур ХК**, цахим системд “Захиалагчийн админ” эрх ажлаас чөлөөлөгдсөн ажилтны нэр дээр бүртгэлтэй эрхийг шинэчлээгүй,
- ✓ **Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХХК**, цахим системд “Захиалагчийн баталгаажуулагч” эрх ажлаас чөлөөлөгдсөн ажилтны нэр дээр бүртгэлтэй эрхийг шинэчлээгүй,
- ✓ **Цемент Шохой ХК**, цахим системд “Захиалагчийн баталгаажуулагч”, “Захиалагчийн админ” эрх ажлаас чөлөөлөгдсөн ажилтны нэр дээр бүртгэлтэй эрхийг шинэчлээгүй,
- ✓ **Эрдэнэс Монгол ХХК**, цахим системд “Захиалагчийн админ” эрх нь нэг хүний нэр дээр 2 бүртгэл үүссэн,
- ✓ **Эрдэнэс Оюу Толгой ХХК**, цахим системд “Захиалагчийн админ” эрх ажлаас чөлөөлөгдсөн ажилтны нэр дээр бүртгэлтэй эрхийг шинэчлээгүй,
- ✓ **Эрдэнэс УТП ХХК**, цахим системд “Захиалагчийн баталгаажуулагч” эрх ажлаас чөлөөлөгдсөн ажилтны нэр дээр бүртгэлтэй эрхийг шинэчлээгүй,
- ✓ **Тавантолгой ХК**, цахим системд “Захиалагчийн баталгаажуулагч” эрх ажлаас чөлөөлөгдсөн ажилтны нэр дээр бүртгэлтэй эрхийг шинэчлээгүй,
- ✓ **Шивээ-Овоо ХК**, цахим системд “Захиалагчийн админ” эрх ажлаас чөлөөлөгдсөн ажилтны нэр дээр бүртгэлтэй байсныг аудитаар залруулсан.

1.39. Энэ нь ТБОНӨХБАҮХАтХуулийн (шинэчилсэн) 49 дүгээр зүйлийн 49.4.6-д “Цахим систем, түүний бүрэлдэхүүн хэсгийн хэвийн үйл ажиллагааг хариуцан, цахим системийн аюулгүй байдал, нууцлалыг хангах, техник технологи, программ хангамжийн хүчин чадлыг тогтмол нэмэгдүүлэх.”, Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалын хавсралт " Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох

мэдээллийг зарлан мэдээлэх журам" ын 2.5⁸, Сангийн сайдын 2023 оны А/249 дүгээр тушаалаар батлагдсан "Бүртгэл хөтлөх, мэдээллийг баталгаажуулах журам"-ын 2.7⁹, 2.8¹⁰, Засгийн газрын 2023 оны 224 дүгээр тогтоолоор баталсан "Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журам"-ын 4.1¹¹, Сангийн сайдын 2023 оны А/248 тушаалаар батлагдсан "Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам"-ын 3.2.10¹², MNS ISO/IEC 27001:2023 стандартын А хавсралтын 8.2¹³ дахь заалтууд тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.40. Иймд хэрэглэгчийн эрхийн матрицыг боловсруулж батлах, үүрэгт суурилсан хандалтын хяналтын дагуу эрх олгох, цуцлах үйл ажиллагааг журамлах, "Захиалагчийн админ" зэрэг өндөр түвшний эрхийг нэг хүнд төвлөрүүлэхгүй байх, ажил үүргийн хуваарилалтад нийцүүлэн хуваарилах, олон шатлалт баталгаажуулалт нэвтрүүлэх, хэрэглэгчийн үйлдлийн бүртгэлийг автоматаар хадгалах болон хэвийн бус үйлдлийн хянах, SIEM (Security Information and Event Management) системийг нэвтрүүлэх, эрхийн олголт, өөрчлөлт, цуцлалтын бүртгэлийг албан ёсны журмаар хөтлөх, эрхийн аудит хийж, холбогдох хууль журмын хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах нь зүйтэй байна.

1.41. ОУ-ын туршлагаас харахад Япон Улсын төрийн цахим худалдан авалтын тогтолцоо нь GEPS-ээр дамжуулан үндэсний, орон нутгийн болон салбарын мэдээллийг нэгдсэн сүлжээнд уялдуулсан, эрсдэлийг системтэй хянаж удирддаг байна.

Шигтгээ 2. Япон Улсын төрийн цахим худалдан авалтын тогтолцоо нь GEPS-ээр дамжуулан үндэсний, орон нутгийн болон салбарын мэдээллийг нэгдсэн сүлжээнд уялдуулж, тендерийн 40–50 хоногийн бэлтгэл хугацааг хуульчилж өрсөлдөөний чанарыг сайжруулан, инженерийн болон технологийн худалдан авалтад техникийн тайлбар уулзалтыг заавал зохион байгуулж маргаан бууруулан, нийлүүлэгчдийг гурван жилийн мөчлөгөөр үнэлдэг нэгдсэн чанарын хяналттай бөгөөд барилгын салбарт жил бүрийн "Keishin" үнэлгээгээр эрсдэлийг системтэй хянаж, цахим битүүмжилсэн саналын механизмар ил тод байдлыг хамгаалж, WTO GPA-д хамаарах тендерийг англи хэлээр нийтэлж JTPP-ээр дамжуулан гадаад оролцогчдод дэмжлэг үзүүлдэг олон улсын өрсөлдөөнд нээлттэй үр ашигтай загвар юм.

ТХААГ цахим системийн ашиглалттай холбоотой холбогдох хууль, журмыг бүрэн мөрдөж ажиллаагүй, тендерийн хураамжийн орлогыг цахим системийн хөгжүүлэлт, мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулахад бүрэн зарцуулаагүй байна

1.42. ТБОНӨХБАҮХАТХуулийн 22 дугаар зүйлийн 22.10-т "Оролцогч цахим системээр тендер илгээхэд үйлчилгээний хураамж төлнө.", 9 дүгээр зүйлийн 9.4-т "Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журмыг баталж, цахим системээр тендер илгээхэд төлөх үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтооно." гэсэн заалтын дагуу цахим системээр тендер илгээх үйлчилгээний хураамжийг 50,000.0 төгрөг байхаар тогтоосон байна.

1.43. ТХААГ дээрх хууль, журмыг үндэслэн Голомт банкин дахь дансаар 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийг хүртэлх хугацаанд 8,138.1 сая төгрөгийн цахим системийн үйлчилгээний орлогыг төвлөрүүлж, 2023-2024 онд цахим системийн үйлчилгээний хураамжийн орлогын 70.0 хувь болох 3,626.2 сая төгрөгийг захиалагч байгууллагад, 29.0 хувь болох 1,370.3 сая төгрөгийг төвлөрүүлснээс 728.6 сая төгрөгийг улсын орлого болгосон бөгөөд 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн байдлаар тухайн тайлант

⁸ Цахим системд нэвтрэх эрх авсан ажилтан, эсхүл цахим системд бүртгэгдсэн мэдээлэл өөрчлөх тухай бүрд захиалагч болон тендерт оролцогч ажлын 5 өдрийн дотор мэргэжлийн байгууллагад албан бичгээр мэдэгдэж, холбогдох өөрчлөлтийг бүртгүүлнэ.

⁹ Мэдээлэл өөрчлөгдөх бүрд захиалагч холбогдох мэдээллийг албан бичгээр цахим системд шинэчлэх хүсэлт гаргана.

¹⁰ Мэдээллийг тухай бүр шинэчлээгүйн улмаас үүсэх аливаа үр дагавар, хариуцлагыг захиалагч бүрэн хариуцна.

¹¹ Байгууллага нь мэдээлэл, мэдээллийн систем, мэдээллийн сүлжээнд зөвшөөрөлгүй хандалт, дамжуулалт, өөрчлөлт, устгалаас хамгаалах хандалтын удирдлагыг тодорхойлно. Байгууллага нь хандалтын удирдлагад тодорхойлсны дагуу мэдээлэл, мэдээллийн системд хандах эрхийг олгож, энэ талаар бүртгэл хөтөлж хяналт тавина.

¹² Цахим системийн хөгжүүлэлт, хэвийн үйл ажиллагаа, сургалт, нууцлал, аюулгүй байдлыг хангах асуудлаар Сангийн яамтай хамтран улирал тутам уулзалт зохион байгуулах

¹³ Дагуу эрхтэй хандалтын хуваарилалт, ашиглалтыг хязгаарлах, хяналт тавих, хэрэглэгчийн эрхийг ажлын үүрэгтэй уялдуулан олгох, өөрчлөх, цуцлах журмыг хэрэгжүүлэх шаардлагатай.

оны дээр дурдсан захиалагч байгууллагууд болох ТХААГ-ын 29.0 хувийн зарлагын гүйлгээг хийж 1,368.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

1.44. Гэвч дээрх данс нь ТХААГ-ын санхүүгийн тайланд нэгтгэгдээгүй, захиалагч байгууллагуудтай цахим системийн үйлчилгээний хураамжийн орлогын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т "Энэ хуулийн 5.1.2-т заасан төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.3.1-д "төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.5-д "...бүх орлого; 14.4.6-д бүх зардал ...", Сангийн сайд, Монгол банкны Ерөнхийлөгчийн 2022 оны А122/А-172 дугаар хамтарсан тушаалын баталсан "Засгийн газар болон төсвийн байгууллагын дансыг банканд нээх, хаах, тайлагнах журам"-ын 2.1-д "Энэ журмын үйлчлэх хүрээнд Засгийн газрын болон төсвийн байгууллагын банк дахь дараах данс хамаарна", 2.1.8-д "Төсвийн орлого төвлөрүүлэх зориулалт бүхий тэг үлдэгдэлтэй /свифт үйлчилгээнд холбосон/ данс", 3.4-т "Банк нь Засгийн газар, улсын болон орон нутгийн төсвийн байгууллагын тухайн сарын дансны үлдэгдлийн мэдээллийг /сараар болон өдрөөр/ бүрэн гүйцэд, үнэн зөв Маягт-2, Маягт-3-ын дагуу цаасаар болон цахим хэлбэрээр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Монгол банканд дараа сарын гуравны өдрийн дотор хүргүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

1.45. Иймд Голомт банкин дахь цахим системийн үйлчилгээний хураамжийн орлого төвлөрүүлэх дансыг санхүүгийн тайланд нэгтгэн, тайлагнах, холбогдох хууль журмын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар албан шаардлага хүргүүлэв.

1.46. Дээрх дансаар 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн байдлаар хайгуулын сонгон шалгаруулалтад оролцогч хуулийн этгээдээс 2,095 удаагийн гүйлгээгээр 523.7 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн боловч тухайн орлого бүрдүүлэх, зарцуулах талаар эрх зүйн зохицуулалтгүй байгаагаас үлдэгдэл тухайн дансанд байршиж байгаа тул улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

1.47. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны А/48 дугаар тушаалаар баталсан "Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам"-ын 1.4-т "Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын асуудал хариуцсан нэгж тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг Ашигт малтмалын тухай хууль болон энэ журмын дагуу цахим хэлбэрээр зохион байгуулна" гэж заасан боловч хайгуулын сонгон шалгаруулалтад оролцогч хуулийн этгээдээс сонгон шалгаруулалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсны үйлчилгээний хураамжийн хэмжээ, хураамжийн орлого зарцуулах эрх зүйн нарийвчилсан зохицуулалт байхгүй байна.

1.48. Иймд хайгуулын сонгон шалгаруулалтад оролцогч хуулийн этгээдээс сонгон шалгаруулалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсны үйлчилгээний хураамжийн хэмжээ, хураамжийн орлого зарцуулах эрх зүйн нарийвчилсан зохицуулалт бий болгох нь зүйтэй байна.

1.49. Мөн ТХААГ тендерт оролцогчдоос нэмэлт санхүүжилтийн дансанд үйлчилгээний хураамжийн орлогоор 2023 онд 647.2 сая төгрөг, 2024 онд 723.1 сая төгрөг нийт 1,370.3 сая төгрөг төвлөрүүлсэн байна. Нийт орлогоос Сангийн сайдын "Улсын төсвийн байгууллагын үйл ажиллагааны давсан орлогоос зарцуулах эрх олгох тухай" 2023, 2024 оны 224 дүгээр тушаалаар 2023 онд 360.5 сая төгрөг, 2024 онд 390.0 сая төгрөгийг эрх нээсний дагуу тайлант хугацаанд нийт багаж техник хэрэгсэлд 339.5 сая төгрөг, тавилга, эд хогшилд 30.2 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ 65.8 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 206.2 сая төгрөг нийт 641.7 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

1.50. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХуулийн 49 дүгээр зүйлийн 49.4.7-д "энэ хуулийн 22.10-т заасан хураамжийн 30 хүртэл хувийг цахим системийн найдвартай ажиллагаа, шинэчлэл сайжруулалт, аюулгүй байдлыг хангахад зарцуулах;" Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг

зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 3.1-д "Үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогод Төсвийн тухай хуулийн 47.1.5-д заасан төсөвт байгууллагын төсвийн жилийн эхнээс өссөн дүнгээр тооцож гаргасан дараах орлогыг тооцно", 3.1.1-д "төлөвлөгөөнөөс давж биелсэн орлого", 3.1.2-т "төсвийн жилийн дундуур шинээр бий болсон орлого", 3.2-т "Энэ журмын 3.1.1, 3.1.2-т заасан орлогыг энэ журмын гуравдугаар хавсралтад заасан үйл ажиллагаанаас олсон орлогын хүрээнд хамруулж үзнэ" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн тул албан шаардлага хүргүүлэв.

1.51. ТХААГ нь 2024 онд "Номадик бейр геймс" ХХК -тай байгуулсан ТХААГ/20240203006 дугаартай "Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн үндсэн платформ болон уялдаатай ажиллах дэд системүүдийн засвар үйлчилгээ үзүүлэх гэрээ"-ний дагуу 58.8 сая төгрөг мөн тус компанитай "Цахим системийн засвар үйлчилгээ хийж гүйцэтгэх гэрээ"-ний дагуу 19.0 сая төгрөг нийт 77.8 төгрөгийн хөгжүүлэлт хийж зардлыг биет бус хөрөнгөөр бүртгээгүй урсгал зардлаар бүртгэсэн байна.

1.52. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", УСНББОУС 17 "Үндсэн хөрөнгө"-ийн "Дахин үнэлгээний загвар" хэсэгт дансны үнэ ба бодит үнэ цэний хооронд материаллаг зөрүү гаргахгүй байх үүднээс тайлагналын үеийн эцэс бүрд хөрөнгийн бодит үнэ цэнэ, ашиглалтын хугацааг тооцож үздэг байх, Шаардлагатай бол "хөрөнгийг дахин үнэлэх" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "үнэлгээ", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

1.53. Аудитын явцад авсан цахим системийн ашиглалт, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаагаар тулгарч буй хүндрэл, бэрхшээлийг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:



Сэтгэл ханамжийн судалгаа 3.

1.Тендер зарлах, материал байршуулах үед систем ачаалал үүсгэн гацаа, серверийн алдаа өгөх зэрэг техникийн дөгөөдөл нь хэрэглэгчдийн худалдан авах ажиллагаанд оролцоход хүндрэл үүсгэдэг, 2.Техникийн тусламж үйлчилгээ шуурхай биш байгаа нь хэрэглэгчдийн гомдлыг нэмэгдүүлдэг, 3.Цахим системийн интерфэйсийн ойлгомжгүй бүтэц нь анхан шатны хэрэглэгчдэд төөрөгдөл үүсгэж, алдаа гаргах магадлалыг нэмэгдүүлдэг, 4.Файлын хэмжээний хязгаар бага, байршуулах явцад тасалдал гарах зэрэг асуудлууд олон файлтай тендерийн үед хүндрэл болдог, 5.Албан ёсны сургалт ба зааварчилгааны хувьд хангалтгүй, гарын авлага ойлгомжгүй, видео заавар байхгүй, 6.Хууль, системийн логикийн уялдаа сул байгаа талаар санал давамгай гарсан бөгөөд үнэлгээ, оноо, баталгаажуулалтын логик болон мэдээллийн бүтэц нь заримдаа хууль, журмын шаардлагад нийцэхгүй байна гэж үзсэн байна.

1.54. Дээрх судалгаанаас үзэхэд цахим системд нэн түрүүнд хийх шаардлагатай шинэчлэл нь системийн тогтвортой ажиллагааг сайжруулах, UX/UI (хэрэглэгчийн туршлага, хэрэглэгчийн интерфэйс) дахин загварчлах, мэдээлэл байршуулах процессыг найдвартай болгох, техникийн тусламжийн шуурхай байдлыг нэмэгдүүлэх, сургалт, зааварчилгааны хүртээмжийг өргөтгөх, хууль, системийн логикийн зөрүүг арилган ил тод байдлыг сайжруулах нь зүйтэй байна.

1.55. Эндээс дүгнэхэд цахим системийн дэд бүтцийн тогтвортой байдал бүрэн хангагдаагүй, мэдээллийн аюулгүй байдал болон цахим системийн хөгжүүлэлт, хяналт, ашиглалттай холбоотой мэргэшсэн боловсон хүчний чадавхыг тогтвортой хангах тогтолцоог бүрэн бүрдүүлээгүй, хэрэглэгчийн эрхийн удирдлага, нууцлал, хяналт, бүртгэл, олон шатлалт баталгаажуулалт болон системийн дотоод хяналт хангалтгүй байгаа нь мэдээллийн аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж байна.

1.56. Иймд цахим системийн дэд бүтцийн тогтвортой байдал бүрэн хангах, мэдээллийн аюулгүй байдал болон цахим системийн хөгжүүлэлт, хяналт, ашиглалттай холбоотой мэргэшсэн боловсон хүчний чадавхыг тогтвортой хангах тогтолцоог бүрэн бүрдүүлэх, хэрэглэгчийн эрхийн удирдлага, нууцлал, хяналт, бүртгэл, олон шатлалт баталгаажуулалт

болон системийн дотоод хяналтыг сайжруулах, хураамжийн орлогыг зориулалтын дагуу цахим системийн ашиглалтад зарцуулах нь зүйтэй байна.

Компаниудын тендер шалгаруулалттай холбоотой Сангийн яаманд ирүүлсэн гомдол нь нийт гомдлын дунджаар 32.9 хувийг эзэлж байна

1.57. ТБОНӨХБАҮХАТХуулинд худалдан авах ажиллагаанд оролцох холбогдох төрийн байгууллагуудын чиг үүргийг дараах байдлаар туссан байгаа боловч хэрэгжилт хангагдаагүй

Сангийн яам	ТХААГ
38 дугаар зүйлийн 38.7-д "Бараа, үйлчилгээг ерөнхий гэрээний аргаар худалдан авах тендер шалгаруулалтын аргачлал, зааврыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална", 55 дугаар зүйлийн 55.1.3-т "Худалдан авах ажиллагаатай холбоотой журам, аргачлал, заавар, тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг, гэрээний загварыг батлах" гэсэн заалтын дагуу Бараа, үйлчилгээг ерөнхий гэрээний аргаар худалдан авах тендер шалгаруулалтын аргачлал, зааврыг батлаагүй.	49 дүгээр зүйлийн 49.4.9-д "цахим системийн ашиглалтад дүн шинжилгээ хийж, холбогдох мэдээ, тоо баримтыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх" гэсэн заалтын дагуу цахим системийн ашиглалтад дүн шинжилгээ хийх ажлыг зохион байгуулаагүй.
55.1.6-д худалдан авах ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, журам, заавар, аргачлалын хэрэгжилтэд хяналт тавьж, дүн шинжилгээ хийсэн тайлан байхгүй,	4 дүгээр зүйлийн 4.1.25-д "цахим каталог" гэж бараа, ажил, үйлчилгээний мэдээллийг ангилж тодорхойлсон цахим системийн бүрэлдэхүүнийг;" 34 дүгээр зүйлийн 34.12-т "Харьцуулалтын аргаар худалдан авах бараа цахим каталогт бүртгэгдсэн байна", 54 дүгээр зүйлийн 54.1-д Худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага цахим системээр дараах бүртгэлийг хөтөлнө: 54.1.4-т "бараа, ажил, үйлчилгээний каталог" гэсэн заалтын дагуу "Цахим каталог" үүсгээгүй.

байна.Үүнд:

1.58. Аудитын явцад авсан цахим системийн ашиглалт, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаагаар хэрэглэгчийн гарын авлагын ойлгомжтой байдлыг дараах байдлаар тодорхойлсон.Үүнд:



Сэтгэл ханамжийн судалгаа 4.

Гарын авлагын ойлгомжтой байдлыг хэрэглэгчдийн 46.1 хувь эергээр үнэлсэн бол 33.8 хувь нь ойлгомжгүй, хангалтгүй, 20.1 хувь нь огт мэдэхгүй буюу ашиглаж үзээгүй гэж хариулсан нь гарын авлагын хүртээмж, тайлбарын түвшин, бүтэц болон хэрэглэгчийн хэрэгцээнд нийцүүлэх шинэчлэл шаардлагатайг тодорхой харуулж байна.

1.59. Иймд холбогдох төрийн байгууллагууд хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага хүргүүлэв.

1.60. Улсын хэмжээнд тендер шалгаруулалттай холбоотой 2023 онд 1487 гомдол, 2024 онд 2176 гомдол шийдвэрлүүлэхээр ирүүлсэн байгаа нь өмнөх оноос 46.3 хувиар өссөн байна. Үүнээс 13 компанийн тендер шалгаруулалттай холбоотой 2023 онд 524 гомдол ирүүлсэн нь нийт гомдлын 35.2 хувь, 2024 онд 665 гомдол ирүүлсэн нь 30.5 хувийг эзэлж байна.

1.61. Ирүүлсэн гомдлыг тендер шалгаруулалтын аргаар авч үзэхэд 2023 онд НТШ-ын аргаар 458 буюу 87.4 хувь, гэрээ шууд байгуулах аргаар 17 буюу 3.2 хувь, зөвлөх үйлчилгээгээр 16 буюу 3.1 хувь, үлдсэн хувийг бусад аргаар, 2024 онд НТШ-ын аргаар 603 буюу 90.7 хувь, харьцуулалтын аргаар 60 буюу 9 хувь, үлдсэн хувийг бусад аргаар зохион байгуулсан гомдол эзэлж байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 2-оос үзнэ үү/

1.62. 13 компанитай холбоотой 2023 онд ирүүлсэн нийт гомдлын 309 буюу 59.0 хувь, 2024 онд 410 буюу 61.7 хувь нь гомдол үндэслэлтэй буюу захиалагчийн гаргасан шийдвэр буруу гэж шийдвэрлэсэн байна. Энэ нь тендер шалгаруулалтын баримт бичиг, техникийн тодорхойлолт хангалтгүй боловсруулагдсан, тендер зохион байгуулалтын явц процессын

алдаатай, захиалагчийн худалдан авах ажиллагааны зохион байгуулалт хангалтгүй, үнэлгээний хороо холбогдох хууль, журмын дагуу ажиллаж чадахгүй, түүнд тавих захиалагчийн хяналт сул байгаатай холбоотой байна.

1.63. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д "Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний батлагдсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална", 48 дүгээр зүйлийн 48.2.3-т "үнэлгээний хорооны зөвлөмж хууль тогтоомжид нийцэх эсэхэд хяналт тавих" гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.64. Мөн ирүүлсэн гомдлоос 2023 онд 3, 2024 онд 10 гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлээгүй байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХуулийн /хуучин/ 55 дугаар зүйлийн 55.2-т "Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар энэ хуулийн 55.1-д заасан гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногт багтаан хянан шийдвэрлэнэ", 2023 оны хууль /шинэчилсэн найруулга/-ийн 59 дүгээр зүйлийн 59.8-д "Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тендер шалгаруулалтад холбоотой цахим системд байршуулсан баримт бичиг, мэдээлэл, тендер шалгаруулалтын хувийн хэрэгт үндэслэн ажлын 10 өдөрт багтаан гомдлыг хянан шийдвэрлэнэ" гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.65. Иймд Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүний нөөцийг оновчтой удирдан зохион байгуулж, хуулийн хугацаанд гомдлыг шийдвэрлэх нь зүйтэй байна.

1.66. Төрийн сан дахь дансанд 2023 онд 631.0 сая төгрөг, 2024 онд 1,182.5 сая төгрөг буюу нийт 1,813.5 сая төгрөгийн тендерийн баталгааны орлогыг улсын төсөвт төвлөрүүлснээс 13 компани нийт 649.3 сая төгрөг буюу 35.8 хувийг эзэлж байна. Үүнд тендерт оролцогч 96 компани нийт 816.5 сая төгрөгийг улсын орлого болгохоос 89 компанийн 752.2 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлж, 4 захиалагчийн зарласан тендерт оролцогч 7 компанийн 64.3 сая төгрөгийг улсын төсөвт дутуу төвлөрүүлснийг аудитын явцад 2 захиалагчийн 23.3 сая төгрөгийг улсын орлого болгон, 5 компанийн 41.0 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

1.67. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХуулийн 14 дүгээр зүйлийн 14.6.3-т "санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гомдлыг бүхэлд нь үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн", Сангийн сайдын 2023 оны А/252 дугаар тушаалаар батлагдсан "Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам"-ын 2.9-т "Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага оролцогчийн гомдлыг бүхэлд нь үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн бол захиалагч тухайн тендер шалгаруулалт, түүний багцад гаргасан 20 сая төгрөг хүртэл үнийн дүнтэй тендерийн баталгааг бүхэлд нь, түүнээс дээш үнийн дүнтэй тендерийн баталгааг хуулийн 14.7-д заасан үнийн дүнд нийцүүлэн улсын орлого болгоно" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй тул улсын орлогод дутуу төвлөрүүлсэн тендерийн баталгааны орлого 41.0 сая төгрөгийг улсын төсөвт бүрэн төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

1.68. Аудитын явцад авсан цахим системийн ашиглалт, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаагаар цахим систем нь холбогдох хууль, журамтай хэрхэн нийцэж байгаа талаар дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:



Сэтгэл ханамжийн судалгаа 5.

Хэрэглэгчдийн 54.9 хувь нь "дунд зэрэг нийцсэн", 42 хувь нь "бүрэн нийцсэн", харин 3.1 хувь нь "огт нийцээгүй" гэж үнэлсэн нь хууль, журмын хэрэгжилтийг бүх үе шатанд нарийвчлан тодорхой, нэг мөр болгох болон системийн мэдээллийн ил тод байдлыг сайжруулах шаардлага өндөр байгааг харуулж байна.

БҮЛЭГ 2. ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ СИСТЕМИЙГ АШИГЛАСНААР ЦАХИМЖИЛТ, ИЛ ТОД БАЙДАЛ БҮРЭН ХАНГАГДААГҮЙ БАЙНА

Төрийн өмчит уул уурхайн компаниудын засаглалыг тодорхой болгох, дээд шатны байгууллагын хяналтыг сайжруулах замаар санхүүгийн үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх шаардлага байна

2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах ажлыг зохион байгуулж гүйцэтгэлийг хянах”, 2 дахь хэсэгт “төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах”, 8 дахь хэсэгт “төрийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах санал, захиалгыг хянаж батлах, шинээр авах шийдвэр гаргах” гэж Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрхийг тодорхойлсон байна.

2.2. Гэвч дээрх хуулийн заалт бүрэн хэрэгжихгүй байна. Энэ нь 2015 онд Төрийн өмчийн хороог татан буулгаж, Сангийн яаманд нэгтгэх үед дээрх хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийн 3-т: “.....төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх этгээдийг Засгийн газар тогтоох” гэсэн заалтыг нэмснээр төрийн захиргааны олон байгууллагууд хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаатай холбоотой байна.

2.3. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-т “орлого төвлөрүүлэгч хуулийн этгээд” гэж Хуримтлалын санд орлого төвлөрүүлэх үүрэг бүхий уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн нэгдлийн толгой компанийг, 12 дугаар зүйлийн 12.4-т “Уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын бүх төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь орлого төвлөрүүлэгч хуулийн этгээдийн харьяанд ажиллана”, 12.6-д “Орлого төвлөрүүлэгч хуулийн этгээд нь уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын болон өөрийн хөрөнгө оруулсан авто зам, төмөр зам, дэд бүтцийн төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшиж, удирдлага зохион байгуулалтаар хангана” гэж тус тус заасан байна.

2.4. Гэтэл “Эрдэнэс Монгол” ХХК нь харьяа хуулийн этгээдүүдийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төсөлд санал өгч, цахим системд баталгаажуулдаг боловч тэдгээрийн худалдан авах ажиллагааны тайланг нэгтгэн тайлагнадаггүй, компаниуд тус бүр тайлангаа цахим системээр Сангийн яаманд хүргүүлж байна.

2.5. Энэ нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 44 дүгээр зүйлийн 44.3-т “Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээнэ”, 44.4-т “Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн жилийн санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш нэг сарын дотор харьяа захиалагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн хянаж, баталгаажуулан цахим системд нийтэлнэ” гэж, 46 дугаар зүйлийн 46.1-д “Захиалагч худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрээр харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр тайлагнана”, 46.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч харьяа захиалагчийн худалдан авах ажиллагааны тайланг нэгтгэн дараа оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахим системээр тайлагнана”, 46.3-т “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчаас ирүүлсэн тайланг нэгтгэн дүгнэж, дараа оны эхний улиралд Засгийн газарт тайлагнана” гэж тус тус заасантай холбоотой байна.

2.6. Өөрөөр хэлбэл, “Эрдэнэс Монгол” ХХК нь дээрх хуульд заасан төсвийн ерөнхийлөн захирагчид хамаарахгүй тул тодорхойгүй байдал үүссэн байна. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрмийн 3.2.7-т “Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 3.2.7.1-д “нэгдлийн урт, дунд хугацааны стратеги төлөвлөгөөг батлах”, 3.2.7.2-т “нэгдлийн бизнесийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах”, 3.2.7.3-т “нэгдлийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийг батлах” гэж заасан байна.

2.7. Харин Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 225 дугаар тогтоолын 2 дахь заалтад “...стратеги болон бизнес төлөвлөгөө, тухайн жилийн зорилтот түвшингүйн үзүүлэлт, хөрөнгө оруулалт, нийт үр ашгийг нэгдлийн хэмжээнд уялдуулан төлөвлөх саналаа боловсруулан...Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай” гэжээ.

2.8. Эндээс үзэхэд дээрх хууль, дүрэм, Засгийн газрын тогтоол зэрэг нь хоорондоо нийцээгүй, чиг үүргийн давхцал үүссэн, засаглал тодорхой бус байгаа нь төрийн болон холбогдох дээд шатны байгууллагуудын хяналт тавих үйл ажиллагаанд нөлөөлж байна.

2.9. Иймд Төрийн өмчит хуулийн этгээдийн төрийн өмчийн бодлого, төрийн төлөөлөл хэрэгжүүлэх нэгдмэл бодлогыг хэрэгжүүлэх, төрийн өмчит, өмчийн оролцоотой хувьцаат, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийг хуульд нийцүүлэн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч этгээд болон төрийн зохицуулалтын чиг үүргийн зааг ялгааг тусгаж, төрийн үүрэг, хариуцлагыг тодорхой болгох нь зүйтэй байна.

2.10. 13 компани 2023 онд 4,142.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 3844 бараа, ажил үйлчилгээг худалдан авахаар төлөвлөж, төсвийн жилд 2-5 удаа тодотгол хийж, 7,910.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 4145 бараа, ажил, үйлчилгээ болж анх батлагдсан төлөвлөгөөнөөс тендерийн тоо 7.8 хувиар, төсөвт өртөг 91.0 хувиар өссөн, 2024 онд 6,321.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 3540 бараа, ажил, үйлчилгээг худалдан авахаар төлөвлөн төсвийн жилд 2-5 удаа тодотгол хийж, 11,855.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 3686 бараа, ажил үйлчилгээ болж анх батлагдсан төлөвлөгөөнөөс тендерийн тоо 4.1 хувиар, төсөвт өртөг 87.5 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 3. Компаниудын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд оруулсан тодотголын мэдээ

тэрбум төгрөг

Д.Д	Компанийн нэр	2023 он					2024 он				
		Тодотгол хийсэн тоо	Анх батлагдсан		Тодотгол хийсэн /сүүлийн/		Тодотгол хийсэн тоо	Анх батлагдсан		Тодотгол хийсэн /сүүлийн/	
			тоо	төсөвт өртөг	тоо	төсөвт өртөг		тоо	төсөвт өртөг	тоо	төсөвт өртөг
1	Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ	4	1006	1,466.2	1222	2,271.0	5	1302	1,905.5	1425	2,393.1
2	Эрдэнэс Монгол ХХК	1	112	36.6	129	38.9	4	113	121.5	159	147.5
3	Эрдэнэс Тавантолгой ХК	3	421	1,092.9	508	4,070.7		470	1,950.4	538	7,220.7
4	Эрдэнэс Алт Ресурс ХХК	-	162	114.9	162	114.9	0	121	137.0	121	137.0
5	Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр ХХК	1	868	211.0	828	220.5	1	573	226.9	578	218.4
6	Эрдэнэс Критикал Минералс ТӨҮГ	1	476	133.6	505	135.8	3	237	108.5	274	143.0
7	Эрдэнэс Оюу Толгой ХХК	-	8	0.8	8	0.8	1	3	13.5	6	19.6
8	Шивээ Овоо ХК	1	178	83.2	115	6.5	1	204	68.6	131	18.4

9	Эрдэнэс УТП ХХК	-	4	7.1	4	7.1	1	2	0.6	2	0.6
10	Багануур ХК	1	248	148.4	248	163.3	1	131	163.2	131	169.2
11	Цемент шохой ХХК	1	236	92.4	252	95.3	1	225	64.6	238	61.7
12	Эрдэнэс Баянбогд ХХК	-	46	14.9	46	14.9	1	41	2.4	40	2.2
13	Тавантолгой ХК	4	79	740.4	118	770.4	3	118	1,558.9	43	1,323.7
	Нийт	17	3844	4,142.5	4145	7,910.1	22	3540	6,321.6	3686	11,855.0

Эх сурвалж: Компаниудын худалдан авах ажиллагааны баталгаажсан төлөвлөгөө, тодотгол

- 2.11. Хүснэгтээс харахад “Эрдэнэс тавантолгой” ХК 2023 онд төсөвт өртгийг 4,070.7 тэрбум төгрөгөөр буюу нийт өсөлтийн 51.5 хувийг, 2024 онд 7,220.7 тэрбум төгрөгөөр буюу нийт өсөлтийн 60.9 хувийг эзэлж байгаа нь Цанхийн баруун, зүүн уурхайн хөрс хуулалт нүүрс олборлолтын ажил /багцтай/ нэмэгдсэнтэй холбоотой байна.
- 2.12. 2023 онд тодотголоор нэмэгдсэн нийт төсөвт өртгөөс барааны төсөвт өртөг 215.3 тэрбум төгрөгөөр буюу 9.3 хувиар буурсан бол ажил, үйлчилгээний төсөвт өртөг 3,767.6 тэрбум төгрөгөөр буюу 3.1 дахин өссөн, 2024 онд тодотголоор нэмэгдсэн нийт төсөвт өртгөөс барааны төсөвт өртөг 43.9 тэрбум төгрөгөөр буюу 1.9 хувиар өссөн бол ажил, үйлчилгээний төсөвт өртөг 5,489.5 тэрбум төгрөгөөр буюу 2.4 дахин өссөн байна.
- 2.13. Эндээс үзэхэд ажил, үйлчилгээний төсөвт өртөг дунджаар 2.8 дахин өссөн нь хөрөнгө оруулалтын нэгдсэн стратеги, төлөвлөлт, бодлого уялдаагүй, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлахдаа тооцоо судалгаанд үндэслээгүй, үйл ажиллагааны урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардлын эх үүсвэрийг тодорхой тусгаагүй, төсөв хооронд гүйлгэн зарцуулах талаар нарийвчлан зохицуулалт байхгүй, холбогдох дээд шатны байгууллагаас нэгдсэн дүн шинжилгээ хийж иж бүрэн хяналт тавьж ажиллаагүйтэй холбоотой байна.
- 2.14. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2.9¹⁴, 2.13¹⁵, 3.6¹⁶ дахь заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- 2.15. Иймд компаниудын хөрөнгө оруулалтын нэгдсэн төлөвлөлт, стратегийг боловсруулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тооцоо судалгаанд үндэслэн батлах, холбогдох дээд шатны байгууллагаас нэгдсэн дүн шинжилгээ хийж иж бүрэн хяналт тавьж ажиллах шаардлага байна.
- 2.16. 2022 оны тендер шалгаруулалтын кодтой 1.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 3 тендерийг 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй, 2023 оны тендер шалгаруулалтын кодтой 127.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 88 тендерийг 2024 оны төлөвлөгөөнд тусгаагүй, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Хүснэгт 4. Он дамжуулан хэрэгжүүлсэн боловч төлөвлөгөөнд тусгаагүй зохион байгуулсан тендерийн мэдээлэл сая төгрөг

Д.д	Компанийн нэр	2023 он		2024 он		НИЙТ	
		Тендер тоо	Төсөвт өртөг	Тендер тоо	Төсөвт өртөг	Тендер тоо	Төсөвт өртөг
1	Цемент шохой ХХК			3	285.0	3	285.0

¹⁴ Захиалагч өөрийн байгууллагын төсвийн хүрээнд хэрэгжүүлэх төлөвлөгөө хууль тогтоомжид нийцэж буй эсэх, тухайн байгууллагын зорилтыг хангах, үр ашигтай, зөв төлөвлөгдсөн эсэхийг хянан, цахим системээр батална,
¹⁵ "Төлөвлөгөөнд тусгагдсан тухайн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, зохион байгуулах хугацаа, тендер шалгаруулалтын арга, бараа, ажил, үйлчилгээний төрөл, тухайн тендер шалгаруулалтыг хүчингүй болгох, бүр захиалагч холбогдох өөрчлөлттэй холбоотой үндэслэлийг албан бичгээр үйлдэж, цахим системд хавсаргасан байх ба холбогдох этгээд түүнийг хянаж төлөвлөгөөний өөрчлөлтийг зөвшөөрнө",
¹⁶ Батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, зохих ёсоор хэрэгжүүлээгүй үндэслэл, тайлбар болон хууль, журамтай холбоотой санал хүсэлтийг тайланд тусгана

2	Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХХК	1	187.4	13	10,618.6	14	10,805.9
3	Тавантолгой ХК			1	500.0	1	500.0
4	Эрдэнэс Баянбогд ХХК			1	6,195.9	1	6,195.9
5	Эрдэнэс оюу толгой ХХК			1	2,324.6	1	2,324.6
6	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ			69	107,386.7	69	107,386.7
7	Багануур ХК	1	66.0			1	66.0
8	Эрдэнэс алт ресурс ХХК	1	1,379.0			1	1,379.0
НИЙТ		3	1,632.4	88	127,310.7	91	128,943.1

Эх сурвалж: Цахим систем

2.17. Иймд өмнөх онд хэрэгжээгүй бараа, ажил, үйлчилгээг ач холбогдлоор нь эрэмбэлж, зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай эсэхийг тодорхойлсны үндсэн дээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх, тухайн оны төлөвлөгөөнд тусгаагүй худалдан авах ажиллагааг зохион байгуулахгүй байх нь зүйтэй байна.

2.18. Аудитаар “Багануур” ХК, “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ, “Дархан төмөрлөгийн үйлдвэр” ХХК, “Цемент шохой” ХХК-ийг түүвэрлэн авч үндсэн хөрөнгө, бараа материалын тайланд шинжилгээ хийлээ. 2023 онд үндсэн хөрөнгө 1,371.4 тэрбум төгрөгөөр бэлтгэсэн нь өмнөх оноос 6.8 хувиар буурсан ба үлдэгдэл 5,637.5 тэрбум төгрөг болж өмнөх оноос 24.9 хувиар өссөн, 2024 онд бараа материал 6,396.8 тэрбум төгрөгөөр бэлтгэсэн нь өмнөх оноос 2.8 хувиар буурч үлдэгдэл 1,800.4 тэрбум төгрөг болж өмнөх оноос 12.5 хувиар тус тус өссөн байна.

2.19. Тайлант хугацаанд бараа материалын үлдэгдэлд 32.1 тэрбум төгрөгийн үнэ цэний бууралтаар, бодит үнэ цэнийг бууруулан бүртгэсэн байна. Гэвч бараа материал, үндсэн хөрөнгийн 2024 оны үлдэгдлийг түүвэрлэн үзэхэд 3-аас дээш жилийн хугацаанд ашиглагдаагүй, агуулахад хадгалагдаж байгаа нийт 33.9 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь чанар байдлаа алдах, ашиглах боломжгүй болох эрсдэл үүссэн байна.Үүнд:

- ✓ **Багануур ХК** 2020-2024 онд хөдөлгөөн ороогүй бараа материалын 4,494.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй, үлдэгдлийг үнэ цэний бууралтаар бүртгэсэн,
- ✓ **Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ** 25,188.0 сая төгрөгийн бараа материалын үлдэгдлийг үнэ цэний бууралтаар бүртгэсэн, үүнээс 8,041.8 сая төгрөгийн бараа материалыг 3 жилээс дээш хугацаанд ашиглаагүй агуулахад үлдэгдэлтэй,
- ✓ **Дархан төмөрлөгийн үйлдвэр ХХК** 2020 оноос хойш ашиглагдаагүй 1,482.0 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй, 1,740.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө ашиглагдаагүй агуулахад үлдэгдэлтэй,
- ✓ **Цемент шохой ХХК** 2010 оноос 2023 оны хооронд худалдан авсан ашиглагдаагүй 1,051.7 сая төгрөгийн тус тус үлдэгдэлтэй

2.20. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх", НББОУС 2 “Бараа материал”-д заасны дагуу бараа материалыг тайлант үе бүрийн эцэст өртөг ба цэвэр боломжит үнэ цэний аль багаар илэрхийлнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй, бараа материалын нөөцийг норм, нормативд үндэслэн оновчтой төлөвлөөгүй, илүүдэл нөөцийг хэрхэн эргэлтэд оруулах талаар нэгдсэн зохицуулалтгүй, нөөцийг зохистой хэмжээгээр бүрдүүлээгүй, арвилан хэмнэлтгүй, нөөцийн ашиглалтад нэгдсэн дүн шинжилгээ хийж, бүрэн хяналт тавьж ажиллаагүй байна.

2.21. Иймд бараа материалын нөөцийг удирдах нэгдсэн журмыг баталж мөрдөх, үнэ цэнийн бууралтыг тооцох талаар аргачлал боловсруулах, эдийн засгийн тооцоолол, үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагааны технологийн нормтой уялдуулан төлөвлөх, арвилан хэмнэлттэй, үр ашигтай, хариуцлагатай байх зарчмыг баримталж ажиллахад нэгдсэн хяналт тавьж ажиллах нь зүйтэй байна.

2.22. Аудитад хамрагдсан 9 компанийн 2023, 2024 онд батлагдсан төсөв, шилэн дансанд нийтэлсэн төсвийн мэдээллийг түүвэрлэн шалгахад мэдээлэл сурталчилгааны зардалд 11.2 тэрбум төгрөг, нийгэм олон нийттэй харилцах зардалд 1.7 тэрбум төгрөг, сургалтын зардалд 14.3 тэрбум төгрөгийг тус тус төлөвлөсөн байна. Үүнээс мэдээлэл сурталчилгаа, нийгэм олон нийттэй харилцах зардлыг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд огт тусгаагүй, харин сургалтын зардлаас 2.3 тэрбум төгрөг буюу нийт зардлын 16.0 хувийг ХАА-ны төлөвлөгөөнд тусгасан байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 3-аас үзнэ үү/

2.23. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", Монгол Улсын Засгийн газрын 2022 оны "Эрдэнэс Монгол" нэгдлийн талаар авах арга хэмжээний тухай 225 дугаар тогтоолын 4 дэх хэсэгт "Нэгдлийн хэмжээнд охин, хараат компани болон харьяа үйлдвэрийн газруудын үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж, зардал бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээг тухай бүр нь авч хэрэгжүүлэх" гэсэн заалтын хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй, толгой компанийн зүгээс удирдлага зохион байгуулалтаар бүрэн хангаагүй, үр дүнтэй ажил зохион байгуулаагүй, нэгдсэн хяналт тавьж ажиллаагүй, төсвийг тооцоо судалгаанд үндэслэн иж бүрэн төлөвлөөгүй, дүн шинжилгээ хийж ажиллаагүй, худалдан авах ажиллагааны нэгдсэн бодлогын баримт бичиг байхгүй, арвилан хэмнэлттэй, үр ашигтай, хариуцлагатай байх зарчмыг баримтлаагүй, хяналт сул байгаатай холбоотой байна.

2.24. Эндээс үзэхэд "Эрдэнэс Монгол" ХХК нь охин, хараат, харьяа компаниудыг Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 108¹⁷, 2022 оны 225¹⁸ дугаар тогтоолын дагуу компанийн төсвийн төлөвлөлтөд арвилан хэмнэлттэй, үр ашигтай, хариуцлагатай байх зарчмыг баримтлан, нэгдсэн дүн шинжилгээ хийж, үр дүнг тооцож, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар бүрэн хангаж, хяналт тавьж ажиллах нь зүйтэй байна.

Цахим системийн ашиглалтай холбоотой холбогдох хууль, журмыг бүрэн мөрдөж ажиллаагүй, систем хооронд уялдаагүй байгаа нь олон нийт үнэн зөв, иж бүрэн, ил тод мэдээллээр бүрэн хангагдахгүй байна

2.25. Дээрх 13 компани 2023 онд худалдан авах ажиллагааны цахим системээр хууль, тогтоомжийн хүрээнд зарлавал зохих 7,593.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 3055 бараа, ажил, үйлчилгээг худалдан авахаар төлөвлөснөөс 6,160.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 2255 тендер буюу 73.8 хувийг цахимаар зарласан байна. Үүнээс 5,625.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1721 буюу 76.3 хувь нь амжилттай болсон бөгөөд энэ нь цахимаар зарлавал зохих тендертэй харьцуулахад 56.3 хувийг эзэлж байна.

2.26. 2024 онд 12,280.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 3172 бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөснөөс 8,910.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 2419 тендер буюу 76.2 хувийг цахимаар зарласан байна. Үүнээс 8,061.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1953 буюу 80.7 хувь нь амжилттай болсон бөгөөд энэ нь цахимаар зарлавал зохих тендертэй харьцуулахад 61.5 хувьтай байгаа нь хангалтгүй байна.

2.27. Мөн 2023 онд зарласан тендерээс 9 компани 3,292.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1761 буюу 78.1 хувь, 2024 онд 2,406.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1671 буюу 69.0 хувийг төлөвлөсөн хугацаанд зарлаагүй байна.

2.28. Энэ нь худалдан авах ажиллагааны төлөвлөлт оновчгүй, төлөвлөгөөнд заасан хугацааг мөрдөж ажиллаагүй, тухайн онд хэрэгжихгүй төсөл, арга хэмжээг олноор төлөвлөснөөр хугацаа алдаж, он дамжих, төлөвлөлт, гүйцэтгэл зөрөх үндсэн шалтгаан болж байна.

2.29. Амжилттай болсон тендерээс 2023 онд 1721 гэрээ бүртгэхээс 376 гэрээ буюу 21.8, 2024 онд 1953 гэрээ бүртгэхээс 405 гэрээ буюу 20.8 хувийг цахим системд бүртгээгүй байна. Үүнээс

¹⁷ "Эрдэнэс Монгол" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэм"-ийн 1.2.2-д "Компани нь энэ дүрмийн 1.2.1-д заасан зорилгын хүрээнд өөрийн болон охин, хараат компани, харьяа хуулийн этгээд, төслийн нэгжийн эрдэс баялгийн хайгуул.....дэд бүтэц, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг удирдлага менежментээр хангах үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ"

¹⁸ "Нэгдлийн хэмжээнд охин, хараат компани болон харьяа үйлдвэрийн газруудын үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж, зардал бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээг тухай бүр нь авч хэрэгжүүлэх"

“Багануур” ХК, “Цемент шохой” ХХК цахим системд гэрээ бүртгээгүй, харин “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Эрдэнэс Монгол” ХХК, “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ компаниуд гэрээг дунджаар 95.0 хувьтай бүртгэсэн байна.

Хүснэгт 5. Худалдан авах ажиллагааны цахим системд гэрээ бүртгэсэн мэдээлэл

Д.д	Компанийн нэр	2023 он			2024 он		
		Гэрээний тоо			Гэрээний тоо		
		Бүртгэвэл зохих	Бүртгэсэн	Хувь	Бүртгэвэл зохих	Бүртгэсэн	Хувь
1	Эрдэнэс Монгол ХХК	13	13	100	20	20	100.0
2	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	767	764	100	892	890	99.8
3	Эрдэнэс критикал минералс ТӨҮГ	215	215	100	163	163	100.0
4	Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХХК	151	112	74	186	94	50.5
5	Эрдэнэс оюу толгой ХХК	-	-	-	7	7	100.0
6	Эрдэнэс алт ресурс ХХК	3	2	67	68	68	100.0
7	Эрдэнэс ҮТП ХХК	-	-	-	6	2	33.3
8	Эрдэнэс Тавантолгой ХК	158	134	85	215	135	62.8
9	Багануур ХК	140	0	0	127	1	0.8
10	Шивээ овоо ХК	114	77	68	140	120	85.7
11	Цемент шохой ХХК	118	0	0	73	0	0.0
12	Эрдэнэс Баянбогд ХХК	2	1	50	2	2	100.0
13	Таван толгой ХК	40	27	68	54	46	85.2
НИЙТ		1,721	1,345		1,953	1,548	

Эх сурвалж: Цахим систем

2.30. Цахим системд гэрээний хэрэгжилтийг /гэрээ дүгнэсэн акт/ бүртгэсэн байдлыг авч үзэхэд 2024 онд “Шивээ-Овоо” ХК, “Эрдэнэс Критикал минералс” ТӨҮГ, “Эрдэнэс монгол” ХХК, “Эрдэнэс Тавантолгой” ХК-иуд дутуу, бусад компаниуд огт бүртгээгүй буюу 1.8 хувьтай байна.

2.31. Иймд ТБОНӨХБАҮХАТХуулийн 39 дүгээр зүйлийн 39.4-т "Захиалагч худалдан авах гэрээ, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг цахим системд бүртгэж, олон нийтэд нээлттэй байршуулна", Сангийн сайдын 2023 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан "Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам"-ын 2.2.8¹⁹, 5.5-д²⁰, Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 3.9²¹, 3.10²², Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар батлагдсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын 8.5²³-д заасныг хэрэгжүүлж ажиллаагүй тул албан шаардлага хүргүүлэв.

2.32. Аудитын явцад “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК-иуд цахим системд гэрээг бүрэн бүртгэж, “Эрдэнэс ҮТП” ХХК гэрээ болон гэрээний хэрэгжилт, гэрээ дүгнэсэн актыг бүрэн бүртгэж зөрчлийг арилгасан.

2.33. Дээрх 13 компаниас 2023 онд 6 компанийн 342 тендерийн гэрээ, 2024 онд 8 компанийн 759 тендерийн гэрээг тус тус гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш хуульд заасан хугацаанд байгуулаагүй байна.

Хүснэгт 6. Шалгарсан компанитай гэрээ хугацаандаа байгуулаагүй талаарх мэдээлэл

¹⁹ “худалдан авах гэрээнд орсон нэмэлт, өөрчлөлтийг цахим системд бүртгэх, гэрээний хэрэгжилт, гэрээ дууссаны дараа хүлээн авсан актыг тухай бүр цахим системд нийтлэх”
²⁰ “Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний хувийг захиалагч цахим системд байршуулна”
²¹ “Шууд худалдан авалт хийсэн захиалагч тухайн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, гэрээний үнийн дүнг цахим системд оруулсан байна”
²² “Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг тухай бүр цахим системд оруулаагүй тохиолдолд цахимд системд мэдээлэл нэгтгэгдэхгүй ба энэ журмын 2.16-д заасан этгээд захиалагчийн төлөвлөгөөний биелэлт, холбогдох мэдээллийг тухай бүр оруулсан эсэхэд хяналт тавина”
²³ Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний хувийг захиалагч гэрээ байгуулсан даруйд цахим системд байршуулна,

Д.д	Компанийн нэр	Тендерийн тоо	
		2023 он	2024 он
1	Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХХК	8	27
2	Тавантолгой ХК	4	6
3	Шивээ-Овоо ХК	9	10
4	Эрдэнэс критикал минералс ТӨҮГ	43	24
5	Эрдэнэс Таван толгой ХК	22	73
6	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	256	599
7	Эрдэнэс алт ресурс ХХК	-	19
8	Эрдэнэс Оюу толгой ХХК	-	1
	НИЙТ	342	759


Эх сурвалж: Цахим систем

2.34. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХуулийн /хуучин/ 29 дүгээр зүйлийн 29.2-т "Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 6-аас доошгүй өдрийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулна", шинэчилсэн хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-д "Шалгарсан оролцогч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын зургаагаас доошгүй өдрийн дараа, захиалагчаас тогтоосон хугацаанд багтаан гэрээг баталгаажуулж, эх хувиар, эсхүл цахим системээр захиалагчид хүргүүлнэ" гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.35. Иймд тендер шалгаруулалтай холбоотой захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний хувийг захиалагч гэрээ байгуулсан даруйд цахим системд байршуулж хэвших, гэрээг хуульд заасан хугацаанд байгуулж ажиллах нь зүйтэй байна.

2.36. Дээрх 13 компанийн шилэн данс цахим хуудаст мэдээлсэн, цахим системд (tender.gov.mn) нийтэлсэн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төсөвт өртгийн мэдээлэл 2023 онд 3,083.5 тэрбум төгрөг, 2024 онд 6,694.5 тэрбум төгрөгөөр тус тус зөрүүтэй, 2023 онд шилэн данс цахим хуудаст "Эрдэнэс Алт Ресурс" ХХК, "Эрдэнэс ҮТП" ХХК, "Тавантолгой" ХК нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг мэдээлээгүй байна.

Дүрслэл 3. Компаниудын шилэн данс, цахим системд нийтэлсэн ХАА-ны төлөвлөгөөний мэдээлэл



Эх сурвалж: Цахим систем, шилэн дансны мэдээлэл

2.37. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", 5 дугаар зүйлийн 5.1.4-т "мэдээллийг тогтмол шинэчилж байх, өөрчлөлт орсон тухай бүр өмнөх мэдээллийг цахим хуудасны архивд хадгалах, архивын мэдээллийн санд нэвтрэх, татаж авах, хэвлэх боломжтой байх", ТБОНӨХБАҮХАТХуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т "Цахим системд мэдээллийг нээлттэй өгөгдөл хэлбэрээр хадгална" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

2.38. Шилэн данс цахим хуудаст байршуулсан мэдээлэл шаардлага хангахуйц бус дутуу, иж бүрэн бус, хуульд заасан хугацаанд байршуулаагүй, төлөвлөгөөний өөрчлөлтийг оруулах боломжгүй, цахим системд (tender.gov.mn) ХАА-ны төлөвлөгөөний өөрчлөлт болон тайланг ил

тод байршуулахгүй байгаа нь компаниудын үр ашиггүй зарцуулалтыг хянах боломжийг хязгаарласан байна.

2.39. ОУ-ын туршлагаас харахад ТӨК-ийн ил тод байдлыг хангах хууль, эрх зүйн зохицуулалт болон зөвлөмж, стандартуудыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд хяналт тавих механизм гол хөшүүрэг болдог.

2.40. Иймд Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, Шилэн данс цахим хуудас хооронд интеграци хийх боломжийг судалж хэрэгжүүлэх, мэдээлэл иж бүрэн, үнэн зөв, ил тод, уялдаатай байхад анхаарч ажиллах, холбогдох хууль, журмын дагуу хяналтын механизмыг сайжруулах нь зүйтэй байна.

2.41. Аудитын явцад авсан цахим системийн ашиглалт, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаагаар цахим системийн ил тод байдал, түүний хэрэгжилтийн талаар дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:



Сэтгэл ханамжийн судалгаа 6.

Оролцогчдын 25.5 хувь ил тод байдал хангалтгүй эсвэл ойлгомжтой бус байна гэж хариулсан нь үнэлгээний тайлан, онооны мэдээлэл, шалгаруулалтын явц болон шийдвэр гаргалтын тайлбарын бүтэц, байршуулалт, логик уялдаа зэрэг мэдээллийн хүртээмж системийн хэмжээнд жигд бус, ойлгомжгүй байгаа тул ил тод байдлыг бүхэлд нь сайжруулах шаардлагатайг харуулж байна

ТХААГ, захиалагч талуудын хамтын ажиллагаа, хариуцлагын тогтолцоо дутмаг байгаа нь цахим дэлгүүрийн ашиглалт, ерөнхий гэрээний хэрэгжилт хангалтгүй байхад нөлөөлж байна

2.42. Ерөнхий гэрээний аргаар зохион байгуулах худалдан авах ажиллагаа нь байнгын хэрэгцээтэй бараа, үйлчилгээг худалдан авахад чиглэгддэг хоёр үе шаттай цахим процесс юм. Эхний шатанд ТХААГ шаардлага хангасан нийлүүлэгчдийг сонгон шалгаруулж, "Цахим дэлгүүр"-т бүртгэдэг. Хоёрдугаар шатанд захиалагч нь уг цахим дэлгүүрт бүртгэгдсэн нийлүүлэгчдээс "Шууд сонголт", "Цахим үнэ хаялцуулах", "Үнийн санал авах" зэрэг аргуудын аль тохирохыг сонгон, Ерөнхий гэрээний дагуу худалдан авах гэрээг байгуулан ажилладаг. Ерөнхий гэрээний аргаар зохион байгуулах худалдан авах ажиллагааны үйл явцын процессын зураглалыг хавсралт 7-оос үзнэ үү.

2.43. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 460 дугаар тогтоолоор 12 нэр төрлийн бараа, үйлчилгээг, 2024 оны 162 дугаар тогтоолоор 21 нэр төрлийн бараа, үйлчилгээг ерөнхий гэрээний аргаар зохион байгуулж, цахим дэлгүүрээс худалдан авахаар тус тус баталсан байна.

2.44. Цахим системд улсын хэмжээнд 2023 онд 1,153 захиалагч, 175 нийлүүлэгч, 2024 онд 1,067 захиалагч, 206 нийлүүлэгч бүртгэлтэй байна. Цахим дэлгүүрт 2023 онд 309, 2024 онд 359 нэр төрлийн бараа, үйлчилгээ байршжээ.

2.45. Улсын хэмжээнд захиалагч байгууллагууд цахим дэлгүүрээс 2023 онд 11,000, 2024 онд 9,700 захиалга хийж, нийтдээ 2023 онд 60.8 сая ширхэг, 2024 онд 86.5 сая ширхэг бараа, үйлчилгээг худалдан авсан байна. Худалдан авалтын үнийн дүн 2023 онд 1,402.2 тэрбум төгрөг, 2024 онд 431.5 тэрбум төгрөг болж, үүнээс 2023 онд 589.0 тэрбум төгрөг, 2024 онд 109.3 тэрбум төгрөгийн тендерийн хэмнэлт гарсан байна.

2.46. Харин 13 компанийн хувьд 2023 онд нийт 228.0 мянган ширхэг бараа, үйлчилгээг 1.9 тэрбум төгрөгөөр захиалж, нийлүүлэгчээс 1.9 тэрбум төгрөгөөр худалдан авснаар 91.8 сая төгрөг, 2024 онд 552.4 мянган ширхэг бараа, үйлчилгээг 13.5 тэрбум төгрөгөөр захиалж,

нийлүүлэгчээс 12.9 тэрбум төгрөгөөр худалдан авч, нийт 636.6 сая төгрөгийн тендерийн хэмнэлт гаргаж үр ашигтай ажилласан байна.

2.47. Аудитаар тайлант хугацаанд 13 компанийн ерөнхий гэрээний аргаар цахим дэлгүүрээс худалдан авсан болон худалдан авах боломжтой байсан бараа, үйлчилгээг (нүүрс тээврийн үйлчилгээ ороогүй) түүвэрлэж тоймлон үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт 7. Компаниудын цахим дэлгүүрээс худалдан авсан болон худалдан авах боломжтой байсан бараа, үйлчилгээний мэдээлэл сая төгрөг

Д.д	Компанийн нэр	Худалдан авсан		Худалдан авах боломжийн тооцоо	
		2023 он	2024 он	2023 он	2024 он
1	Багануур ХК	5.8	-	3,946.5	17,818.5
2	Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХХК	3.3	149.8	9,936.7	26,090.5
3	Таван толгой ХК	-	-	907.9	1,802.8
4	Цемент шохой ХХК	-	-	7,233.7	4,542.5
5	Шивээ-Овоо ХХК	3.3	4.2	10,008.0	7,680.3
6	Эрдэнэс Алт Ресурс ХХК	-	0.6	-	3,413.6
7	Эрдэнэс Баянбогд ХХК	-	-	390.9	155.0
8	Эрдэнэс критикал минералс ТӨҮГ	1.9	48.6	12,092.6	14,082.4
9	Эрдэнэс Монгол ХХК	343.0	258.4	753.6	3,973.1
10	Эрдэнэс Оюу Толгой ХХК	-	53.8	-	434.8
11	Эрдэнэс Тавантолгой ХК	558.5	1205.1	24,467.4	172,899.4
12	Эрдэнэс УТП ХХК	64.5	52.3	-	204.3
13	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	892.4	11,519.6	115,015.6	140,378.1
Нийт		1,897.9	12,949.9	183,999.4	389,297.9

Эх сурвалж: Цахим систем, МУЗГ-ын 2022 оны 460, 2024 оны 162 дугаар тогтоол, аудитын багийн тооцоо

2.48. Хүснэгтээс харахад компаниуд 2023 онд 1.9 тэрбум төгрөг, 2024 онд 7 нэр төрлийн 12.9 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй бараа, үйлчилгээг цахим дэлгүүрээс худалдан авсан байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 4, 5-с үзнэ үү/

2.49. Үүнээс 2023 онд эм, эмийн хэрэгсэл, дотоодод үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн, хөдөлмөр хамгаалал, нормын хувцас, байнгын хэрэгцээтэй тоног төхөөрөмж, программ хангамжийн үйлчилгээнээс худалдан авалт хийсэн бол бичгийн цаас, бичгийн хэрэгсэл, ариутгал, халдваргүйжүүлэлтийн түүхий эд, материал, даатгалын үйлчилгээг цахим дэлгүүрээс огт худалдан аваагүй байна.

2.50. Харин 2024 онд импортын зарим хүнсний бүтээгдэхүүн, хор саармагжуулах хүнсний бүтээгдэхүүн, худалдан авалт шинээр нэмэгдсэн бөгөөд хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд шаардлагатай үндсэн болон туслах тоног төхөөрөмж, сэлбэг, эд анги, хөдөлмөр хамгааллын гутал, хувцас, хэрэгсэл, монгол гэр, гэрийн иж бүрдэл, туулах чадвар сайтай автомашин, уул уурхайн салбарын тоног төхөөрөмж, сэлбэг, дагалдах хэрэгсэл, даатгалын үйлчилгээг ерөнхий гэрээний аргаар худалдан аваагүй байна.

2.51. 13 компани 2023 онд 4 нэр төрлийн 183.1 тэрбум төгрөг, 2024 онд 12 нэр төрлийн 387.5 тэрбум төгрөгийн дүнтэй бараа, үйлчилгээг цахим дэлгүүрээс худалдан авах боломжтой байсныг түүвэрлэн тооцвол дээрх нийт худалдан авалт нь 2023 онд 9.1 хувь, 2024 онд 3.3 хувьтай байгаа нь хангалтгүй байна.

2.52. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХуулийн /хуучин/ 8 дугаар зүйлийн 8.13-т “Ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авах бараа, үйлчилгээг цахим дэлгүүрт байршуулснаас өөр этгээдээс худалдан авахыг хориглоно”, шинэчилсэн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-т “Энэ хуулийн 37.2.4-т зааснаар захиалагч нь ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авна”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ", 14.2-т "Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-д зааснаар хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ", 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад

этгээдээс худалдан авахыг хориглоно", мөн хуулийн 38 дугаар зүйлийн 38.7-д "Бараа, үйлчилгээг ерөнхий гэрээний аргаар худалдан авах тендер шалгаруулалтын аргачлал, зааврыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална" гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.53. Дээрх судалгаанаас дүгнэн үзэхэд ТХААГ болон захиалагч талуудын хамтын ажиллагаа, хариуцлагын тогтолцоо дутмаг байгаа нь цахим дэлгүүрийн ашиглалт, ерөнхий гэрээний хэрэгжилт хангалтгүй байхад нөлөөлж байна.

2.54. Иймд холбогдох төрийн байгууллага болон компаниуд холбогдох хууль, журамд заасны дагуу Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг бүрэн хангаж, хоорондоо харилцан уялдаж, санаачилгатай ажиллаж, цахим дэлгүүрийн ашиглалтыг сайжруулах шаардлагатай байна.

2.55. Мөн дээрх тогтоолд зааснаар нүүрс тээврийн үйлчилгээг "Эрдэнэс Тавантолгой" ХК, "Тавантолгой" ХК-иуд цахим дэлгүүрээр ерөнхий гэрээний аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна.

2.56. "Эрдэнэс Тавантолгой" ХК 2023 онд 3.5 сая тонн нүүрсийг 123.7 тэрбум төгрөгөөр, 2024 онд 26.6 сая тонн нүүрсийг 464.8 тэрбум төгрөгөөр тус тус тээвэрлэсэн байна. Гэвч ТБОНӨХБАҮХАТХуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т "Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ерөнхий гэрээний аргаар худалдан авах бараа, үйлчилгээг тусгасан байна" гэсэн заалтын дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй, цахим системд баталгаажуулаагүй байна.

2.57. Засгийн газрын 2025 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн хуралдаанаар "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн нууцад хамаарч байсан 2010 оноос хойших 581 нүүрс худалдах, худалдан авах гэрээнүүдийг ил болгох шийдвэр гаргасан. Эдгээр гэрээнүүд нь тус аудитын багаас гүйцэтгэсэн Төрийн өмчит уул уурхайн компаниудын төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалт, үр дүн сэдэвт гүйцэтгэлийн аудитад агуулга, зорилт, хамрах хүрээгээр хамаарахгүй боловч Засгийн газрын шийдвэрээр ил болсноор цаашид Үндэсний Аудитын газраас санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитаар гэрээний хэрэгжилт, үр дүнд хөндлөнгийн хяналт хийгдэх, дүгнэлт гаргах боломж бүрдсэн байна.

2.58. 2023 онд "Тавантолгой" ХК цахим системд 4.3 сая тонн нүүрс тээвэрлэхээр 130 захиалга бүртгүүлж, 30 компани шалгарснаас, гүйцэтгэлээр 32 компанитай гэрээ байгуулж, нийт 3.3 сая тонн нүүрсийг 203.4 тэрбум төгрөгөөр тээвэрлэсэн байна. 2024 онд цахим системд 4.4 сая тонн нүүрс тээвэрлэхээр 142 захиалга бүртгүүлж, 56 компани шалгарснаас, гүйцэтгэлээр 31 компанитай гэрээ байгуулж, нийт 2.5 сая тонн нүүрсийг 222.2 тэрбум төгрөгөөр тээвэрлэсэн байна.

2.59. Гэтэл дараах компаниудтай цахим системээр ерөнхий гэрээний аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна. Үүнд:

- ✓ **2023 онд "Азура энерги" ХХК-тай** ТГ/2023/016 дугаартай 9590,9 тонн нүүрс тээвэрлэхээр 44.9 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээ байгуулсан,
- ✓ **2024 онд "Бүндэр" ХХК-тай** ТГ/2024/103 дугаартай 20,000 тонн нүүрс тээвэрлэхээр 1,120.0 сая төгрөгийн дүнтэй гэрээ байгуулсан,
- ✓ **"Завхан Транс Нэгдэл" ХХК-тай** ТГ/2024/063 дугаартай 10,000 тонн нүүрс тээвэрлэхээр 478.0 сая төгрөгийн дүнтэй гэрээ байгуулсан,
- ✓ **"Шанхай Ажнай" ХХК-тай** ТГ/2024/073 дугаартай 20,000 тонн нүүрс тээвэрлэхээр 798.0 сая төгрөгөөр, ТГ/2024/104 дугаартай 10,000 тонн нүүрс тээвэрлэхээр 399.0 сая төгрөгөөр, ТГ/2024/050 дугаартай 10,000.0 тонн нүүрс тээвэрлэхээр 399.0 сая төгрөгийн дүнтэй гэрээ байгуулсан,
- ✓ **"Ар Чавчар" ХХК-тай** ТГ/2024/070 дугаартай 20,000 тонн нүүрс тээвэрлэхээр 798.1 сая төгрөгийн дүнтэй гэрээ тус тус байгуулан ажил гүйцэтгэсэн байна. Нийт 99.6 мянган тонн нүүрс тээвэрлэхээр 4,037.1 сая төгрөгийн дүнтэй тус тус гэрээ байгуулж, ажил гүйцэтгэсэн.

2.60. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-т "Энэ хуулийн 37.2.4-т зааснаар захиалагч нь ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авна", 37 дугаар зүйлийн 37.1.2-т "хоёрдугаар үе

шатанд захиалагч бараа, үйлчилгээг үнийн санал дуудаж цахим дэлгүүрээс худалдан авах.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн тул албан шаардлага хүргүүлэв.

2.61. Эндээс үзэхэд тайлант хугацаанд төлөвлөсөн тендерийн 75.0 хувийг цахимаар зарласан, гэрээний бүртгэл дунджаар 78.7 хувь, гэрээ дүгнэсэн актын бүртгэл 1.8 хувь, цахим хуудас, цахим системд нийтэлсэн мэдээлэл зөрүүтэй, цахим дэлгүүрийн ашиглалт дундаж 6.2 хувь, бараа, ажил, үйлчилгээний цахим каталог хөгжүүлээгүй, "худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын Маягт 1, 2-ыг нэгтэн тайлагнах, цахим системд эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг цахим системд тайлагнах, "Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар"-ын Маягт 1-10-ын мэдээллийг автоматаар үүсгэх хөгжүүлэлт хийгдээгүй, тендер шалгаруулалттай холбоотой гомдлын мэдээллийг цаасаар хүлээн авч байгаа нь цахимжилт хангалтгүй байгааг харуулж байна.

2.62. Гэтэл ОУ-ын туршлагаас харахад БНСУ-ын төрийн цахим худалдан авалтын тогтолцоо нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендер, гэрээ, төлбөрийн бүх үе шатыг нэг цонхоор бүрэн цахимжуулж, 225 мэдээллийн сантай автомат холболтоор шаардлагатай бүх баталгаажуулалтыг хүндрэлгүй гүйцэтгэж байна.

Шигтгээ 3. БНСУ-KONEPS нь нийлүүлэгчийг нэг удаагийн бүртгэлээр бүх тендерт оролцох боломжтой болгож зардал-цагийн хэмнэлт бий болгон, татвар-банк-даатгалын системтэй уялдсан цахим төлбөрийн горимоор нийлүүлэлтийн дараах 4 цагийн дотор төлбөр олгох орчныг бүрдүүлж, PKI ба давхар нөөцлөлттэй архитектураар 24/7 найдвартай ажиллагааг ханган, худалдан авалтын мэдээллийг бодит хугацаанд нийтэлж аудит-хяналтын байгууллагуудтай шууд мэдээлэл солилцдог бөгөөд үүний үр дүнд жил бүр 3.2 их наяд воны хэмнэлтийг улсын хэмжээнд бий болгосон цахим худалдан авалтын дэлхийн жишиг загвар юм.

Цахим системийн үйл ажиллагаа, ашиглалтын байдалд дотоод хяналтын механизм үр дүнгүй байгаагаас худалдан авах ажиллагаанд үүсэх эрсдэлийг тодорхойлох боломжгүй байна

2.63. Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 16.5.6-д "Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасан боловч ТХААГ-ын бүтцэд 2023-2024 онуудад Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс бие даан үйл ажиллагаа явуулж байсан хэдий ч дотоод хяналтын үйл ажиллагааг орхигдуулсан байна.

2.64. Монгол Улсын шадар сайдын 2025 оны 54 дүгээр тушаалаар ТХААГ-ын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг баталсан. Уг хөтөлбөрт Засгийн газрын тогтоол шийдвэр, худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргахаар тусгасан хэдий ч дотоод аудитын үйл ажиллагааг мөн орхигдуулсан.

2.65. Төрийн болон орон нутгийн өмчит уул уурхайн компаниудад үйл ажиллагааны чиглэл, хамрах хүрээнээс шалтгаалан хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын чиглэлээр ажлын хэсэг, албан хаагч болон нэгж ажиллаж байна.

Хүснэгт 8. Компанийн дотоод хяналтын чиг үүрэг бүхий нэгжийн судалгаа

Д.д	Компанийн нэр	Хяналтын чиг үүрэг бүхий нэгжийн нэр	Орон тоо
1	Багануур ХК	Дотоод хяналт шалгалтын алба	-
2	Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХХК	Дотоод хяналтын хэлтэс	8
3	Таван толгой ХК	Дотоод хяналтын хэлтэс	5
4	Цемент шохой ХХК	Дотоод хяналт, шинжилгээ, үнэлгээ, эрсдэлийн удирдлагын хэлтэс	3
5	Шивээ-Овоо ХХК	Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын алба	7

6	Эрдэнэс Алт Ресурс ХХК	Дотоод хяналтын алба	2
7	Эрдэнэс Баянбогд ХХК	Дотоод хяналт хэрэгжүүлэх ажлын хэсэг	4
8	Эрдэнэс Монгол ХХК	Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газар	9
9	Эрдэнэс критикал минералс ТӨҮГ	Дотоод хяналт, мониторингийн хэлтэс	5
10	Эрдэнэс Оюу Толгой ХХК	Дотоод хяналт, эрсдэл хариуцсан мэргэжилтэн	1
11	Эрдэнэс Тавантолгой ХК	Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газар	-
12	Эрдэнэс УТП ХХК	Дотоод хяналтын алба	2
13	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	Дотоод хяналт, мониторингийн хэлтэс	-

Эх сурвалж: Компаниудын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн тушаал, шийдвэр

2.66. Байгууллагууд жил, жилийн гүйцэтгэлийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахдаа худалдан авах ажиллагааны цахим системд дотоод хяналт, хяналтын механизм үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэлээр үйл ажиллагааг оновчтой тусгаагүй, хэрэгжилт хангалтгүй байна. Энэ нь хяналтын чиг үүрэг бүхий нэгжүүдэд худалдан авах ажиллагааны цахим системээр мэргэшсэн хүний нөөц дутмаг бөгөөд албан хаагчдыг энэ чиглэлээр сургах, мэргэшүүлэх асуудал дутмаг байгаатай холбоотой байна.

2.67. Мөн 2023, 2024 онуудад цахим системд дотоод хяналт үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэхэд Төсвийн ерөнхийлөн захирагч (Монгол Улсын шадар сайд) болон Сангийн яамны зүгээс дотоод хяналт хийж, хяналт тавьж, дүн шинжилгээ хийгдээгүй байна.

2.68. Эндээс үзэхэд цахим системийн дотоод хяналт, хяналтын механизм үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэлээр байгууллагууд үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлээгүй, хүний нөөцийн бодлого дутмаг, үйл ажиллагааны чиглэл тодорхой бус байна.

2.69. Иймд цахим системд дотоод хяналт, хяналтын механизм үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой ажлыг байгууллагын төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг хангаж хэвших, хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий албан хаагчдыг цахим систем, түүний хяналтын чиглэлээр мэргэшүүлэх, сургах, давтан сургах, хүний нөөцийг бүрдүүлэх бодлого, чиглэлийг тодорхойлж, хэрэгжилтийг хангах нь зүйтэй байна.

2.70. Аудитаар нийт 6,088.5 сая төгрөгийн дүнтэй 82 зөрчил илрүүлснээс 59 зөвлөмж, 564.8 сая төгрөгийн дүнтэй 3 төлбөрийн акт, 5,523.7 сая төгрөгийн дүнтэй 17 албан шаардлага хүргүүлээ.

Хүснэгт 9. Аудитаар илрүүлсэн алдаа зөрчлийн бүртгэлийн нэгтгэл

сая төгрөг

Д/д	Байгууллага, ААН-ийн нэр	Нийт зөрчлийн дүн		Үүнээс,					
				Зөвлөмж өгсөн		Төлбөрийн акт тогтоосон		Албан шаардлага өгсөн	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
1	Сангийн сайд	3	-	2	-	0	-	1	-
2	ТХААГ	11	2,010.4	7	-	1	523.7	3	1,486.7
3	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	7	-	6	-	0	-	1	-
4	Эрдэнэс Тавантолгой ХК	4	28.7	2	-	1	28.7	1	-
5	Эрдэнэс Баянбогд ХХК	4	-	3	-	0	-	1	-
6	Эрдэнэс Монгол ХХК	6	-	5	-	0	-	1	-
7	Эрдэнэс алт ресурс ххк	4	-	3	-	0	-	1	-
8	Дарханы төмөрлөгийг үйлдвэр ХХК	6	-	5	-	0	-	1	-
9	Эрдэнэс критикал минералс ТӨҮГ	4	-	3	-	0	-	1	-
10	Тавантолгой ХК	7	4,037.1	5	-	0	-	2	4,037.1
11	Багануур ХК	6	12.4	4	-	1	12.4	1	-
12	Эрдэнэс УТП ХХК	3	-	2	-	0	-	0	-
13	Цемент шохой ХХК	6	-	5	-	0	-	1	-
14	Шивээ овоо хк	5	-	4	-	0	-	1	-
15	Эрдэнэс Оюу толгой ХХК	4	-	3	-	0	-	1	-
	Дүн	79	6,088.5	59	0	3	564.8	17	5,523.7

Эх сурвалж: Аудитын баг

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, хийсэн дүн шинжилгээ, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.Үүнд:

1. Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд туссан ногоон худалдан авалтыг үе шаттай нэвтрүүлэх, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, цахимжилт болон дэвшилтэт технологийг ашиглан ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилтын хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна.
2. Төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх этгээдийг Засгийн газар тогтоож, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудад хувьцаа эзэмшигчийн эрхийг шилжүүлснээр Төрийн өмчийн бодлого хэрэгжүүлэгч болон өмчийн төлөөлөгчийн чиг үүрэг хэрэгжихгүй, холбогдох хууль, дүрэм давхардсан байгаа нь уул уурхайн төрийн өмчит компаниудын төсөв, хөрөнгө, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаанд төрөөс хэрэгжүүлэх нэгдсэн бодлого, хяналт, шийдвэр гаргалтад нөлөөлж байна.
3. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн дэд бүтцийн тогтвортой байдал хангагдаагүй, хэрэглэгчийн эрхийн удирдлага, нууцлал, бүртгэл, олон шатлалт баталгаажуулалт, системийн дотоод хяналт хангалтгүй, мэргэшсэн боловсон хүчний нөөц дутмаг зэрэг нь системийн найдвартай ажиллагаа, мэдээллийн аюулгүй байдлыг хангахад сөргөөр нөлөөлж байна.
4. Цахим системийн ашиглалттай холбогдох хууль, журмыг бүрэн мөрдөж ажиллаагүй, систем хооронд уялдаагүй байгаа нь олон нийт үнэн зөв, иж бүрэн, ил тод мэдээллээр бүрэн хангагдахгүй байна.
5. ТХААГ, захиалагч талын хамтын ажиллагаа, хариуцлагын тогтолцоо дутмаг байгаа нь цахим дэлгүүрийн ашиглалт, ерөнхий гэрээний хэрэгжилт хангалтгүй байхад нөлөөлж байна.
6. Цахим системийн үйл ажиллагаа, ашиглалтын байдалд дотоод хяналтын механизм үр дүнгүй байгаа нь худалдан авах ажиллагаанд үүсэх эрсдэлийг тодорхойлох боломжгүй нөхцөлийг үүсгэж байна.
7. Төлөвлөсөн тендерийн 75.0 хувийг цахимаар зарласан, гэрээний бүртгэл дунджаар 78.7 хувь, гэрээ дүгнэсэн актын бүртгэл 1.8 хувь, цахим хуудас, цахим системд нийтэлсэн мэдээлэл зөрүүтэй, цахим дэлгүүрийн ашиглалт дундаж 6.2 хувьтай, бараа, ажил, үйлчилгээний цахим каталог хөгжүүлээгүй, “худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын Маягт 1, 2-ыг нэгтэн тайлагнах, цахим системд эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг цахим системд тайлагнах, “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ын Маягт 1-10-ын мэдээллийг автоматаар үүсгэх хөгжүүлэлт хийгдээгүй, тендер шалгаруулалттай холбоотой гомдлын мэдээллийг цаасаар хүлээн авч байгаа зэрэг нь цахимжилт хангалтгүй байгааг харуулж байна.
8. Аудитаар цахим системийн ашиглалт, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаагаар (tender.gov.mn)-ийн цахим системд нэн түрүүнд хийх шаардлагатай шинэчлэл нь мэдээллийн ил тод байдал, тогтвортой ажиллагааг сайжруулах, хэрэглэхэд энгийн, ойлгомжтой, хялбар, мэдээлэл байршуулах процессыг найдвартай болгох, техникийн тусламжийн шуурхай байдлыг нэмэгдүүлэх, сургалт, зааварчилгааны хүртээмжийг өргөтгөх, мөн системийг хууль тогтоомжийн өөрчлөлттэй уялдуулан хөгжүүлэлтийг шуурхай нэвтрүүлэх зүйтэй гэж дүгнэлээ.

ЗӨВЛӨМЖ

Аудитаар илрүүлсэн зүйл, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

1. Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд туссан зорилтыг бүрэн хангах ажлын хүрээнд дотоодын үйлдвэрлэлийн судалгаа, үндэслэлд суурилсан худалдан авалтыг өргөжүүлэх, ногоон худалдан авалтыг нэмэгдүүлэх, цахимжуулалт болон хиймэл оюун ухаанд суурилсан системийг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх;
2. Цахим системийн дэд бүтцэд иж бүрэн техникийн шинэчлэлтийг хийх, бэлэн байдлын шийдэл болон гүйцэтгэлийн мониторинг нэвтрүүлэх, мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог ISO/IEC 27001 стандартад нийцүүлэн бүрдүүлж, мэргэшсэн хүний нөөцийг нэмэгдүүлэх, хэрэглэгчийн эрхийн матриц, үүрэгт суурилсан хандалтын хяналт, олон шатлалт баталгаажуулалт, эрх хаах автомат процессыг нэвтрүүлэх, нөөц механизмыг бий болгож, нэгдсэн хяналт тавьж ажиллах;
3. Худалдан авах ажиллагаанд оролцогч талууд худалдан авах ажиллагаатай холбоотой хууль журмын хэрэгжилтийг бүрэн хангаж, системийн хөгжүүлэлт, шинэчлэлт, сайжруулалт, систем хоорондын уялдааг хангах, мэдээллийг тогтмол, иж бүрэн, үнэн зөв, ил тод байршуулахад анхаарч, дотоод хяналтын механизмыг үр дүнтэй хэрэгжүүлэх;

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад:

1. Төрийн өмчит хуулийн этгээдийн төрийн өмчийн бодлого, төрийн төлөөлөл хэрэгжүүлэх нэгдмэл бодлогыг хэрэгжүүлэх, төрийн өмчит, өмчийн оролцоотой хувьцаат, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэмд төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч этгээд болон төрийн зохицуулалтын чиг үүргийн зааг ялгааг тодорхой тусгаж, холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэх;

Сангийн сайдад:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.8 дах заалтыг мөрдөж, хүний нөөцийг оновчтой удирдан зохион байгуулж, хуулийн хугацаанд гомдлыг шийдвэрлэн ажиллах;
2. Шилэн данс цахим хуудас болон Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем хооронд уялдааг хангах, Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын "худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан"-ийн Маягт 1, 2-т захиалагч байгууллага, ТЭЗ, улсын хэмжээний мэдээллийг нэгтэн тайлагнаж, дүн шинжилгээ хийдэг байхаар боловсруулж, мөрдүүлэх, төлөвлөгөөний өөрчлөлтийг нэмэлт маягтаар оруулах, төрийн худалдан авах ажиллагааны цахим системд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.10-т заасны дагуу тайланг оруулдаг байх;

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргад:

1. Төрийн өмчит хуулийн этгээдийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, өмнөх тайлант хугацааны үр дүнд шинжилгээ хийхэд нэгдсэн арга зүйгээр хангах, санхүүгийн шинжилгээнд үндэслэн гаргасан төсөв, төлөвлөгөөг хянаж, батлах, төрийн өмчит уул уурхайн хуулийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг шинээр авах шийдвэр гаргах зэрэг хуульд заасан бусад үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллах;

Төрийн худалдан авах ажиллагааны газрын даргад:

1. Цахим системийн тасралтгүй ажиллагаа, сэргээн босголтын төлөвлөгөөг боловсруулж батлах, жил бүр бодит туршилт хийж шинэчлэх механизмыг хэрэгжүүлэх, нөөц сервер, илүүдэл холболт, ачаалал тэнцвэржүүлэгчийн техникийн шийдлийг нэвтрүүлж, туршилтын үр дүнг баримтжуулан дүгнэх тогтолцоог бүрдүүлэх, сэргээх ажиллагааны протокол, өөрчлөлтийн бүртгэлийн болон лог-мониторингийн хяналтыг бүрдүүлж, тасалдлын шалтгаан, хариу арга хэмжээг задлан шинжлэх, баримтжуулах аргачлал нэвтрүүлэх;
2. Жил бүр мэдээллийн аюулгүй байдлын сургалтыг төлөвлөгөөнд тусгаж, байгууллагын бүх техникийн болон удирдах ажилтныг хамруулах, нөөц инженер, мэдээллийн аюулгүй байдлын ажилтан томилж, орлох зохицуулалтын баримт бичиг боловсруулж батлах, ажилтнуудын мэргэжлийн түвшнийг дээшлүүлэх, олон улсын сургалт, сертификаттай (ISO/IEC 27001 тэргүүлэх аудитор гэх мэт) сургалтад үе шаттай хамруулах;
3. "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын Маягт 1, 2-ыг нэгтэн тайлагнах, цахим системд эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг цахим системд тайлагнах, "Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар"-ын Маягт 1-10-ын мэдээллийг автоматаар үүсгэх хөгжүүлэлт хийх;
4. Хэрэглэгчийн эрхийн матрицыг баталж, үүрэгт суурилсан хандалтын хяналтын дагуу эрх олгох, цуцлах үйл ажиллагааг журамлах, супер админ зэрэг өндөр түвшний эрхийг нэг хүнд ногдуулахгүй байх, ажил үүргийн хуваарилалтаар чиглүүлэн олгох, олон шатлалт баталгаажуулалт нэвтрүүлэх, хэрэглэгчийн үйлдлийн бүртгэлийг автоматаар тэмдэглэж, шинжлэх, хянах нэгдсэн системийг нэвтрүүлэх, эрхийн өөрчлөлт, олголт, цуцлалтын бүртгэлийг албан ёсны журмаар хөтлөх, эрхийн аудит хийж байх, ISO/IEC 27001:2023, Кибер аюулгүй байдлын нийтлэг журам, Сангийн сайдын А/248 тушаалын хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч, жил бүр хянан үнэлэх;
5. Худалдан авах ажиллагааны цахим системд дотоод хяналт, хяналтын механизм үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэлээр үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлэх, цахим систем, түүний хяналтын чиглэлээр мэргэшсэн хүний нөөцийн дутагдалтай, түүнийг бүрдүүлэх бодлого чиглэлийг тодорхой болгох;
6. Цахим системийн өөрчлөлт, шинэчлэлийн үйл явцыг хянах бүртгэлийг албан ёсоор хөтлөх, хууль, журмын өөрчлөлт бүрийг системийн хөгжүүлэлтэд тусгах, баталгаажсан протокол, туршилтын тайлангаар баримтжуулах, ISO/IEC 27001:2022 стандартад нийцсэн хяналтын үйл явцыг нэвтрүүлж, өөрчлөлтийн баталгаажуулалтад мэдээллийн системийн хяналтын багийн оролцоог нэмэгдүүлэх;
7. Цахим дэлгүүрийн бүртгэл, нийлүүлэгчийн тоо, бараа, үйлчилгээний нэр төрөл, ангиллыг өргөжүүлэх ажлыг эрчимжүүлэх, бараа, үйлчилгээний нэршлийг стандартчилах, нэгдсэн кодын систем нэвтрүүлэх замаар мэдээллийн уялдааг хангах, худалдан авах ажиллагаанд оролцогч талуудын дунд сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулах, цахим системийн ач холбогдлыг нэмэгдүүлэх;

Эрдэнэс Монгол ХХК-д:

1. Компанийн төсвийн төлөвлөлтөд арвилан хэмнэлттэй, үр ашигтай, хариуцлагатай байх зарчмыг баримтлан, нэгдсэн дүн шинжилгээ хийж ажиллах, бараа материалын нөөцийг удирдах нэгдсэн журмыг баталж мөрдөх, үнэ цэний бууралтыг тооцох талаар аргачлал боловсруулах, эдийн засгийн тооцоолол, үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагааны технологийн нормтой уялдуулан төлөвлөх, менежментийн үйлчилгээний гэрээний биелэлтийг дүгнэж, үр дүнг тооцох, нэгдлийн охин, хараат, харьяа компаниудыг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар бүрэн хангаж, хяналт тавьж ажиллах;

Уул уурхайн төрийн болон орон нутгийн өмчит компаниудад:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулах, Сангийн сайдын 2023 оны А/257, А/258, А/259, А/260, А/261, А/262 дугаар тушаалаар батлагдсан тендер шалгаруулалтын жишиг баримт бичгийн дагуу тендер шалгаруулалтын баримт бичгийг боловсруулах, үнэлгээний хороо, түүний үйл ажиллагаа, шийдвэрт тавих хяналтыг сайжруулах;
2. Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "мэдээллийг тогтмол шинэчилж байх, өөрчлөлт орсон тухай бүр өмнөх мэдээллийг цахим хуудасны архивд хадгалах, архивын мэдээллийн санд нэвтрэх, татаж авах, хэвлэх боломжтой байх" гэж заасны дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд орсон өөрчлөлтийг тухай бүр шилэн дансны цахим хуудас болон Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд иж бүрэн мэдээлж байх;
3. Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 1.3, 1.4, 2.2 дахь хэсгийг мөрдөн ажиллах, худалдан авах ажиллагааны батлагдсан төлөвлөгөө, Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд нийтэлсэн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө хооронд зөрүү үүсгэхгүй байхад анхаарч ажиллах;
4. "Захиалагчийн баталгаажуулах" эрхийг удирдлага солигдох бүрд админ эрхээр нэвтэрч шинэчлэн бүртгэж, хуучин эрхийг нэн даруй хүчингүй болгох, "Захиалагчийн админ" эрхийг өөрчлөх, шинэчлэхдээ Төрийн худалдан авах ажиллагааны газарт албан бичгээр хүсэлт гарган, эрхийг хугацаанд нь шинэчилж байх;
5. Тухайн оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй худалдан авах ажиллагааг зохион байгуулахгүй байх, өмнөх онд хэрэгжээгүй бараа, ажил, үйлчилгээг ач холбогдлоор нь эрэмбэлж, зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай эсэхийг тодорхойлсны үндсэн дээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байх;

Холбогдох байгууллагын санал:

	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР С.МАГНАЙСҮРЭН ТАНАА
МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД	
Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1, 4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот, Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn, Цахим хуудас: http://www.mof.gov.mn	
<u>2025.12.11</u> № <u>01/10833</u>	
танай _____-ны № _____-т	
Санал хүргүүлэх тухай	
Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны "Аудитын сэдэв батлах тухай" 2024 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов "Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай" 2024 оны А/108 дугаар тушаалыг тус тус үндэслэн "Төрийн өмчит уул уурхайн компаниудын худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалт, үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд санал, тайлбар авах тухай Танаас ирүүлсэн албан бичигтэй танилцлаа. Тайлангийн төсөлд тусгагдсан Сангийн яаманд холбогдуулан гаргасан зөвлөмжид дараах саналтай байна. Үүнд: 1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (2005 оны)-ийн 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсэгт заасан хугацаанд шийдвэрлээгүй гомдол 2023 онд гурав, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ (цаашид "хууль" гэх)-ийн 59 дүгээр зүйлийн 59.8 дахь хэсэгт заасан хугацаанд шийдвэрлээгүй гомдол 2024 онд 10 байсан талаар дурдсаны дагуу үзэхэд 2024 оны долоон гомдлыг Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам"-ын 5.12-т "Нэг тендер шалгаруулалттай холбоотойгоор хоёр ба түүнээс дээш этгээд хуулийн 28.1-д заасан шийдвэртэй холбоотой гомдол ирүүлсэн тохиолдолд гомдол хянан шийдвэрлэх хугацааг сүүлийн гомдол ирүүлсэн хугацаанаас тоолно." гэж заасны дагуу хугацаа тооцож хүргүүлсэн болно. 2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (2005 оны)-д зааснаар Ерөнхий гэрээ байгуулахыг журмаар зохицуулж байсныг 2023 онд батлагдсан хуулиар ерөнхий гэрээний аргатай холбоотой тусгайлсан зохицуулалтыг хуулийн 37, 38 дугаар зүйлд тодорхой тусгаж, тендер шалгаруулалтын жишиг баримт бичгийг хуулийн 38 дугаар зүйлийн 38.7 дахь хэсэгт "Бараа, үйлчилгээг ерөнхий гэрээний аргаар худалдан авах тендер шалгаруулалтын аргачлал, зааврыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална." гэж, 55 дугаар зүйлийн 55.1.3 дахь заалтад "худалдан авах ажиллагаатай холбоотой журам, аргачлал, заавар, тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг, гэрээний загварыг батлах;" гэж, 11 дүгээр зүйлийн 11.14 дэх хэсэгт "Тендер шалгаруулалтын баримт бичигт тусгах гэрээний жишиг нөхцөлийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална." гэж тус тус хуулиар эрх олгосон зохицуулалтын хүрээнд Сангийн сайдын 2023 оны А/262 дугаар тушаалын	

хавсралтаар "Ерөнхий гэрээний аргаар бараа, үйлчилгээ худалдан авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг"-ийг баталсан.

Ерөнхий гэрээний аргаар бараа, үйлчилгээ худалдан авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг нь тендер шалгаруулалтын зааварчилгаа, өгөгдлийн хүснэгт, техникийн тодорхойлолт, жишиг маягтууд, гэрээний нөхцөл гэсэн 5 бүлэгтэй. "Тендер шалгаруулалтын зааварчилгаа" гэсэн нэгдүгээр бүлэгт тендер шалгаруулалтын баримт бичиг боловсруулахаас эхлээд захиалагч шийдвэр гаргах, гэрээ байгуулах хүртэл алхам бүрээр зааварчилгааг зааснаас гадна сонирхогч этгээд, оролцогчийг тендер бэлтгэхтэй холбоотой зааварчилгаа, аргачлалаар хангасан хэсэг болно. "Өгөгдлийн хүснэгт" гэсэн хоёрдугаар бүлэгт худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагаас тухайн тендер шалгаруулалттай холбогдуулан оролцогч болон тендерт тавих шалгуур үзүүлэлт, мэдээллийг тендер шалгаруулалтын зааварчилгаанд нийцүүлэн заадаг. "Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага" гэсэн гуравдугаар бүлэгт худалдан авах барааны техникийн тодорхойлолт, үйлчилгээний тодорхойлолт болон тэдгээрт хамаарах мэдээллийг тусгадаг. "Тендерийн жишиг маягтууд" гэсэн 4 дүгээр бүлэгт оролцогч тендер бэлтгэхэд шаардлагатай жишиг маягтуудыг заасан бөгөөд оролцогч маягтын дагуу мэдээллээ бөглөж, тендер илгээдэг. "Гэрээний нөхцөл" гэсэн 5 дугаар бүлэгт худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага, ерөнхий гэрээний нийлүүлэгч аж ахуйн нэгж, захиалагч байгууллагын харилцааг тодорхойлсон гэрээний ерөнхий нөхцөл, гэрээний тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягтуудыг багтаасан байна.

Иймээс Сангийн сайдын 2023 оны А/262 дугаар тушаалын үндэслэх хэсэгт "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 38 дугаар зүйлийн 38.7 дахь хэсэг" гэдгийг тусгайлан заасан нь Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалтад "тусгайлан эрх олгосон тухайн хуулийн агуулга, зорилго, хүрээнд нийцсэн байх;" гэж, 60.1.3 дахь заалтад "тэмдэглэх хэсэгт үндэслэл болгож байгаа хуулийн заалтыг заасан байх;" гэж заасанд нийцсэн тул тус актыг захиргааны хэм, хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 6535 дугаарт бүртгэсэн байна.

Хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.6 дахь заалтад "худалдан авах ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, журам, заавар, аргачлалын хэрэгжилтэд хяналт тавьж, дүн шинжилгээ хийх;" гэж заасныг Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 1.6-д "Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын худалдан авах ажиллагааны бодлого хариуцсан нэгж (цаашид "нэгж" гэх) төсвийн ерөнхийлөн захирагч болон энэ журмын 1.7-д заасан бусад захиалагчаас цахим системээр хянан баталгаажуулсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, цахим системийн бусад мэдээлэлд үндэслэн тухайн оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд энэ журмын 4 дүгээр зүйлд зааснаар хяналт тавьж, дүн шинжилгээ хийнэ." гэж, 4 дүгээр буюу "Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих, дүн шинжилгээ хийх" зүйлд зааснаар захиалагч байгууллагаас ирүүлсэн тухайн төсвийн жилийн худалдан авах ажиллагааны тайлангийн хүрээнд жил бүр хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулдаг. Дээрх журмын 3 дугаар маягт нь ".....оны ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авсан бараа, үйлчилгээний тайлан" бөгөөд мөн журмын 3.7-д "Худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага цахим системийн ашиглалт болон захиалагчаас ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авсан бараа, үйлчилгээний тайланг нэгтгэн төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад энэ журмын хавсралтын 3 дугаар маягтын

дагуу цахим системээр дараа оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор тайлагнана." гэж заасныг мөрдөж ажиллаж байна.

Түүнчлэн хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.3, 55.1.6 дахь заалтын хүрээнд Сангийн сайдын тушаалаар батлагдсан тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг, журмын хэрэгжилтийг үнэлэн дүн шинжилгээ хийж, нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн батлах зорилгоор бүх төсвийн ерөнхийлөн захирагч, захиалагч нараас санал авч, төслийг худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) (цаашид "цахим систем" гэх)-д олон нийтийн саналыг авахаар нээлттэй байршуулдаг.

Энэ хүрээнд хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлснээс хойш төсвийн ерөнхийлөн захирагч, захиалагч, худалдан авах ажиллагаанд оролцогч нараас ирүүлсэн нийтлэг санал, хүсэлтэд үндэслэн 2023 онд Сангийн сайдын тушаалаар батлагдсан Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам, Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам, Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журамд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, нээлттэй болон харьцуулалтын аргаар бараа худалдан авах, ажил гүйцэтгүүлэх, үйлчилгээ авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичгийг тус тус шинэчлэн батлах тухай Сангийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/98, А/100, А/101, А/102, А/103, А/104 тоот тушаалууд батлагдсан байна.

3.Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт "Хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ." гэж заасны дагуу худалдан авах ажиллагааны дараах мэдээлэл ил тод, нээлттэй байна:

- Захиалагч тухайн төсвийн жилд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, төсөвт өртөг;
- Тендер шалгаруулалтын зарлал, урилга;
- Захиалагчийн баталсан тендер шалгаруулалтын баримт бичиг, техникийн тодорхойлолт;
- Тендер шалгаруулалтын баримт бичигтэй холбоотой тодруулга;
- Тендерийг хянан үзэж, үнэлсэн үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл;
- Шалгарсан оролцогчийн тендер;
- Тендерийн тодруулга, арифметик алдаа;
- Тендер шалгаруулалтад гаргасан захиалагчийн шийдвэр;
- Шалгарсан оролцогчийн мэдээлэл, гэрээ байгуулах дүн;
- Тендер шалгаруулалтын үр дүнгийн талаарх мэдээлэл;
- Худалдах, худалдан авах гэрээний мэдээлэл.

Сангийн сайдын 2023 оны А/248 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам"-ын 1.2-т "Цахим систем нь www.tender.gov.mn гэсэн хаягтай байх ба цахим системийн тасралтгүй, аюулгүй ажиллагааг худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (цаашид "мэргэжлийн байгууллага" гэх) хангаж ажиллана." гэж зааснаар дээрх мэдээлэл цахим системд нийтлэгддэг.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.4 дэх заалтад заасан мэдээллийг шилэн дансанд нийтлэх зохицуулалтын дагуу захиалагч байгууллагууд

нэг ижил төрлийг мэдээллийг хоёр өөр системд оруулах үүрэг хүлээдэг. Иймд нэг ижил төрлийн мэдээллийг цахим системээр харилцан өгөгдөл дамжуулах боломжийг судлах, мэдээллийн давхардлыг арилгаж, нэг мэдээллийг нэг цонхноос авах асуудлыг холбогдох хуульд өөрчлөлт оруулах замаар засварлах нь зүйтэй байх тул танай "Шилэн дансны цахим хуудас болон худалдан авах ажиллагааны цахим систем хоорондын уялдааг хангах тухай" зөвлөмжийг дэмжиж байна.

Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 1.4-т "Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (цаашид "төлөвлөгөө" гэх), худалдан авах ажиллагааны тайлан (цаашид "тайлан" гэх), түүнд оруулсан аливаа өөрчлөлтийг цахим системээр хөтөлнө.", 1.5-д "Захиалагчийн дээд шатны байгууллага төлөвлөгөө, тайлан, тэдгээрт холбогдох өөрчлөлтийг цахим системд бүртгэлтэй захиалагчийн эрхээр хянаж, баталгаажуулна." гэж зааснаар тус журмын 1, 2 дугаар хавсралтаар батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг захиалагч баталсны дараа түүний дээд шатны байгууллага (Төсвийн тухай хуульд зааснаар төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн ерөнхийлөн захирагч) хянан баталгаажуулахаар мөн журмын 2.6-д "Захиалагч төрийн байгууллагын төсвийн шууд захирагч, төрийн болон орон нутгийн өмчит улсын төсөвт үйлдвэрийн газрын гүйцэтгэх удирдлага төлөвлөгөөг батлагдсан төсөв болон хуульд нийцсэн эсэхийг хянан баталж, санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор холбогдох дээд шатны байгууллагад төлөвлөгөөг цахим системээр илгээнэ: 2.6.1.төсвийн шууд захирагч нь төсвийн төвлөрүүлэн захирагчид, төсвийн төвлөрүүлэн захирагч нь төлөвлөгөөг нэгтгэн хянаж төсвийн ерөнхийлөн захирагчид; 2.6.2.төсвийн шууд захирагч нь төсвийн төвлөрүүлэн захирагчгүй бол төсвийн ерөнхийлөн захирагчид; 2.6.3.Төсвийн тухай хуулийн 61.1-д заасны дагуу гэрээний үндсэн дээр санхүүжих байгууллагын төсвийн шууд захирагч нь сум, дүүргийн Засаг даргад, сум, дүүргийн Засаг дарга нь төлөвлөгөөг нэгтгэн хянаж төсвийн ерөнхийлөн захирагч болох аймаг, нийслэлийн Засаг даргад; 2.6.4.төсвийн ерөнхийлөн захирагч дээрх төсвийн захирагчдын төлөвлөгөөг санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш нэг сарын дотор нэгтгэн хянаж, баталгаажуулан цахим системд нийтэлнэ." гэж, 3.2-т "Энэ журмын 3.1-д заасан захиалагчийн тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг төсвийн ерөнхийлөн захирагч энэ журмын хавсралтын 2 дугаар маягтын дагуу цахим системд хянан нэгтгэж, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараа оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор цахим системээр тайлагнана." гэж тус тус зааснаар төсвийн ерөнхийлөн захирагч хянан баталгаажуулж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын 2.11-д "Захиалагч цахим системд нийтэлсэн төлөвлөгөөг мөрдөж ажиллах ба энэ журмын 2.12-т заасан үндэслэлээр батлагдсан төлөвлөгөөнд орсон нэмэлт, өөрчлөлтийг холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын 10 өдөрт багтаан төлөвлөгөөнд өөрчлөлтийг тусган, батална.", 2.13-т "Төлөвлөгөөнд тусгагдсан тухайн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, зохион байгуулах хугацаа, тендер шалгаруулалтын арга, бараа, ажил, үйлчилгээний төрөл, тухайн тендер шалгаруулалтыг хүчингүй болгох, бүр захиалагч холбогдох өөрчлөлттэй холбоотой үндэслэлийг албан бичгээр үйлдэж, цахим системд хавсаргасан байх ба холбогдох этгээд түүнийг хянаж төлөвлөгөөний өөрчлөлтийг зөвшөөрнө." гэж зааснаар өөрчлөлт батлагдсан бол цахим системд өөрчлөгдсөн хэлбэрээр бүртгэгддэг. Худалдан авах ажиллагааг, төлөвлөх тайлагнах журмын хавсралт болох худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний 1 дүгээр

маягтын 10 дугаар баганад "Тайлбар, тодруулга" гэсэн хэсэгт өөрчлөлт орсон, тодотгол орсон зэргээр тайлбар оруулах хэсэг нь нээлттэй байна. Танай "төлөвлөгөөний өөрчлөлтийг нэмэлт маягтаар оруулах" гэсэн зөвлөмжийн дагуу өөрчлөлт оруулж, цахим системд холбогдох төлөвлөгөөний тодотголын талбарыг оруулах болно.

Түүнчлэн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.10 дахь заалтад заасан худалдан авах ажиллагааны тайлан гэж заасны дагуу хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэгт "Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчаас ирүүлсэн тайланг нэгтгэн дүгнэж, дараа оны эхний улиралд Засгийн газарт тайлагнана." гэж заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны жилийн тайланг Сангийн яамны цахим хуудас (www.mof.gov.mn)-т нийтэлдэг болно.

Иймээс аудитын зөвлөмжид хүргүүлж буй тус яамны саналыг харгалзан үзэж, холбогдох хэсгийг хасах асуудлыг судалж үзэхийг хүсье.

Хүндэтгэсэн,



Б.ЖАВХЛАН

ҮАГ-ын тайлбар: Сангийн сайдаас ирүүлсэн саналыг судалж үзэхэд аудитын тайлангийн төсөлд өөрчлөлт оруулах хэмжээний тайлбар ирүүлээгүй болно.

4214



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

А корпус, Засгийн газрын IX байр,
Энхтайваны өргөн чөлөө 16, Баянзүрх дүүрэг,
Улаанбаатар хот, 13381
Утас/Факс: (976-51) 26 00 62
Цахим шуудан: info@sra.gov.mn
Цахим хуудас: www.sra.gov.mn

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР
С.МАГНАЙСҮРЭН ТАНАА

2025. 12. 10 № А-1/5610
танай _____-ны № _____-т

**Тайлангийн төсөлд тайлбар,
санал хүргүүлэх тухай**

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны "Аудитын сэдэв батлах тухай" 2024 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов "Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай" 2024 оны А/108 дугаар тушаалыг тус тус үндэслэн "Төрийн өмчит уул уурхайн компаниудын худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалт, үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад Төрийн аудитын тухай хуулийн 18.2-т заасны дагуу дараах тайлбар, саналыг хүргүүлж байна. Үүнд:

Нэг.Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4.1.26-д зааснаар программ хангамж ашиглан худалдан авах ажиллагааг зохион байгуулах, интернэтэд суурилсан мэдээллийн системийг ойлгохоор заасан. Худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь 2013 онд байгуулагдаж цахим системийг 2017 онд анх улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хөгжүүлэн ашиглалт оруулсан. Энэхүү цахим системийн тасралтгүй ажиллагааг тус байгууллага хариуцан ажиллаж байна. Ашиглалтад орсон хугацаанаас хойш хөрөнгө оруулалт хийгдээгүй байгууллагын дотоод нөөц бололцоог ашиглан тасралтгүй ажиллагааг хариуцаж байна. Гүйцэтгэлийн аудитын тайланд өнгөрсөн хугацаанд санхүүжилтийн эх үүсвэр, түүнийг шийдвэрлэсэн байдлын талаар тусгах. Мөн цахим системийн өргөтгөл, шинэчлэлтэд холбогдох санхүүжилтийг шийдвэрлэхийг эрхэлсэн Засгийн газрын гишүүнд үүрэг болгох талаар тусгах саналтай байна.

Хоёр.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиар тендер илгээх хураамжийг төвлөрүүлэх, зарцуулах эрхийг тус байгууллагад өгсөн байдаг. Төрийн худалдан авах ажиллагааны газар нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудит хийгдэж хязгаарлалттай дүгнэлт авсан. Дүгнэлтийн үндэслэлээр Төсвийн тухай хуулийн 43.1-д "Төсвийн захирагч төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг төсвийн үр ашгийг сайжруулах зорилгоор тухайн төсвийн жилд захиран зарцуулж болно" гэж заасныг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна гэсэн дүгнэлт өгсөн.

Дээрх дүгнэлтийн дагуу 2023 онд орлогын төлөвлөгөө 20.0 сая төгрөг, 2024 онд 25.0 сая төгрөг, 2025 онд 115.9 сая төгрөгөөр тус тус батлуулан ажиллаж байна. 2023 онд үндсэн үйл ажиллагааны орлого 106.6 сая төгрөг үүнээс 20.0 сая төгрөгийн орлогын төлөвлөгөөг биелүүлж үлдсэн 86.6 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн. Нэмэлт

санхүүжилтийн дансанд 697.4 сая төгрөгийн цахим тендерийн орлого олж үүнээс давсан орлого 325.3 сая төгрөгийг Сангийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 224 дүгээр тушаалын дагуу зарцуулж 372.1 сая төгрөг улсын төсөвт төвлөрүүлсэн. Сангийн сайдын 2022 оны А/282 тушаалаар баталсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 5.1, 5.2-т заасны дагуу холбогдох шийдвэрийг гарган ажилласан бөгөөд тушаалын гуравдугаар хавсралтын Төлөвлөгөөнөөс давж биелсэн орлогыг урсгалт дансаар хуваарилахад баримтлах үйл ажиллагааны төрлийн 4-т заасан Төсвийн байгууллагын улсын төсөвт төвлөрүүлэхээс бусад тогтмол үзүүлдэг ажил, үйлчилгээний орлого /бүртгэл, үйлчилгээний төлбөр хураамж, түрээс, сургалт, акц, сорил, баталгаажуулалт/-д байгаа болно. Хууль тогтоомжоор зарцуулах эрхийг олгосон боловч үйл ажиллагааны орлогыг урьдчилан тооцох боломжгүй, "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-аар зарцуулах эрх үүссэн боловч ашиглах боломжгүй байдаг болохыг анхаарч үзэхийг хүсэж байна.

Тайлангийн төслийн 1.43-д заасан 4,960.5 сая төгрөгийн хэдэн хувийг захиалагч байгууллагуудад шилжүүлсэн талаар нэмж тусгах. Уг зардал нь зөвхөн Төрийн худалдан авах ажиллагааны газрын үйл ажиллагаанд зарцуулагдсан байдлаар дурдсан байгааг өөрчлөх. Аудитын багаас боловсруулсан асуудлын түүвэрт зардлын талаар зөвлөмж өгөхөөр заасан байсан бөгөөд мөн 1.49, 1.50-д заасан журмыг зөрчсөн гэснийг өөрчлөх саналтай байна.

Тайлангийн төслийн 1.43-ийг дараах байдлаар "ТХААГ дээрх хууль, журмыг үндэслэн Голомт банк дах түр дансаар 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийг хүртэлх хугацаанд 8,138.1 сая төгрөгийн цахим системийн үйлчилгээний орлогыг төвлөрүүлж, 2023-2024 онд цахим системийн үйлчилгээний хураамжийн орлогын 70 хувь болох 3,626.2 сая төгрөгийг захиалагч байгууллагад, 29 хувьд болох 1,370.3 сая төгрөгийн төвлөрүүлснээс 728.6 сая төгрөгийг улсын орлого болгосон бөгөөд 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн байдлаар тухайн тайлант оны дээр дурдсан захиалагч байгууллагууд болон ТХААГ-ын 29 хувийн зарлагын гүйлгээг хийж 1,368.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна." гэж өөрчлөх.

Тайланд дурдсан асуудлаар үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан 2026 оны эхний улиралд холбогдох өөрчлөлтийг цахим системд бүрэн оруулан ажиллах бөгөөд цахим системийн хөгжүүлэлтийн явцад холбогдох зөвлөмж өгч дэмжин ажиллахыг Танаас хүсэж байна.

ДАРГА  Ц.БАТЗУЛ



ҮАГ-ын тайлбар: ТХААГ-аас ирүүлсэн саналын дагуу 1.43-ийг өөрчилсөн бөгөөд бусад саналын хувьд аудитын тайлангийн төсөлд өөрчлөлт оруулах хэмжээний тайлбар ирүүлээгүй болно.



ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК

Эрдэнэс Монгол ХХК-ийн байр, 1 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас: 7555 3399,

Цахим шуудан: info@erdenesmongol.mn,

Цахим хуудас: www.erdenesmongol.mn

2025. 12. 10 № 08/1560

танай _____-ны № _____-т

Тайлангийн төсөлд санал хүргүүлэх тухай

Танай 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн тайлангийн төсөлд санал авах тухай 3448 дугаартай албан бичигтэй танилцаж, санал хүргүүлж байна.

Манай байгууллагад ирүүлсэн "Төрийн өмчит уул уурхайн компаниудын худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалт, үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад аудитын дүгнэлтийн нийтлэг байр суурийг хүлээн зөвшөөрч, дэвшүүлсэн зөвлөмжүүд нь худалдан авах ажиллагааны ил тод байдал, үр нөлөөг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Тайлангийн төслийн агуулгатай санал нийлж байгаа боловч тодорхой хэсгүүдэд бодит нөхцөл байдлыг тодруулах зорилгоор дараах тайлбар, саналыг хүргүүлж байна. Үүнд:

Тайлангийн 1.38. ... "Эрдэнэс Монгол" ХХК цахим системд нэг ажилтны нэр дээр хоёр админ эрх бүртгэлтэй бөгөөд эдгээрийг Худалдан авах ажиллагааны газрын ажилтнууд хамтран ашиглаж байгаа;

Тайлбар: "Эрдэнэс Монгол" ХХК-д бүртгэл үүсгэсэн хоёр "Захиалагчийн админ" эрхийн нэг нь "Эрдэнэс Монгол ХХК-ийн өөрийн үйл ажиллагаанд ашиглах эрх, нөгөө нь "Эрдэнэс Монгол" нэгдлийн хэмжээнд буюу охин, хараат компаниудын үйл ажиллагаанд ашиглахаар үүсгэсэн хоёр тусдаа эрх юм.

"Эрдэнэс Монгол" ХХК-ийн тухайн жилд худалдан авахаар төлөвлөсөн бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр төлөвлөхдөө компанийн худалдан авалт хариуцсан ажилтан "Захиалагчийн админ" эрхээр нэвтэрч төлөвлөгөө үүсгэх, шивж оруулах ажлыг гүйцэтгэдэг бөгөөд оруулсан төлөвлөгөөг батлах эрхийн тохиргоог зөвхөн "Захиалагчийн баталгаажуулагч" эрх эзэмшигч гүйцэтгэдэг тул ямар нэгэн эрсдэл үүсэх боломжгүй.

Мөн Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн хандалтын түүх хэсэгт нэвтрэлтийн лог нь огноо болон IP хаягийн хамт хадгалагддаг тул хэрэглэгч ямар нэг үйлдэл, өөрчлөлт хийсэн нь тогтоогдох тул үүрэг, хариуцлага тодорхой байхаас гадна эдгээр эрхийг бусдад шилжүүлээгүй бөгөөд эрх эзэмшигчийн эрх үүргийн хүрээнд үйл ажиллагаандаа ашиглаж байгаа тул тайлангийн 1.38 дахь хэсгээс хасуулах саналтай байна.

Тайлангийн 2.32. Дээрх 13 компаниас 2023 онд 6 компанийн 342 тендерийн гэрээ, 2024 онд 9 компанийн 761 тендерийн гэрээг тус тус гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш хуульд заасан хугацаанд байгуулаагүй байна. ... "Эрдэнэс Монгол" ХХК 2024 онд 2 тендерийн гэрээ;

Тайлбар: "Эрдэнэс Монгол" ХХК зохион байгуулсан тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан оролцогчтой гэрээ байгуулахдаа тендерийн хүчинтэй байх хугацааг мөрдөж ажилласан бөгөөд гэрээний мэдээлэл, хүчинтэй хугацаа тооцсон жагсаалтыг хавсралтаар хүргүүлсэн тул хасуулах саналтай.

Тайлангийн 2.46. Аудитын тайлант хугацаанд 13 компанийн ерөнхий гэрээний аргаар цахим дэлгүүрээс худалдан авсан болон худалдан авах боломжтой байсан бараа, үйлчилгээг (нүүрс тээврийн үйлчилгээ ороогүй) түүвэрлэж тоймлон үзэхэд дараах байдалтай байна. Хүснэгт 7. Компаниудын цахим дэлгүүрээс худалдан авсан, авах боломжтой байсан бараа, үйлчилгээний мэдээлэл. ...2023 онд 183.9 тэрбум төгрөг, 2024 онд 389.3 тэрбум төгрөг. Цахим систем, МУЗГ-ын 2022 оны 460, 2024 оны 162 дугаар тогтоол, аудитын багийн тооцоо;

Тайлангийн 2.48. Үүнээс 2023 онд эм, дотоодод үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн, хөдөлмөр хамгаалал, нормын хувцас, байнгын хэрэгцээтэй тоног төхөөрөмж, программ хангамжийн үйлчилгээнээс худалдан авалт хийсэн бол бичгийн цаас, бичгийн хэрэгсэл, ариутгал, халдваргүйжүүлэлтийн түүхий эд, материал, даатгалын үйлчилгээг огт аваагүй байна;

Тайлангийн 2.49. Харин 2024 онд импортын зарим хүнсний бүтээгдэхүүн, хор саармагжуулах хүнсний бүтээгдэхүүн, худалдан авалт шинээр нэмэгдсэн бөгөөд хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд шаардлагатай үндсэн болон туслах тоног төхөөрөмж, сэлбэг, эд анги, хөдөлмөр хамгааллын гутал, хувцас, хэрэгсэл, монгол гэр, гэрийн иж бүрдэл, туулах чадвар сайтай автомашин, уул уурхайн салбарын тоног төхөөрөмж, сэлбэг, дагалдах хэрэгсэл, даатгалын үйлчилгээг ерөнхий гэрээний аргаар худалдан аваагүй байна;

Тайлангийн 2.50. Шалгагдагч 13 компани 2023 онд 4 нэр төрлийн 183.1 тэрбум төгрөг, 2024 онд 12 нэр төрлийн 387.5 тэрбум төгрөгийн дүнтэй бараа, үйлчилгээг цахим дэлгүүрээс худалдан авах боломжтой байсныг тоймлон тооцвол дээрх нийт худалдан авалт нь 2023 онд 9.1 хувь, 2024 онд 3.3 хувийг тус тус эзэлж байгаа нь хангалтгүй байна;

Тайлангийн 2.51. Холбогдох төрийн байгууллагууд болон компаниуд ТБОНӨХБАҮХАТХуулийн /хуучин/ 8 дугаар зүйлийн 8.13-д "Ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авах бараа, үйлчилгээг цахим дэлгүүрт байршуулснаас өөр этгээдээс худалдан авахыг хориглоно", шинэчилсэн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-т "Энэ хуулийн 37.2.4-т зааснаар захиалагч нь ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авна", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ", 14.2-д "Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-д зааснаар хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ", 14.4-д "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно", мөн хуулийн 38 дугаар зүйлийн 38.7-д "Бараа, үйлчилгээг ерөнхий гэрээний аргаар худалдан авах тендер шалгаруулалтын аргачлал, зааврыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална" гэж заасныг бүрэн хэрэгжүүлж, хооронд харилцан уялдаж, хамтран санаачилгатай ажиллаагүй байна.

Тайлбар: Тайлангийн 2.46, 2.48, 2.49, 2.50, 2.51-д Ерөнхий гэрээний аргаар "Цахим дэлгүүр"-ээс худалдан авах боломжтой байсан бараа, үйлчилгээний судалгаа, түүнд үндэслэн тайлан боловсруулж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил,

үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэд хэдэн заалтыг зөрчсөн мэтээр зөрүүтэй тайлагнасанд тайлбар хүргүүлье.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (Шинэчилсэн найруулга, цаашид "хууль" гэх) /хуучин хуулийн ижил утгатай заалт/-ийн 49 дүгээр зүйлийн 49.4.11-т Ерөнхий гэрээний аргаар худалдан авах бараа, үйлчилгээний нэгж үнийн дээд хязгаарыг тогтоох, ерөнхий гэрээний аргаар тендер шалгаруулалт зохион байгуулах захиалагчийн чиг үүргийг зөвхөн Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага буюу Төрийн худалдан авах ажиллагааны газар хэрэгжүүлэхээр зохицуулсан.

Төрийн худалдан авах ажиллагааны газар нь хуулийн 10.7-д "Энэ хуулийн 4.1.8-д заасан ерөнхий гэрээний аргаар худалдан авах бараа, үйлчилгээний жагсаалтыг Засгийн газар батална" гэж заасны дагуу Ерөнхий гэрээний аргаар худалдан авах боломжтой, байнгын хэрэгцээтэй бараа, үйлчилгээний жагсаалтыг МУЗГ-ын 2022 оны 460, 2024 оны 162 дугаар тогтоолоор тус тус батлуулсан байдаг.

Энэ нь Төрийн худалдан авах ажиллагааны газрын Ерөнхий гэрээний аргаар тендер шалгаруулалт зохион байгуулж, тендер шалгаруулалтын үр дүнд тодорхой шаардлага, шалгуур үзүүлэлт, нэгж дээд үнэ болон бусад нөхцөлийг хангасан нэг буюу хэд хэдэн этгээдтэй ерөнхий гэрээ байгуулж, "Цахим дэлгүүр"-т байршуулах боломжтой бараа, үйлчилгээний жагсаалт юм.

Төрийн худалдан авах ажиллагааны газрын зохион байгуулсан тендер шалгаруулалтын үр дүнд Ерөнхий гэрээ байгуулж, "цахим дэлгүүр"-т байршсан бараа, үйлчилгээнээс худалдан авах хуулийн зохицуулалт нь хуулийн /хуучин/ 8 дугаар зүйлийн 8.13-д "Ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авах бараа, үйлчилгээг цахим дэлгүүрт байршуулснаас өөр этгээдээс худалдан авахыг хориглоно", шинэчилсэн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-т "Энэ хуулийн 37.2.4-т зааснаар захиалагч нь ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авна", Төрийн хэмнэлтийн хуулийн 14.4-д "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно", гэх заалтууд бөгөөд тайланд тусгагдсан нэр төрлийн бараа, үйлчилгээ "Цахим дэлгүүр"-т байршаагүй тохиолдолд Ерөнхий гэрээний аргаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, хоёрдугаар шатны захиалгын гэрээ байгуулах боломжгүй юм.

Төрийн худалдан авах ажиллагааны газар нь тайланд дурдагдсан нэр төрлийн барааны жишиг техникийн тодорхойлолт боловсруулаагүй, ерөнхий гэрээний аргаар худалдан авах бараа, үйлчилгээний нэгж үнийн дээд хязгаарыг тогтоогоогүй, ерөнхий гэрээний аргаар тендер шалгаруулалт зохион байгуулаагүй, "Цахим дэлгүүр"-т байршуулаагүй байхад Засгийн газрын тогтоолоор баталсан бараа, үйлчилгээний жагсаалтаас "Ерөнхий гэрээний аргаар **цахим дэлгүүрээс** худалдан авах боломжтой байсан бараа, үйлчилгээний судалгаа"-г боловсруулж, нэгтгэн 13 компани 2023 онд 4 нэр төрлийн 183.1 тэрбум төгрөг, 2024 онд 12 нэр төрлийн 387.5 тэрбум төгрөгийн дүнтэй бараа, үйлчилгээг "**цахим дэлгүүр**"-ээс худалдан авах боломжтой байсан мэтээр тайлагнасан тайлангууд хуульд нийцэхгүй байгаа тул тайлангийн холбогдох хэсгээс хасуулах саналтай байна.

Мөн "Цахим дэлгүүр"-т байршсан бараа, үйлчилгээний худалдан авалтын тайлан, судалгаа боловсруулахдаа "Эрдэнэс тавантолгой" ХК-ийн үндсэн үйл ажиллагаанд голлох үүрэг гүйцэтгэж буй "Нүүрс тээврийн үйлчилгээ"-г хасаж тайлагнасан нь уул уурхайн салбарын худалдан авалтын хувь хэмжээг бууруулж байгаа тул бодит тоо баримтыг улсын хэмжээний "Цахим дэлгүүр"-ийн захиалгын гэрээний тоо баримттай харьцуулж тайлагнаж өгөхийг хүсье.

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Төрийн худалдан авах ажиллагааны газар, Сангийн яам болон охин, хараат компаниудтай хамтран шаардлагатай арга хэмжээ, сайжруулалтыг үе шаттайгаар зохион байгуулахын зэрэгцээ Үндэсний аудитын газартай уялдаа холбоотой ажиллахад нээлттэй байна.

Хавсралт 1. хуудастай.



ҮАГ-ын тайлбар: "Эрдэнэс Монгол" ХХК-аас ирүүлсэн саналыг судалж үзэхэд тайлангийн 2.32-т саналын дагуу өөрчилсөн бөгөөд бусад саналын хувьд аудитын тайлангийн төсөлд өөрчлөлт оруулах хэмжээний тайлбар ирүүлээгүй болно.

Хавсралт 1. Цахим системийн үндсэн үйл ажиллагааны үе шатны процессын тайлбар

Д.д	Үе Шат	Тайлбар
1	Бүртгэл ба баталгаажуулалт	Байгууллага, оролцогчдыг цахим системд бүртгэж, тоон гарын үсэг ашиглан баталгаажуулна. Аж ахуй эрхлэгчийн чадавх, туршлагын мэдээлэл, бараа, үйлчилгээний каталогийг системд оруулж, баталгаажуулна.
2	Худалдан авах төлөвлөлт	Захиалагч батлагдсан төсөвт үндэслэн төлөвлөгөөг системд оруулж, Сангийн яам баталгаажуулж нийтэлнэ. Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг захиалагч тогтмол гаргана.
3	Тендерийн баримт бичиг боловсруулах	Техникийн тодорхойлолт, шалгуур, гэрээний нөхцөлийг (жишиг маягтын дагуу) боловсруулж, захиалагч батална. Үнэлгээний хороог (ҮХ) мэргэшсэн ажилтны санааас сонгож байгуулна ¹ .
4	Зар, урилга нийтлэх	Зарлал, урилга, ТББ-ийг цахим системд нийтэлнэ. Сонирхогч этгээдээс гаргасан тодруулга авах хүсэлтэд хариуг тодруулгын хамт системд нийтэлнэ.
5	Тендер хүлээн авах, нээлт хийх	Тендер хүлээн авах эцсийн хугацаа дууссанаас хойш 1 цагийн дотор тендерийг нээнэ. Тендерийн баталгаа шаардсан ТШ-т баталгаа ирүүлээгүй бол нээхээс татгалзана.
6	Үнэлгээний хороо ажиллах	ҮХ ирүүлсэн тендерүүдийг шалгуур, шаардлага (ерөнхий, чадавх, туршлага)-ын дагуу хянан үзэж, үнэлнэ. Арифметик алдааг залруулах тооцоо хийнэ.
7	Шийдвэр гаргах	ҮХ-ны зөвлөмжид үндэслэн захиалагч тендер нээснээс хойш ажлын 15 өдрийн дотор шийдвэр гаргана. Шийдвэрийг цахим системд нийтэлснээр оролцогчдод мэдэгдсэнд тооцно.
8	Баталгаа шаардах/Хүлээн авах	Шалгарсан оролцогчтой гэрээ байгуулахын өмнө гүйцэтгэлийн баталгааг (төсвийн 3 хувь) шаардана. Тендерийн баталгааг хуульд заасан үндэслэлээр улсын орлого болгох шийдвэр гаргаж болно.
9	Гэрээ байгуулах	Шийдвэр гарснаас хойш ажлын 6-аас доошгүй өдрийн дараа гэрээг баталгаажуулна. Худалдан авах гэрээг цахим системд бүртгэж, олон нийтэд нээлттэй байршуулна.
10	Гэрээний хэрэгжилт	Гэрээнд орсон нэмэлт, өөрчлөлт, гэрээний хэрэгжилт, хүлээн авсан актыг тухай бүр цахим системд бүртгэж, нийтэлнэ. Гүйцэтгэгч гэрээний гүйцэтгэлийн мэдээллийг нотлох баримтын хамт цахим системд бүртгэнэ.
11	Гомдол шийдвэрлэх	Оролцогч хуульд заасан хугацаанд гомдлоо захиалагч, Сангийн яам, өрсөлдөөний байгууллагад гаргах боломжтой. Эдгээр байгууллагууд гомдлыг хянан шийдвэрлэх хугацаанд ТШ-ыг түдгэлзүүлж болно.
12	Тайлагнал ба мониторинг	Захиалагч худалдан авах ажиллагааны тайланг цахим системээр дээд шатны байгууллагад тайлагнана. Мэргэжлийн байгууллага цахим системийн аюулгүй байдлын аудитыг 2 жил тутамд хийлгэнэ.

Эх сурвалж: Цахим системийн гарын авлага

Хавсралт 2. 13 Компанийн тендер шалгаруулалттай холбоотой гомдлын мэдээлэл

Д.Д	Он	Нийт тендер ийн тоо	Гомдол гарсан тендер тоо	Нийт ТШ-д гомдлын эзлэх хувь	Гомдол гаргасан оролцогч ын тоо	Ирүүлсэн гомдлын тоо (давхардсан тоогоор)	Гомдол гаргагчийн гомдлын үндэслэлтэй хувь
2023 он							
1	Багануур ХК	248	20	8.0	16	25	64.0
2	Дарханы Төмөрлөгийн үйлдвэр ХХК	828	18	2.2	20	24	54.2
3	Эрдэнэс Критикал Минералс ТӨҮГ	505	13	2.6	14	22	54.5
4	Тавантолгой ХК	76	7	9.2	9	10	80.0
5	Цемент шохой ХХК	252	13	5.2	13	13	38.5
6	Шивээ-Овоо ХК	298	7	2.3	7	8	75.0
7	Эрдэнэс баянбогд ХХК	43	1	2.3	2	2	50.0
8	Эрдэнэс Монгол ХХК	98	3	3.1	3	5	20.0
9	Эрдэнэс Тавантолгой ХК	521	20	3.8	24	30	33.3
10	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	1218	223	18.3	196	385	61.6
2024 он							
1	Багануур ХК	111	9	8.1	10	12	41.7
2	Дарханы Төмөрлөгийн үйлдвэр ХХК	574	17	3.0	19	24	70.8
3	Эрдэнэс Критикал Минералс ТӨҮГ	274	16	5.8	18	28	82.1
4	Тавантолгой ХК	157	7	4.5	12	17	47.1
5	Цемент шохой ХХК	237	8	3.4	7	11	81.8
6	Шивээ-Овоо ХК	360	11	3.1	9	15	66.7
7	Эрдэнэс Алт ресурс ХХК	119	10	8.4	14	20	65.0
8	Эрдэнэс Монгол ХХК	128	2	1.6	1	2	100.0
9	Эрдэнэс Тавантолгой ХХК	537	25	4.7	28	87	41.4
10	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	1414	241	17.0	232	449	63.9

Эх сурвалж: СЯ-наас ирүүлсэн мэдээлэл

Хавсралт 3. 13 компанийн 2023-2024 онд төсөвт туссан зарим зардлуудыг ХАА-ны төлөвлөгөөнд туссан эсэхийг тодруулах судалгаа

сая төгрөг													
Д.д	Компанийн нэр	Батлагдсан нийт төсөв		Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө		Менежментийн зардал (Орлого)		Тодруулах зардал					
								Мэдээлэл сурталчилгааны зардал		Нийгэм олон нийттэй харилцах		Сургалтын зардал	
		2023 он	2024 он	2023 он	2024 он	2023 он	2024 он	2023 он	2024 он	2023 он	2024 он	2023 он	2024 он
1	Багануур ХК	224,350.0	244,296.3	42,545.0	36,566.5	4,291.7	4,964.2					110.6	158.0
2	Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХХК	341,384.1	417,707.7	45,114.4	50,586.0		9,427.1			1,736.0			334.2
3	Цемент шохой ХХК	121,675.9	121,978.9	92,440.3	12,068.4		2,590.2		169.0			178.5	250.0
4	Шивээ-Овоо ХК	115.7	111.1		92,218.0								
5	Эрдэнэс Алт Ресурс ХХК	146,283.8	166,851.6	29,278.0	26,430.5	3,601.0	5,759.0	135.0	135.0			149.8	130.2
6	Эрдэнэс Баянбогд ХХК	2,326.4	2,045.0		7,444.4							43.4	5.0
7	Эрдэнэс критикал минералс ТӨҮГ	256,249.2	304,104.1	60,699.3	20,363.5	5,321.6	5,162.9						
8	Эрдэнэс Монгол ХХК	87,031.0	87,884.6	38,364.8	129,235.7	231,766.5	163,564.7	270.0	420.0			291.0	934.9
9	Эрдэнэс Оюу Толгой ХХК	27,904.7	17,569.3	11,202.5	9,496.1		354.1	5,753.6	4,385.0				61.5
10	Эрдэнэс Тавантолгой ХК	6,743,476.9	7,737,851.7	8,360,418.9	8,667,449.4	142,537.5	163,990.7					1,330.7	2,330.0
11	Эрдэнэс УТП ХХК		5,317.6		570.5								20.0
12	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	3,168,307.1	3,293,338.6	1,270,571.7	1,182,345.8							4,000.0	4,000.0
ДҮН		11,119,104.8	12,399,056.5	9,950,634.9	10,234,774.8			6,158.6	5,109.0	-	1,736.0	6,104.0	8,223.8

Эх сурвалж: “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн тогтоолууд, 2023, 2024 он, ХАА-ны төлөвлөгөө (<https://shilendans.gov.mn/>)

Хавсралт 4. 13 компанийн 2023-2024 онд худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс ерөнхий гэрээний аргаар худалдан авсан бараа, үйлчилгээ, сая төгрөг

Д.д	Төсөл, арга хэмжээний нэр	Багануур ХК		Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХХК		Таван толгой ХК		Цемент шохой ХХК		Шивээ-Овоо ХК		Эрдэнэс Алт Ресурс ХХК		Эрдэнэс Баянбогд ХХК	
		2023 он	2024 он	2023 он	2024 он	2023 он	2024 он	2023 он	2024 он	2023 он	2024 он	2023 он	2024 он	2023 он	2024 он
1	Зарим ерөнхий нэршлийн эм, эмнэлгийн хэрэгсэл	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	0.6	-	-
2	Чанар стандартын шаардлага хангасан дотоодод үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн	5.8	-	3.3	-	-	-	-	-	1.3	4.2	-	-	-	-
3	Чанар стандартын шаардлага хангасан импортын зарим хүнсний бүтээгдэхүүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
4	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд шаардлагатай үндсэн болон туслах тоног төхөөрөмж, сэлбэг, эд анги	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
5	Хор саармагжуулах хүнсний бүтээгдэхүүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
6	Хөдөлмөр хамгааллын гутал, хувцас, хэрэгсэл	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
7	Монгол гэр, гэрийн иж бүрдэл	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
8	Нийтлэг хэрэгцээтэй тавилга, тоног төхөөрөмж, бараа материал, түүхий эд	-	-	-	17.3	-	-	-	-	-	-	-	-	-	-
9	Төрийн захиргаа, нутгийн удирдлага, тусгай чиг үүргийн байгууллагууд болон уул уурхайн салбарын төрийн өмчит хуулийн этгээдэд шаардлагатай туулах чадвар сайтай автомашин	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
10	Уул уурхайн салбарын тоног төхөөрөмж, сэлбэг, дагалдах хэрэгсэл	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
11	Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын байнгын хэрэгцээтэй тоног төхөөрөмж, сэлбэг, дагалдах хэрэгсэл	-	-	-	132.5	-	-	-	-	-	-	-	-	-	-
12	Нүүрс тээврийн үйлчилгээ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
13	Даатгалын үйлчилгээ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
ДҮН		5.8	-	3.3	149.8	-	-	-	-	1.3	4.2	-	0.6	-	-

Хавсралт 4-ийн үргэлжлэл

Д.д	Төсөл, арга хэмжээний нэр	Эрдэнэс критикал минералс ТӨҮГ		Эрдэнэс Монгол ХХК		Эрдэнэс Оюу Толгой ХХК		Эрдэнэс Тавантолгой ХК		Эрдэнэс ҮТП ХХК		Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ		ДҮН	
		2023 он	2024 он	2023 он	2024 он	2023 он	2024 он	2023 он	2024 он	2023 он	2024 он	2023 он	2024 он	2023 он	2024 он
1	Зарим ерөнхий нэршлийн эм, эмнэлгийн хэрэгсэл	2.0	1.6	-	-	-	-	10.3	9.4	-	-	24.0	-	36.3	11.6
2	Чанар стандартын шаардлага хангасан дотоодод үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн	-	-	-	-	-	-	5.2	12.0	-	-	672.9	9,233.2	688.5	9,249.4
3	Чанар стандартын шаардлага хангасан импортын зарим хүнсний бүтээгдэхүүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	240.2	-	240.2
4	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд шаардлагатай үндсэн болон туслах тоног төхөөрөмж, сэлбэг, эд анги	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
5	Хор саармагжуулах хүнсний бүтээгдэхүүн	-	14.3	-	-	-	-	-	-	-	-	-	326.7	-	341.0
6	Хөдөлмөр хамгааллын гутал, хувцас, хэрэгсэл	-	-	-	-	-	-	-	-	-	-	195.5	-	195.5	-
7	Монгол гэр, гэрийн иж бүрдэл	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
8	Нийтлэг хэрэгцээтэй тавилга, тоног төхөөрөмж, бараа материал, түүхий эд	-	7.8	270.0	170.4	-	53.9	15.6	747.0	62.0	32.1	-	586.5	347.6	1,614.9
9	Төрийн захиргаа, нутгийн удирдлага, тусгай чиг үүргийн байгууллагууд болон уул уурхайн салбарын төрийн өмчит хуулийн этгээдэд шаардлагатай туулах чадвар сайтай автомашин	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
10	Уул уурхайн салбарын тоног төхөөрөмж, сэлбэг, дагалдах хэрэгсэл	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
11	Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын байнгын хэрэгцээтэй тоног төхөөрөмж, сэлбэг, дагалдах хэрэгсэл	-	25.0	73.0	88.1	-	-	554.4	436.7	2.6	3.8	-	806.7	630.0	1,492.8
12	Нүүрс тээврийн үйлчилгээ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
13	Даатгалын үйлчилгээ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
ДҮН		2.0	48.6	343.0	258.4	-	53.9	585.5	1,205.1	64.6	35.9	892.4	11,193.5	1,897.9	12,949.9

Эх сурвалж: Компаниудын ХАА-ны тайлан, цахим системийн мэдээлэл

Хавсралт 5. 13 компанийн 2023-2024 онд цахим дэлгүүрээс ерөнхий гэрээний аргаар худалдан авах боломжтой бараа, үйлчилгээний түүвэрлэсэн тооцоолол

сая төгрөг

Д.д	Төсөл, арга хэмжээний нэр	Багануур ХК		Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХХК		Таван толгой ХК		Цемент шохой ХХК		Шивээ-Овоо ХК		Эрдэнэс Алт Ресурс ХХК		Эрдэнэс Баянбогд ХХК	
		2023 он	2024 он	2023 он	2024 он	2023 он	2024 он	2023 он	2024 он	2023 он	2024 он	2023 он	2024 он	2023 он	2024 он
1	Зарим ерөнхий нэршлийн эм, эмнэлгийн хэрэгсэл	12.1	77.9	14.8	25.0	-	13.8	67.8	103.2	16.9	19.3	-	-	-	-
2	Чанар стандартын шаардлага хангасан дотоодод үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн	65.5	27.3	15.4	-	-	-	859.6	718.4	-	-	-	-	-	-
3	Чанар стандартын шаардлага хангасан импортын зарим хүнсний бүтээгдэхүүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
4	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд шаардлагатай үндсэн болон туслах тоног төхөөрөмж, сэлбэг, эд анги	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
5	Хор саармагжуулах хүнсний бүтээгдэхүүн	-	-	-	-	-	-	-	-	-	270.3	-	-	-	-
6	Хөдөлмөр хамгааллын гутал, хувцас, хэрэгсэл	989.7	530.4	166.5	272.9	157.3	109.6	1,843.4	957.8	573.2	373.2	-	483.0	-	-
7	Монгол гэр, гэрийн иж бүрдэл	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
8	Нийтлэг хэрэгцээтэй тавилга, тоног төхөөрөмж, бараа материал, түүхий эд	-	-	-	25.2	-	1.8	-	76.4	-	-	-	-	-	-
9	Төрийн захиргаа, нутгийн удирдлага, тусгай чиг үүргийн байгууллагууд болон уул уурхайн салбарын төрийн өмчит хуулийн этгээдэд шаардлагатай туулах чадвар сайтай автомашин	-	616.0	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	155.0
10	Уул уурхайн салбарын тоног төхөөрөмж, сэлбэг, дагалдах хэрэгсэл	-	16,357.9	-	25,731.5	-	1,224.7	-	2,539.6	-	6,610.7	-	2,620.0	-	-
11	Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын байнгын хэрэгцээтэй тоног төхөөрөмж, сэлбэг, дагалдах хэрэгсэл	2,769.0	99.0	9,740.0	36.0	600.6	453.0	4,449.5	33.3	-	129.6	-	40.0	338.5	-
12	Нүүрс тээврийн үйлчилгээ	-	-	-	-	-	-	-	-	9,149.0	-	-	-	-	-
13	Даатгалын үйлчилгээ	110.3	110.1	-	-	150.0	-	13.4	113.8	269.0	277.3	-	270.7	52.5	-
ДҮН		3,946.5	17,818.5	9,936.7	26,090.5	907.9	1,802.8	7,233.8	4,542.5	10,008.1	7,680.4	-	3,413.7	391.0	155.0

Эх сурвалж: Аудитын баг, цахим системийн мэдээлэл

Хавсралт 5-ын үргэлжлэл

Д.д	Төсөл, арга хэмжээний нэр	Эрдэнэс критикал минералс ТӨҮГ		Эрдэнэс Монгол ХХК		Эрдэнэс Оюу Толгой ХХК		Эрдэнэс Тавантолгой ХК		Эрдэнэс УТП ХХК		Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ		ДҮН	
		2023 он	2024 он	2023 он	2024 он	2023 он	2024 он	2023 он	2024 он	2023 он	2024 он	2023 он	2024 он	2023 он	2024 он
1	Зарим ерөнхий нэршлийн эм, эмнэлгийн хэрэгсэл	-	-	-	-	-	-	-	-	-	-	940.8	1,301.1	1,052.5	1,540.2
2	Чанар стандартын шаардлага хангасан дотоодод үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн	1,539.0	1,212.8	-	-	-	-	-	-	-	-	3,590.8	2,166.0	6,070.3	4,124.4
3	Чанар стандартын шаардлага хангасан импортын зарим хүнсний бүтээгдэхүүн	-	-	-	-	-	-	-	293.5	-	-	-	1,381.4	-	1,674.9
4	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд шаардлагатай үндсэн болон туслах тоног төхөөрөмж, сэлбэг, эд анги	-	6.0	-	11.7	-	-	-	-	-	-	-	236.3	-	254.0
5	Хор саармагжуулах хүнсний бүтээгдэхүүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	3,140.0	-	3,410.3
6	Хөдөлмөр хамгааллын гутал, хувцас, хэрэгсэл	761.6	848.4	10.1	30.2	-	-	1,916.2	7,814.2	-	-	1,674.8	81.1	8,092.8	11,500.7
7	Монгол гэр, гэрийн иж бүрдэл	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	104.1	-	104.1
8	Нийтлэг хэрэгцээтэй тавилга, тоног төхөөрөмж, бараа материал, түүхий эд	-	-	-	-	-	164.9	-	492.0	-	204.3	-	510.4	-	1,475.1
9	Төрийн захиргаа, нутгийн удирдлага, тусгай чиг үүргийн байгууллагууд болон уул уурхайн салбарын төрийн өмчит хуулийн этгээдэд шаардлагатай туулах чадвар сайтай автомашин	-	-	-	-	-	270.0	-	-	-	-	-	-	-	1,041.0
10	Уул уурхайн салбарын тоног төхөөрөмж, сэлбэг, дагалдах хэрэгсэл	-	11,320.5	-	-	-	-	-	156,750.6	-	-	-	120,748.1	-	339,725.7
11	Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын байнгын хэрэгцээтэй тоног төхөөрөмж, сэлбэг, дагалдах хэрэгсэл	9,499.5	431.4	743.5	3,746.4	-	-	17,311.3	5,252.2	-	-	107,479.3	-	152,177.4	10,220.8
12	Нүүрс тээврийн үйлчилгээ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	9,149.0	-
13	Даатгалын үйлчилгээ	292.4	263.3	-	184.8	-	-	5,239.8	2,296.9	-	-	1,330.0	10,709.7	7,457.5	14,226.6
ДҮН		12,092.6	14,082.4	753.6	3,973.1	-	434.9	24,467.4	172,899.5	-	204.3	115,015.6	140,378.2	183,999.4	389,297.9

Эх сурвалж: Аудитын баг, цахим системийн мэдээлэл


Хавсралт 6 Цахим системийн үндсэн үйл ажиллагаанд оролцогчдын үе шатны процессын дэлгэрэнгүй зураглал


Үе шат	Үйл явцын нэр	Захиалагч (Систем Бүртгүүлэгч) / Үнэлгээний Хороо (ҮХ)	Төрийн худалдан авах ажиллагааны газар / Мэргэжлийн Байгууллага (Админ)	Төсвийн Ерөнхий Захирагч / Сангийн Яам	Тендер Оролцогч (Нийлүүлэгч)
1.Бүртгэл баталгаажуулалт	ба Эхлэл ба Бэлтгэл	Бүртгэлээ хийж, баримт бичгийг цахим системд оруулах.	Бүртгэл хөтлөх тооллогыг хангах.		
2.Худалдан төлөвлөлт	авах Төлөвлөгөө Боловсруулах	Төсөл, арга хэмжээний жагсаалт, мэдээллийг боловсруулж, Ерөнхий болон Дэлгэрэнгүй төлөвлөгөөг боловсруулах.			
3.ТББ боловсруулах (Төлөвлөлтийн дараа)	Төлөвлөгөө Итгэх/Батлах	Ерөнхий төлөвлөгөөг ТЕЗ-рүү илгээх.		ТЕЗ: Хариуцсан захиалагчийн төлөвлөгөөг хянах, батлах. СЯ-руу илгээх. СЯ:Илгээгдсэн төлөвлөгөөг батлах	
4.Зар, урилга нийтлэх	Тендерийн Баримт Бичиг бэлтгэх, Урилга, Зарлах	ҮХ-г мэргэжлийн ажилтныг сонгож байгуулах. ҮХ-ны шийдвэр, Ашиг сонирхлын зөрчлийг системд бүртгэх. ТББ-ийг үнэлгээний техник, батлах эсэхийг шийдэх. ТББ-ний зар, урилгыг цахим системд нийтлэх.	ТББ-ний боловсруулах дараа захиалагч руу илгээх (ҮХ-ны НБ-ын зураг).		
5.Тендер хүлээн авах, нээлт хийх	Тодруулга	Тодруулга авах (оролцогчдоос ирсэн) хүсэлтэд хариуг, тодруулгын хавт нийтлэх.	Тодруулгын хариуг цахим шуудангаар дамжуулах техникийн шийдлийг хангах.		Тодруулга авах хүсэлтийг тоон гарын үсгээр баталгаажуулан цахимаар гаргах.
6. Үнэлгээний хороо ажиллах (Тендер нээсний дараа)	Тендер Ирүүлэх				Тендерийн багцыг цахим системээр дамжуулан ирүүлэх. Тендер, холбогдох мэдээллийг тоон гарын үсгээр баталгаажуулан илгээх.

	Лавлагаа Ашиглах	Лавлагаа (Татвар, НД, Шүүхийн шийдвэр, Төсвийн хараа хяналт гэх мэт) авах.	
	Тендер Үнэлэх	ҮХ тендерүүдийг хянан үзэж, үнэлэх.	
7. Шийдвэр гаргах	Үр дүн Нийтлэх	ҮХ-ны шийдвэрийг бүрэн нийтлэх, шалгарсан оролцогчийн өмнөх бус мэдээллийг нийтлэх.	
8.Баталгаа шаардах/ Хүлээн авах	Гэрээ Байгуулах	Үнэлгээний дүнгээр шалгарсан оролцогчтой гэрээ байгуулж, системд бүртгэх.	
9. Гэрээ байгуулах	Гэрээний Гүйцэтгэл	Гэрээнд орсон нэмэлт, өөрчлөлт, гэрээний хэрэгжилт, хүлээн авсан актыг тухай бүр цахим системд нийтлэх.	Гэрээний гүйцэтгэлийн мэдээллийг нотлох баримтын хувь хэмжээгээр дагуулан бүртгэх.
10.Гэрээний хэрэгжилт	Цахим Дэлгүүр	Ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээ худалдан авах.	Цахим дэлгүүрийн систем, ерөнхий гэрээг сонгон шалгаруулан барааг байршуулах.
11.Гомдол шийдвэрлэх	(Аливаа үе шатад зэрэгцээ орж болно)	Гомдол хүлээн авч, холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх.	
12. Тайлагнал ба Мониторинг (Гэрээний дараа үргэлжилнэ)	Системийн Аюулгүй Байдал	Системийн тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах. Мэдээллийн аюулгүй байдлын аудитыг 2 жилд нэг удаа хийх.	СЯ: Хяналт, аюулгүй байдлын талаар төвлөрсөн мэдээлэл солилцох.
	Ерөнхий Мэдээлэл Солилцоо	Төрийн бусад системтэй харилцан өгөгдөл солилцох боломжтой байх системийн хөгжүүлэлт хийх.	

Эх сурвалж: Аудитын баг

Хавсралт 7 Цахим системээр ерөнхий гэрээний аргаар тендер шалгаруулалтын дэлгэрэнгүй зураглал





Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагын жагсаалт

№	Төлбөр, зөрчил хариуцах		Төлбөрийн акт, албан шаардлагын товч утга	Төлбөрийн акт, албан шаардлагын дүн (төгрөгөөр)
	Байгууллага	Албан тушаалтан		
1	Сангийн яам	Сангийн сайд Б.Жавхлан	Бараа, үйлчилгээг ерөнхий гэрээний аргаар худалдан авах тендер шалгаруулалтын аргачлал, зааврыг батлаагүй, худалдан авах ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, журам, заавар, аргачлалын хэрэгжилтэд хяналт тавьж, дүн шинжилгээ хийгээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.7-д "Бараа, үйлчилгээг ерөнхий гэрээний аргаар худалдан авах тендер шалгаруулалтын аргачлал, зааврыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална", 55 дугаар зүйлийн 55.1.3-д "худалдан авах ажиллагаатай холбоотой журам, аргачлал, заавар, тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг, гэрээний загварыг батлах", 55 дугаар зүйлийн 55.1.6-д "Худалдан авах ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, журам, заавар, аргачлалын хэрэгжилтэд хяналт тавьж, дүн шинжилгээ хийх" гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.	Албан шаардлага
2	Төрийн худалдан авах ажиллагааны газар	Газрын дарга Ц.Батзул	Төрийн худалдан авах ажиллагааны газар нь 2023-2024 онд тендерт оролцогч аж ахуй нэгж, байгууллагуудаас үйл ажиллагааны дансанд нийт 1,628,598,119.00 төгрөгийн үйлчилгээний хураамжийн орлогыг төвлөрүүлсэн байна. Гэвч Сангийн сайдын 2023 оны 224 дүгээр "Улсын төсвийн байгууллагын үйл ажиллагааны давсан орлогоос зарцуулах эрх олгох тухай"	Албан шаардлага 641,959,624.00 төгрөг

			тушаал, 2024 оны 224 дүгээр "Улсын төсвийн байгууллагын үйл ажиллагааны давсан орлогоос зарцуулах эрх олгох тухай" тушаалаар эрх нээсний дагуу багаж техник хэрэгсэл, тавилга, эд хогшил, бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардал, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд нийт 641,959,624.00 төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.4.7-д "энэ хуулийн 22.10-т заасан хураамжийн 30 хүртэл хувийг цахим системийн найдвартай ажиллагаа, шинэчлэл сайжруулалт, аюулгүй байдлыг хангахад зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.	
3	Төрийн худалдан авах ажиллагааны газар	Газрын дарга Ц.Батзул	Цахим системийн үйлчилгээний хураамжийн орлогын Голомт банкин дахь 8340126100009 тоот данс нь Төрийн худалдан авах ажиллагааны газрын санхүүгийн тайланд нэгтгэгдээгүй, мөн захиалагч байгууллагуудтай цахим системийн үйлчилгээний хураамжийн орлогын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д "Энэ хуулийн 5.1.2-т заасан төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.3.1-д "төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.5-д "...бүх орлого; 14.4.6-д бүх зардал ...", Сангийн сайд, Монгол банкны Ерөнхийлөгчийн 2022 оны А122/А-172 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Засгийн газар болон төсвийн байгууллагын дансыг банканд нээх, хаах, тайлагнах журам"-ын 2.1-д "Энэ журмын үйлчлэх хүрээнд Засгийн газрын болон төсвийн байгууллагын банк дахь дараах данс хамаарна", 2.1.8-д	Албан шаардлага 844,700,00.00 төгрөг

			"Төсвийн орлого төвлөрүүлэх зориулалт бүхий тэг үлдэгдэлтэй /свифт үйлчилгээнд холбосон/ данс", 3.4-д "Банк нь Засгийн газар, улсын болон орон нутгийн төсвийн байгууллагын тухайн сарын дансны үлдэгдлийн мэдээллийг /сараар болон өдрөөр/ бүрэн гүйцэд, үнэн зөв Маягт-2, Маягт-3-ын дагуу цаасаар болон цахим хэлбэрээр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Монгол банканд дараа сарын гуравны өдрийн дотор хүргүүлнэ" гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.	
4	Төрийн худалдан авах ажиллагааны газар	Газрын дарга Ц.Батзул	Харьцуулалтын аргаар худалдан авах барааны "Цахим каталог" үүсээгүй, Худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага цахим системийн ашиглалтад дүн шинжилгээ хийж, холбогдох мэдээ, тоо баримтыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.25-д "цахим каталог" гэж бараа, ажил, үйлчилгээний мэдээллийг ангилж тодорхойлсон цахим системийн бүрэлдэхүүнийг", 34 дүгээр зүйлийн 34.12-т "Харьцуулалтын аргаар худалдан авах бараа цахим каталогт бүртгэгдсэн байна", 54 дүгээр зүйлийн 54.1-д "Худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага цахим системээр дараах бүртгэлийг хөтөлнө", 54.1.4-д "бараа, ажил, үйлчилгээний каталог", 49 дүгээр зүйлийн 49.4.9-д "Худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэгт цахим системийн ашиглалтад дүн шинжилгээ хийж, холбогдох мэдээ, тоо баримтыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх" гэсэн заалтыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.	Албан шаардлага

5	Төрийн худалдан авах ажиллагааны газар	Газрын дарга Ц.Батзул	Голомт банкин дахь 8340126100009 тоот цахим системийн үйлчилгээний орлогын дансаар 2022.01.01-2025.09.12-ны өдрийн байдлаар хайгуулын сонгон шалгаруулалтад оролцогч хуулийн этгээдээс 2,095 удаагийн гүйлгээгээр 523,700,000.00 төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн боловч зарцуулах талаар эрх зүйн зохицуулалтгүй үлдэгдэл байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-т "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.	Төлбөрийн акт 523,700,000.00 төгрөг
6	Багануур ХК	Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Т.Отгонболд	Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд гэрээний хэрэгжилт, гэрээ дууссаны дараа хүлээн авсан акт бүртгэсэн байдлыг авч үзэхэд 2024 онд 126 гэрээний хэрэгжилт, акт бүртгээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4-д "Захиалагч худалдан авах гэрээ, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг цахим системд бүртгэж, олон нийтэд нээлттэй байршуулна", Сангийн сайдын 2023 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан "Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам"-ын 2.2.8-т "худалдан авах гэрээнд орсон нэмэлт, өөрчлөлтийг цахим системд бүртгэх, гэрээний хэрэгжилт, гэрээ дууссаны дараа хүлээн авсан актыг тухай бүр цахим системд нийтлэх" гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.	Албан шаардлага
7	Багануур ХК	Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Т.Отгонболд	Тендерийн баталгааны улсын орлого бүрдүүлэлтийн төрийн сангийн 100900000753 тоот дансны 2023, 2024 оны	

		орлого бүрдүүлэлтийг Сангийн яамны Хууль зрх зүйн газрын худалдан авах ажиллагаатай холбоотой гомдол шийдвэрлэсэн байдалтай тулгалт хийж түүвэрлэн шалгахад гомдол гаргагч Виматек ХХК-иас 10,680,442.00 төгрөг, Эм ди даян ХХК-иас 1,685,000.00 төгрөг, нийт 12,365,442.00 төгрөгийн тендерийн баталгааны орлогыг улсын төсөвт дутуу төвлөрүүлсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6.3-т "санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гомдлыг бүхэлд нь үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн", мөн хуулийн 14.7-т "Энэ хуулийн 14.6.3-т заасан тохиолдолд 20 тэрбум төгрөг хүртэлх төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтад оролцогчийн тендерийн баталгааны 20 хүртэл сая төгрөгийг, 20-100 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтад оролцогчийн тендерийн баталгааны 40 сая төгрөгийг, 100 тэрбумаас дээш төгрөгийн төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтад оролцогчийн тендерийн баталгааны 60 сая төгрөгийг тус тус улсын орлого болгоно", Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/252 дугаар тушаалаар батлагдсан "Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам"-ын 2.9-т "Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага оролцогчийн гомдлыг бүхэлд нь үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн бол захиалагч тухайн тендер шалгаруулалт, түүний багцад гаргасан 20 сая төгрөг хүртэл үнийн дүнтэй тендерийн баталгааг бүхэлд нь, түүнээс дээш үнийн дүнтэй тендерийн баталгааг хуулийн 14.7-д заасан үнийн дүнд нийцүүлэн улсын орлого болгоно" гэсэн заалтуудын тус тус зөрчсөн байна.	Төлбөрийн акт 12,365,442.00 төгрөг
--	--	--	---

8	Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХХК	Гүйцэтгэх захирал Б.Чагнаадорж	Цахим системд гэрээ бүртгэсэн байдлыг авч үзэхэд 2023 онд 39 гэрээ бүртгээгүй, 2024 онд 92 гэрээ бүртгээгүй байна. 2024 онд цахим системд гэрээний хэрэгжилт, гэрээ дууссаны дараа хүлээн авсан актыг бүртгэсэн байдлыг авч үзэхэд гэрээний хэрэгжилт, акт огт бүртгээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4-т "Захиалагч худалдан авах гэрээ, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг цахим системд бүртгэж, олон нийтэд нээлттэй байршуулна", Сангийн сайдын 2023 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан "Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам"-ын 2.2.8-т "худалдан авах гэрээнд орсон нэмэлт, өөрчлөлтийг цахим системд бүртгэх, гэрээний хэрэгжилт, гэрээ дууссаны дараа хүлээн авсан актыг тухай бүр цахим системд нийтлэх", 5.5-т "Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний хувийг захиалагч цахим системд байршуулна", Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 3.9-т "Шууд худалдан авалт хийсэн захиалагч тухайн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, гэрээний үнийн дүнг цахим системд оруулсан байна" гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.	Албан шаардлага
9	Тавантолгой ХК	Гүйцэтгэх захирал Ш.Отгонбаяр	Цахим системд гэрээ бүртгэсэн байдлыг авч үзэхэд 2023 онд 13 гэрээ бүртгээгүй, 2024 онд 8 гэрээ бүртгээгүй байна. 2024 онд цахим системд гэрээний хэрэгжилт, гэрээ дууссаны дараа хүлээн авсан актыг бүртгэсэн байдлыг авч үзэхэд гэрээний хэрэгжилт, акт огт бүртгээгүй байна.	Албан шаардлага

			Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4-т "Захиалагч худалдан авах гэрээ, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг цахим системд бүртгэж, олон нийтэд нээлттэй байршуулна", Сангийн сайдын 2023 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан "Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам"-ын 2.2.8-т "худалдан авах гэрээнд орсон нэмэлт, өөрчлөлтийг цахим системд бүртгэх, гэрээний хэрэгжилт, гэрээ дууссаны дараа хүлээн авсан актыг тухай бүр цахим системд нийтлэх", 5.5-т "Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний хувийг захиалагч цахим системд байршуулна", Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 3.9-т "Шууд худалдан авалт хийсэн захиалагч тухайн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, гэрээний үнийн дүнг цахим системд оруулсан байна" заалтуудыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.	
10	Тавантолгой ХК	Гүйцэтгэх захирал Ш.Отгонбаяр	Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр ерөнхий гэрээний аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, гэрээ байгуулж, ажил гүйцэтгэсэн байна. Үүнд: 2023 онд Азура энерги ХХК-тай ТГ/2023/016 дугаартай 44,981,086.50 төгрөгийн үнийн дүнтэй, 2024 онд Бүндэр ХХК-тай ТГ/2024/103 дугаартай 1,120,000,000.00 төгрөгийн үнийн дүнтэй, Завхан Транс Нэгдэл ХХК-тай ТГ/2024/063 дугаартай 478,000,000.00 төгрөгийн үнийн дүнтэй, Ар Чавчар ХХК-тай ТГ/2024/070 дугаартай 798,088,433.06 төгрөгийн үнийн дүнтэй, Шанхай	Албан шаардлага 4,037,069,519.56 төгрөг

			Ажнай ХХК-тай ТГ/2024/073 дугаартай 798,000,000.00 төгрөгийн үнийн дүнтэй, ТГ/2024/104 дугаартай 399,000,000.00 төгрөгийн үнийн дүнтэй, ТГ/2024/050 дугаартай 399,000,000.00 төгрөгийн үнийн дүнтэй, нийт 4,037,069,519.56 төгрөгийн үнийн дүнтэй гэрээ байгуулж, ажил гүйцэтгэсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-т "Энэ хуулийн 37.2.4-т зааснаар захиалагч нь ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авна", 37 дугаар зүйлийн 37.1.2-т "хоёрдугаар үе шатанд захиалагч бараа, үйлчилгээг үнийн санал дуудаж цахим дэлгүүрээс худалдан авах.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" заалтуудыг тус тус зөрчсөн байна.	
11	Цемент шохой ХХК	Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Л.Ганбаатар	Цахим системд гэрээ бүртгэсэн байдлыг авч үзэхэд 2023 онд 118 гэрээ бүртгээгүй, 2024 онд 73 гэрээ бүртгээгүй байна. 2024 онд цахим системд гэрээний хэрэгжилт, гэрээ дууссаны дараа хүлээн авсан актыг бүртгэсэн байдлыг авч үзэхэд гэрээний хэрэгжилт, акт огт бүртгээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4-т "Захиалагч худалдан авах гэрээ, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг цахим системд бүртгэж, олон нийтэд нээлттэй байршуулна", Сангийн сайдын 2023 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан "Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам"-ын 2.2.8-т "худалдан авах гэрээнд орсон нэмэлт, өөрчлөлтийг цахим системд бүртгэх, гэрээний хэрэгжилт, гэрээ	Албан шаардлага

			дууссаны дараа хүлээн авсан актыг тухай бүр цахим системд нийтлэх", 5.5-т "Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний хувийг захиалагч цахим системд байршуулна", Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 3.9-т "Шууд худалдан авалт хийсэн захиалагч тухайн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, гэрээний үнийн дүнг цахим системд оруулсан байна" гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.	
12	Шивээ овоо ХХК	Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Г.Батсуурь	Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд гэрээний хэрэгжилт, гэрээ дууссаны дараа хүлээн авсан акт бүртгэсэн байдлыг авч үзэхэд 2024 онд 27 гэрээний хэрэгжилт, акт бүртгээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4-д "Захиалагч худалдан авах гэрээ, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг цахим системд бүртгэж, олон нийтэд нээлттэй байршуулна", Сангийн сайдын 2023 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан "Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам"-ын 2.2.8-т "худалдан авах гэрээнд орсон нэмэлт, өөрчлөлтийг цахим системд бүртгэх, гэрээний хэрэгжилт, гэрээ дууссаны дараа хүлээн авсан актыг тухай бүр цахим системд нийтлэх" гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.	Албан шаардлага
13	Эрдэнэс алт ресурс ХХК	Гүйцэтгэх захирал Э.Ууганбаяр	Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд гэрээний хэрэгжилт, гэрээ дууссаны дараа хүлээн авсан акт бүртгэсэн байдлыг авч үзэхэд 2024 онд 68 гэрээний хэрэгжилт, акт бүртгээгүй байна.	

			Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4-д "Захиалагч худалдан авах гэрээ, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг цахим системд бүртгэж, олон нийтэд нээлттэй байршуулна", Сангийн сайдын 2023 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан "Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам"-ын 2.2.8-т "худалдан авах гэрээнд орсон нэмэлт, өөрчлөлтийг цахим системд бүртгэх, гэрээний хэрэгжилт, гэрээ дууссаны дараа хүлээн авсан актыг тухай бүр цахим системд нийтлэх" гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.	
14	Эрдэнэс баянбогд ХХК	Гүйцэтгэх захирал Ц.Орхонтамир	Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд гэрээ бүртгэсэн байдлыг авч үзэхэд 2023 онд 1 гэрээ бүртгээгүй, гэрээний хэрэгжилт, гэрээ дууссаны дараа хүлээн авсан акт бүртгэсэн байдлыг авч үзэхэд 2024 онд 2 гэрээний хэрэгжилт, акт бүртгээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4-т "Захиалагч худалдан авах гэрээ, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг цахим системд бүртгэж, олон нийтэд нээлттэй байршуулна", Сангийн сайдын 2023 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан "Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам"-ын 2.2.8-т "худалдан авах гэрээнд орсон нэмэлт, өөрчлөлтийг цахим системд бүртгэх, гэрээний хэрэгжилт, гэрээ дууссаны дараа хүлээн авсан актыг тухай бүр цахим системд нийтлэх", 5.5-т "Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний хувийг захиалагч цахим системд байршуулна", Сангийн сайдын 2023 оны А/250	Албан шаардлага

			дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 3.9-т "Шууд худалдан авалт хийсэн захиалагч тухайн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, гэрээний үнийн дүнг цахим системд оруулсан байна" гэсэн заалтуудыг тус тус бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.	
15	Эрдэнэс Монгол ХХК	Гүйцэтгэх захирал С.Наранцогт	Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд гэрээний хэрэгжилт, гэрээ дууссаны дараа хүлээн авсан акт бүртгэсэн байдлыг авч үзэхэд 2024 онд 19 гэрээний хэрэгжилт, акт бүртгээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4-д "Захиалагч худалдан авах гэрээ, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг цахим системд бүртгэж, олон нийтэд нээлттэй байршуулна", Сангийн сайдын 2023 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан "Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам"-ын 2.2.8-т "худалдан авах гэрээнд орсон нэмэлт, өөрчлөлтийг цахим системд бүртгэх, гэрээний хэрэгжилт, гэрээ дууссаны дараа хүлээн авсан актыг тухай бүр цахим системд нийтлэх" гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.	Албан шаардлага
16	Эрдэнэс критикал минералс ТӨҮГ	Захирал Д.Тогтохсүрэн	Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд гэрээний хэрэгжилт, гэрээ дууссаны дараа хүлээн авсан акт бүртгэсэн байдлыг авч үзэхэд 2024 онд 162 гэрээний хэрэгжилт, акт бүртгээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4-д "Захиалагч худалдан авах гэрээ, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг цахим системд бүртгэж, олон нийтэд нээлттэй байршуулна", Сангийн сайдын	Албан шаардлага

			2023 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан "Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам"-ын 2.2.8-т "худалдан авах гэрээнд орсон нэмэлт, өөрчлөлтийг цахим системд бүртгэх, гэрээний хэрэгжилт, гэрээ дууссаны дараа хүлээн авсан актыг тухай бүр цахим системд нийтлэх" гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.	
17	Эрдэнэс оюу толгой ХХК	Гүйцэтгэх захирлын үүргийг Түр орлон гүйцэтгэгч Э.Ганхуу	Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд гэрээний хэрэгжилт, гэрээ дууссаны дараа хүлээн авсан акт бүртгэсэн байдлыг авч үзэхэд 2024 онд 7 гэрээний хэрэгжилт, акт бүртгээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4-д "Захиалагч худалдан авах гэрээ, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг цахим системд бүртгэж, олон нийтэд нээлттэй байршуулна", Сангийн сайдын 2023 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан "Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам"-ын 2.2.8-т "худалдан авах гэрээнд орсон нэмэлт, өөрчлөлтийг цахим системд бүртгэх, гэрээний хэрэгжилт, гэрээ дууссаны дараа хүлээн авсан актыг тухай бүр цахим системд нийтлэх" гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.	Албан шаардлага
18	Эрдэнэс Тавантолгой ХК	Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Н.Цэрэнсамбуу	Цахим системд гэрээ бүртгэсэн байдлыг авч үзэхэд 2023 онд 24 гэрээ бүртгээгүй, 2024 онд 80 гэрээ бүртгээгүй байна. 2024 онд цахим системд гэрээний хэрэгжилт, гэрээ дууссаны дараа хүлээн авсан акт бүртгэсэн байдлыг авч үзэхэд гэрээний хэрэгжилт, акт огт бүртгээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4-т "Захиалагч худалдан авах гэрээ, түүнд оруулах нэмэлт,	Албан шаардлага

			өөрчлөлтийг цахим системд бүртгэж, олон нийтэд нээлттэй байршуулна", Сангийн сайдын 2023 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан "Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам"-ын 2.2.8-т "худалдан авах гэрээнд орсон нэмэлт, өөрчлөлтийг цахим системд бүртгэх, гэрээний хэрэгжилт, гэрээ дууссаны дараа хүлээн авсан актыг тухай бүр цахим системд нийтлэх", 5.5-т "Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний хувийг захиалагч цахим системд байршуулна", Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 3.9-т "Шууд худалдан авалт хийсэн захиалагч тухайн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, гэрээний үнийн дүнг цахим системд оруулсан байна" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	
19	Эрдэнэс Тавантолгой ХК	Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Н.Цэрэнсамбуу	Тендерийн баталгааны улсын орлого бүрдүүлэлтийн төрийн сангийн 100900000753 тоот дансны 2023, 2024 оны орлого бүрдүүлэлтийг Сангийн яамны Хууль эрх зүйн газрын худалдан авах ажиллагаатай холбоотой гомдол шийдвэрлэсэн байдалтай тулгалт хийж түүвэрлэн шалгахад Эрдэнэс Тавантолгой ХК-ийн тендерт гомдол гаргагч "Бодь даатгал ХК"-иас 11,361,870.00 төгрөг, "Евро хан" ХХК-иас 16,815,580.00 төгрөг, "Эмералд сийд" ХХК-иас 509,250.00 төгрөг нийт 28,686,700.00 төгрөгийн тендерийн баталгааны орлогыг улсын төсөвт дутуу төвлөрүүлсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6.3-т "санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв	Төлбөрийн акт 28,686,700.00 төгрөг

			байгууллага гомдлыг бүхэлд нь үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн", мөн хуулийн 14.7-т "Энэ хуулийн 14.6.3-т заасан тохиолдолд 20 тэрбум төгрөг хүртэлх төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтад оролцогчийн тендерийн баталгааны 20 хүртэл сая төгрөгийг, 20-100 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтад оролцогчийн тендерийн баталгааны 40 сая төгрөгийг, 100 тэрбумаас дээш төгрөгийн төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтад оролцогчийн тендерийн баталгааны 60 сая төгрөгийг тус тус улсын орлого болгоно", Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/252 дугаар тушаалаар батлагдсан "Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам"-ын 2.9-т "Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага оролцогчийн гомдлыг бүхэлд нь үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн бол захиалагч тухайн тендер шалгаруулалт, түүний багцад гаргасан 20 сая төгрөг хүртэл үнийн дүнтэй тендерийн баталгааг бүхэлд нь, түүнээс дээш үнийн дүнтэй тендерийн баталгааг хуулийн 14.7-д заасан үнийн дүнд нийцүүлэн улсын орлого болгоно" гэсэн заалтуудын тус тус зөрчсөн байна.	
20	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	Ерөнхий захирал Г.Ёндон	Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд гэрээний хэрэгжилт, гэрээ дууссаны дараа хүлээн авсан акт бүртгэсэн байдлыг авч үзэхэд 2024 онд 890 гэрээний хэрэгжилт, акт бүртгээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4-д "Захиалагч худалдан авах гэрээ, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг цахим системд бүртгэж, олон нийтэд нээлттэй байршуулна", Сангийн сайдын 2023 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан "Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах,	Албан шаардлага
			түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам"-ын 2.2.8-т "худалдан авах гэрээнд орсон нэмэлт, өөрчлөлтийг цахим системд бүртгэх, гэрээний хэрэгжилт, гэрээ дууссаны дараа хүлээн авсан актыг тухай бүр цахим системд нийтлэх" гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.	